| 114 | 2.5.1. Хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, шинэ ажлын байр бий болгоно. | 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | 2021 - 2024 | 424 140 | | 3663 600 | "Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2024 онд 647 иргэнийг төсөлт хөтөлбөрт хамруулж, ХЭДСангаас 407,068,389 төгрөгийг зарцуулж, 136шинэ ажлын байр, 2022 онд 1645 иргэнийг хамруулж, ХЭДСангаас 1,202,285,655 төгрөгийг зарцуулан 283 шинэ ажлын байрыг тус тус бий болгосон байна.  2023 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөр бэлтгэх үйл ажиллагаанд 439 иргэнийг, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг 1395 иргэнийг, санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 157 иргэнийг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 111 иргэнийг, түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаанд 448 иргэнийг тус тус хамруулж, ХЭДСангаас 1,248,228,521 төгрөгийг зарцуулсан байна. 2024 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлчилгээ арга хэмжээнд нийт 5364 иргэнийг хамруулж 5.809.9 сая төгрөг зарцуулсан. Үүнд санхүүгийн дэмжлэгт 235 иргэн хамрагдаж 5.098.0 сая төгрөг олгож шинээр 181 ажлын байр бий болсон. нийтийг хамарсан ажилд 1948 иргэн түр ажлын байраар хангагдсан. Тус онд хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан Ejob системд 3345 шинэ ажлын байрны мэдээллийг бүртгэн мэдээлсэн. Үүнд: уул уурхайн салбарт 164, санхүүгийн дэмжлэгт 188, малжуулах арга хэмжээнд 1014, түр ажлын байранд 1948 , бусад эх үүсвэрээр 31 шинэ ажлын байр бий болсон байна. Нийт ажлын байрны 63,2 хувь буюу 1397 нь байнгын ажлын байр бий болсон байна. " | |
| 115 | | 2. “Малчны залуу халаа” хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлэх | 2022 - 2024 | 0 | | | ХЭДСангаас хэрэгжүүлж буй Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 2022, 2023 онд тус бүр 13 сумын 70 малчин өрхийг хамруулж, нийт 140 малчин өрхөд 6761 тоо малыг хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Малжуулах хөтөлбөрт хамрагдаж буй өрхүүдийг жил бүр аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулж байна. 2024 онд улсын хэмжээнд зуд бол мал ихээр хорогдсон тул малжуулах арга хэмжээнд 507 малчин өрх хамрагдаж 1014 ажлын байр бий болсон. Мөн сэг зэм устгах ажилд 1777 малчид ажиллаж 430.0 сая төгрөгийн урамшуулал авсан байна | 70% / 50%<br><br>2023-2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. “Малчны залуу халаа” хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй. |
| 116 | | 3. Гарааны бизнес буюу старт-аппыг дэмжиж, хөгжүүлэн | 2021 - 2024 | 15 | | 52 | Хөдөлмөр эрхлэлт, аж ахуй эрхлэх бүтээлч шинэлэг санаа, санаачлагуудыг шалгаруулах шилдэг “СТАРТ-АП” сургалтыг жил бүр зохион байгуулж, шилдгээр шалгарсан төсөл санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион | 100% / 30%<br><br>Хэрэгжүүлсэн төслийн тоо зорилтод |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажлын байрыг бий болгох | | | | | байгуулж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан төсвийн дагуу жил бүр 1 төслийг шалгаруулж буй бөгөөд 2021 онд ."Евро хашаа" 2022 онд орчин үеийн шийдэлтэй "Мини кино театр", 2023 онд "Зөөврийн орон сууц" төсөл шалгарч, тус бүр 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан байна. Уг арга хэмжээний хүрээнд нийт 8 ажлын байр шинээр бий болсон байна. | түвшинд хүрээгүй. Тодорхойлсон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин ойлгомжгүй. Хэрэгжилт хангалтгүй. |
| 117 | | 4. Орон нутгийн хэрэгцээнд тулгуурласан мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх арга хэмжээг зохион байгуулах | 2021 - 2024 | 50 0 | | 230 8 | 2021-2022 онд зохион байгуулагдсан Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн орон нутагт мэргэжлийн сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. ХХҮЕГазраас сургалтын эрх авсан байгууллагатай хамтран 2021 онд үсчин мэргэжлээр 37 иргэнийг, 2022 онд оёдол эсгүүр, авто засвар, гар урлал мэргэжлээр 63 иргэнийг тус тус мэргэжил олгох сургалтад хамруулсан байна. 2023 онд аж ахуй нэгжээс ирүүлсэн захиалгын дагуу мэргэжил олгох танхимын сургалтыг “Мэргэшсэн мэргэжил” ТББ-тай хамтран “Хүнд машин механизмын операторч” бэлтгэх чиглэлээр зохион байгуулж 24 иргэнийг, эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадвар олгох танхим, цахим хосолсон сургалтыг "Дарь овоо" ТББ байгууллагатай хамтран зохион байгуулж тогооч мэргэжлээр 18 иргэнийг тус тус хамруулав. Мөн Мэргэшсэн мэргэжил сургалтын төвтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй 10 иргэнд зориулан няравын мэргэжил олгох сургалтыг 30 хоногийн хугацаанд танхимаар зохион байгууллаа. Тайлант хугацаанд (2021-2023) мэргэжил олгох сургалтад нийт 152 иргэнийг хамруулсан байна. | 100% / 50%<br><br>2024 оны зорилтод түвшинд хүрээгүй.Өмнөх арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан. Журмын 6.2.2.3-р үнэлэв. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2024 онд Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, аж ахуй эрхлэх бүтээлч шинэлэг санаа, санаачилгуудыг шалгаруулах шилдэг “СТАРТ-АП” 3 өдрийн сургалтыг “Баялаг бүтээгч монгол хүн” ТББайгууллагатай хамтран зохион байгуулж сургалтад 15-34 насны 30 залуучууд оролцсон. Таван долоо хоногийн бизнес хурдасгуур арга хэмжээнд 4 багийн залуучууд өрсөлдсөнөөс Мөнххаан сум Э.Хүрэлсүх “ 47 сошиал медиа маркетинг” төсөл шалгарч 10,0 сая төгрөгийн эргэн төлөгдөхгүй санхүүгийн дэмжлэг авсан байна. | |
| 118 | | 5. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | 4 | | 22 | Халамжаас хөдөлмөрт арга хэмжээний хүрээнд нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2022 онд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн 956 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулсан ба 178 иргэн байнгын ажлын байранд зуучлагдсан байна. Мөн уг арга хэмжээний хүрээнд 2023 онд "Автобустай аялал", "Түншлэл-2023", "Ажил олгогч-Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн" зэрэг 4 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 189 иргэнийг хамруулж, 8 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан байна.<br>2024 онд Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтад болон ганцаарчилсэн зөвлөгөөг ЕБС, МБС 740 сурагчид зохион байгуулсан. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ХХҮГ-аас “Монголын удирдлага шинэчлэл менежментийн | 90% / 39.87%<br><br>Зорилтод түвшигд хүрээгүй. Сургалт, нөлөөллийн ажлын тоог тодорхой тайлагнаагүй. Журам-ын 6.2.1-ээр үнэлэв. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | академи” сургалтын байгууллагатай хамтран “Гоо сайхан, маникюр”-ийн сургалтыг 21 хоногийн сургалтад 18 эмэгтэй, Талх нарийн боов үйлдвэрлэлийн сургалтад 27 ,цахилгаанчины сургалтад 19 иргэн тус тус хамрагдаж чадамжийн гэрчилгээтэй болсон. | |
| 119 | | 6. Ажлын байрыг бий болгох, хадгалахад чиглэсэн хөнгөлөлттэй зээлийг иргэд , аж ахуйн нэгжид олгох | 2021 - 2024 | 3 | | 50 | Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр ХЭДСангаас олгодог жижиг зээлийг 2023 оноос эхлэн төрийн банкаар дамжуулан олгож эхлээд байна. Тайлант хугацаанд жижиг зээлд 87 иргэн төсөл ирүүлснээс 4 иргэн, 4 аж ахуйн нэгжид 420.0 сая төгрөгийн зээл олгож 49 ажлын байр шинээр бий болсон байна. Ковид-19 цар тахал, санхүүгийн бусад шалтгааны улмаас урьд жилүүдэд ХЭДСангаас жижиг зээл олгогдоогүй хэдий ч Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд Ажлын байр дэмжих 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай зээлийг арилжааны банкаар 338 иргэн, аж ахуйн нэгжид 18.1 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. 2024 он Төрийн банкаар дамжуулан 2023 онд олгосон жижиг зээлийн эргэн төлөлтөөс 1 аж ахуйн нэгжид 50.0 сая, 5 иргэнд тус бүр 10.0 сая нийт 100.0 сая, Олон улсын хөгжлийн Ассоциацийн санхүүжилтээр банкаар олгох жижиг зээлд улсын хэмжээнд 13.0 тэр бум төгрөгийг жилийн 6.0% хүүтэй олгохоос тус аймаг 43 иргэнд 836.0 сая төгрөгийн зээл олгоод байна. Жижиг зээлээр 80 ажлын байр шинээр бий болсон. | 90% / 70.5%<br><br>Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. Журам-ын 6.2.1-ээр үнэлэв. |
| 120 | | 7. Шинэ сэргэлтийн | 2023 - 2024 | 0 | - | Тийм-1,70% -2 - аас дээш | Хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд шилжин суурьших иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих, | 70% / 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бодлогын “Хот, хөдөөгийн сэргэлт” зорилтын хүрээнд “Нээлттэй Сүхбаатар аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | | | | | | татах чиглэлээр Нээлттэй Сүхбаатар хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын тогтоолоор батлуулж уг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн ЗД-ын 2023 оны 3 сарын 21-ны өдрийн А/122 тоот захирамжаар батлагдсан. Энэхүү төлөвлөгөө нь 5 зорилтын хүрээнд хэрэгжих нийт 35 арга хэмжээг багтаасан бөгөөд ажлууд төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна. Энэ хүрээнд Сүхбаатар аймаг хөгжилд хамтдаа хөрөнгө оруулагчдын чуулганыг 2023 оны 5 сард Баруун урт хотноо зохион байгуулж төрийн болон хувийн хэвшлийн 200 хүн оролцлоо. Нийт 6 хувийн хэвшилтэй хөрөнгө оруулалтын санамж бичиг байгуулсан бодит үр дүн гарав.2023 оны 11 сард Сүхбаатарын Оюутнууд арга хэмжээг УБ хотноо зохион байгуулж 400 гаруй нутгийн оюутнуудыг оролцуулсан 1 өдрийн арга хэмжээ зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээ бүр дээр зорилтод иргэд болон аж ахуйн нэгжид чиглэсэн видео танилцуулга, шторкууд бэлтгэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр арга хэмжээ болохоос 7 хоногий өмнө цацаж, арга хэмжээний талаар мэдээлийг фэйж хуудас болон ТВ, сайтуудаар мэдээлж ажилласан. Орон нутагт эрэлттэй мэргэжлийн судалгаа гаргаж, төрийн албанд нэн шаардлагатай байгаа албан тушаалын жагсаалтыг гаргаж нийтэд тогтмол мэдээлж байна. Дорноговийн сувилагчийн сургуультай хамтран ажиллаж, орон нутагт ажиллахаар шилжин ирсэн 2 сувилагч 2 багшид орон сууцны урьдчилгаанд дэмжлэг үзүүлж батламж гардуулав. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулсны хүрээнд журам боловсруулж батлуулан энэ хүрээнд хэрхэн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дэмжлэг үзүүлэх бодлого чиглэлээ залууст танилцуулж байна. | |
| 121 | 2.5.2. Орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлнэ. | 1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг аймгийн хэмжээнд зохион байгуулах | 2021 | 0 | | | Швейцарын хөгжлийн агентлагийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлтэй хамтран аймгийн хэмжээнд анх удаа хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлох судалгааг зохион байгууллаа. Тус судалгаанд 400 гаруй аж ахуйн нэгж байгууллага, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэд, ажил эрхэлж буй залуучууд зэрэг 4000 гаруй иргэдийг хамруулсан ба судалгааны үр дүнд үндэслэн ойрын 3 жилийн аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн дүр зургийг урьдчилан тооцож, гарын авлагыг нэгтгэн боловсруулан, холбогдох талуудад хүргүүлж, бодлого, хөтөлбөрт тусгуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулж байна. | 100% / 100% |
| 122 | 2.5.2. Орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлнэ. | 2. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн багш нарыг мэргэшүүлэх, туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулах | 2021 - 2024 | 0 | | 10 | "Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь үйлдвэрлэлийн дадлага болон үйлдвэр сургалтын дадлагын хичээлийг Талын баян-Эрхэт ХХК, ""Хабу Хасу"" ХХК, ""Шарга"" ХХК, ""Хайлааст гарам"" ХХК, ""Энгэр бүрд"" ХХК, ""Оргих"" ХХК, ""Молцог элс"" ХХК, ""Их Модун"" ХХК, ""Aadar craft"" ХХК, ""Ханан салхит"" ХХК-ууд дээр зохион байгуулснаар сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг ажиллуулах болон орчин үеийн барилга барих аргачлал, шинээр гарч ирж буй барилгын материалуудыг таньж мэдэн ашиглах гэх мэт сургалтаа цаг үедээ тохируулан зохион байгуулж байна. Тэрбум модны үндэсний хөтөлбөртэй хөтөлбөртэй холбогдуулан МСҮТөвд ойжуулагчийн ангийг шинээр нээсэнтэй холбогдуулан боловсон хүчинг бэлтгэх зорилгоор ХААИС-ийн | 90% / 70%<br><br>2024 оны хэрэгжилт тайлагнаагүй, 2023 оны хэрэгжилтийг хуулбарлан тайлагнасан. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. журам"-ын 6.2.2.2-ыг үндэслэв. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Агроэкологийн сургуулийн Ойн инженерийн ангид  орон нутаас сургалтын төлбөр 100% аар дааж суралцуулж  байна " | |
| 12 3 | | 3. “Ажилтай төгсөгч” хөтөлбөрийг хэрэгжүүлж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 67.5 | | 80 | МСҮТ-ийн 94 төгсөгчдийг “Түншлэл- 2023”, “Ажлын гараа– Автобустай аялал ” арга хэмжээнд хамруулж Цайртминериал” ХХК, “Эм Эл Цахирт овоо” ХХК, “Дарь-Шүтээн” ХХК зэрэг томоохон аж ахуй нэгжийн үйл ажиллагаатай танилцуулав. 2023 оны 03-р улирлын байдлаар МСҮТ-ийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь 60 хувь байна.<br>2024 МБС байгууллагын төгсөх ангийн 12 сурагчийг  "Их модун"  ХХК дагалдуулан суралцуулж 2 сарын цалин болох 3.8 сая төгрөгийг ажил олгогчид олгоод байна. Үүний үр дүнд төгсөгчид байнгын ажлын байртай болно. | 70% / 50%<br><br>Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. 2024 онд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг хувиар тайлагнаагүй. Журмын 6.2.2.3-ын дагуу үнэлэв. |
| 12 4 | | 4. Хөдөлмөрийн зах зээлийн төлөвтэй уялдуулан мэргэжлийн ангийн чиглэлийг оновчтой болгох | 2021 - 2024 | 0 | | - 100 | "2021-2022 онд зохион байгуулагдсан Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны үр дүн, ажил олгогчдын эрэлт хэрэгцээ, орон нутагт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилтай уялдуулан Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвд 2022-2023 оны хичээлийн жилд шинээр ойжуулалтын ангийг нээж, элсэлт авсан ба төмөр замын мэргэжлээр 2021 оноос жил бүр элсэлт авч байна. " | 90% / 70%<br><br>Тодорхойлсон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин ойлгомжгүй. 2024 онд хийгдсэн ажил тодорхойгүй, тайлан 2023 оны хэрэгжилтийг хуулбарласан. Журам-ын 6.2.2.2-р үнэлэв. |
| 12 | 2.5.3. | 1. Хөдөлмөр, | 2021 - | 1 70 | | | Аймгийн Засаг дарга, Үйлдвэрчний эвлэлийн | 90% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчин, нөхцөлийг сайжруулна. | нийгмийн зөвшлийн 3 талт хэлэлцээрийг 2 жил тутам зохион байгуулж, хэрэгжилтийг хангах | 2024 | | | | холбоо болон ажил олгоч эздийн холбооны дарга, тэдгээрийн бүрэн эрх төлөөлөгчид хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2022-2023 оны хэлэлцээрийг байгуулж, аймгийн ХХҮГазарт 2022 оны 02-р сард бүртгүүлэн, баталгаажуулж хэрэгжилтийг хангах ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг орон нутагт хангах, Засгийн газрын “Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2013 оны 370 дугаар тогтоол, аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2022-2023 оны гурван талт хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны 07, 08 тоот албан даалгаврыг сум, агентлагт хүргүүллээ. 2023 оны 4-р сард аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талын ажлын хэсэг Түмэнцогт, Сүхбаатар сумдад уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 4 аж ахуйн нэгж байгууллагад цалин хөлсний үзлэг, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж, 215 албан хаагчдын хөдөлмөрийн нөхцөл, гэрээтэй танилцаж, холбогдох зөвлөмж, чиглэлийг өгч, ажиллав. Мөн аймгийн Засаг даргын баталсан удирдамж чиглэлийн дагуу хөдөлмөр, нийгмийн зөвшлийн ажлын хэсэг 2023 оны 05-р сард Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр сумдад ажиллаж, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, бусад бодлого, шийдвэрийн хэрэгжилттэй танилцсан. | 2022-2024 оны хүрэх түвшин тодорхойлоогүй. Хэлэлцээрийн хэрэгжилтийн хувийг тайлагнаагүй. |
| 126 | | 2. ХАБЭА-н орчин бүрдүүлсэн | 2021 - 2024 | 2 | | 11 | Аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлөөс "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг эрхэмлэгч байгууллага" | 90% / 50%<br><br>2023-2024 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ААН-ийг урамшуулах | | | | | шалгаруулах удирдамжийг боловсруулан сум, байгууллагуудад хүргүүлж, 2022 оноос эхлэн аймгийн хэмжээнд дүгнэн, Дөрвөлж ОНӨААТҮГ, Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэг, Наран сумын хүүхдийн цэцэрлэгийг тус тус шагнаж, урамшуулаад байна. 2023 онд санаачлагатай ажилласан ААНБ-ыг шалгаруулж, урамшуулах арга хэмжээг удирдамжийн дагуу 12-р сард зохион байгуулна. 2024 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 14 байгууллагын 873 ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулж зөвлөгөө өгч ажилласан. Хөдөлмөрийн хууль, ХАБЭА-н хуулийн улсын үзлэгийн хүрээнд байгууллагуудад хуулийн хэрэгжилтийг үзэж зөвлөгөө өгч ажилласан. | онуудад Урамшуулсан байгууллагын тоог дурьдаагүй. Тайлагнал хангалтгүй. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. |
| 127 | | 3. Цалин хөлс, ХАБЭА-н талаарх Засаг даргын нэрэмжит сарын аян, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулах | 2021 - 2024 | 1 | | 1 | Аймгийн Засаг даргын нэрэмжит ХАБЭА-н сарын аяны арга хэмжээг 2021 онд ““ Хямралын урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулья-ХАБЭА-н тогтолцоог бэхжүүлье” уриан дор, 2022 онд “Аюулгүй байдал, эрүүл мэндийн соёлыг хамтдаа төлөвшүүлье" уриан дор, 2023 онд "Эрүүл аюулгүй ажил-Бидний суурь эрх" " уриан дор тус тус зохион байгуулж, хууль тогтоомжийн хэрэгжитийг хангах, ажил олгогч, албан хаагчдын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийн хуулийн улсын үзлэгийг 2021 онд эрчим хүчний салбарт, 2022 онд эрүүл мэндийн салбарт, 2023 онд мэргэжлийн боловсролын салбарт тус тус зохион байгуулж, холбогдох зөвлөмж чиглэлийг | 100% / 75%<br><br>2024 оны хэрэгжилт тайлагнаагүй. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүргүүлэв. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд жил бүр 9-11 нөлөөллийн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажилласан ба тайлант хугацаанд давхардсан тоогоор 2200 гаруй албан хаагчийг сургалтад хамруулсан байна. | |
| 128 | 2.5.4. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй олгоно. | 1. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах ажлыг үе шаттай зохион байгуулах | 2021 - 2024 | 6 | | 26 13660 | Нийгмийн халамжийн тэтгэмж, ахмад настны хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, хүүхдийн мөнгөн тэтгэмж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж зэрэг үйлчилгээнүүд 2022 онд Ehalamj.mn цахим системд шилжсэн ба 2023 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс ахмадын зориулалттай амралт сувиллын эрхийн бичиг олгох үйлчилгээ цахимд шилжсэн . Нийгмийн халамжийн үйлчилгээ Ehalamj.mn нэгдсэн системд шилжсэнээр иргэд хүсэлтээ цахимаар илгээхээс гадна халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийн олголтыг сар бүр цахимаар хянах боломжтой болсон. Ehalamj.mn системээр нийт 180 иргэн цахимаар хүсэлтээ гаргаж, халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтөд үйлчилгээнд 25590 иргэн хамрагдсан байна. | 100% / 70%<br><br>Цахимд шилжсэн үйлчилгээний тоог тодорхой тайлагнах. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. |
| 129 | 2.5.5. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, аймгийн хэмжээнд татварт бүртгэлтэй | 1. Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тэдгээрийг дагалдан гарах журам, дүрмийг иргэдэд | 2021 - 2024 | 4 - | | 12 | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, төрийн албан хаагчид, ажил олгогчдын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлын тогтмол зохион байгуулж байна. 2023 онд нийгмийн хамгааллын салбарын албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх чиглэсэн 24 удаагийн сургалтыг зохион байгуулсан ба ажил олгогч, иргэдэд | 100% / 75%<br><br>2024 оны хэрэгжилт тайлагнаагүй. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажил олгогчийн 98, эдийн засгийн идэвхтэй хүн амын 50 хувийг нийгмийн даатгалд, нийт хүн амын 98 хувийг эрүүл мэндийн даатгалд хамруулна. | сурталчлах, сургалт сурталчилгааг сайжруулах | | | | | чиглэсэн 60 сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 3381 иргэд /даатгуулагч/-ийг хамруулсан байна. Мөн цахимаар нийт 587 удаагийн давтамжтай лайв, постер, шторк, мэдээ, мэдээллийг түгээхэд 389719 хандалт авсан үзүүлэлттэй байна. Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтэй холбогдуулан шинэчлэн боловсруулж буй хуулийн хэлэлцүүлэгийг орон нутагт 2 удаа зохион байгуулсан ба 2023.оны 10-р сард Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулгыг хийж 366 аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл, иргэд даатгуулагчид хамрагдсан байна. 2023 оны 10-р сарын байдлаар татварт бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа 806 ажил олгогчоос 794 ажил олгогчийг хамруулж биелэлт 98,5%. -Эдийн засгийн идэвхтэй хүн ам 28249 байгаагаас Нийгмийн даатгалд 15488 хүн хамруулж биелэлт 54.8% байна. -ЭМД-д албан журмаар даатгуулагч-11,143 иргэн өөрөө хариуцан төлөгч -7,315 иргэн төр хариуцах-45,945 иргэн нийт 64,403 иргэн хамруулж гүйцэтгэл нь 99%-тай биелсэн байна. | хүрээгүй. |
| 130 | | 2. Цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 70 10 | | | "1.Даатгуулагчид зориулсан https://daatguulagch.ndaatgal.mn веб программын тусламжтайгаар нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэж байна.1. Цахимаар аймаг, дүүрэг, сум хооронд авсан лавлагаа – 245 2. Сайн дурын гэрээг цахимаар байгуулсан хүний тоо – 3453 3. Цахимаар хүсэлт ирж хянасан ажилгүйдлийн тэтгэмжийн тоо – 3 4. Цахимаар хүсэлт ирж хянасан жирэмсэн амаржсаны тэтгэмжийн тоо - 1775 5. Цахимаар хүсэлт | 100% / 50%<br><br>2024 оны хэрэгжилт тайлагнаагүй. Тодорхойлсон хүрэх түвшний дагуу тайлагнах. Төлөвлөлт буруу. Журмын 6.2.2.3 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ирж хянасан хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн тоо - 1812 6. Цахимаар тайлан илгээж хянасан байгууллагын тоо – 680 /сар бүр/ 2023 онд Үйлчлүүлэгчийн үнэлгээний КИОСК систем/ХНХЯам/ - Нийт үйлчилгээ авсан хүний тоо – 8011 - Үзүүлсэн үйлчилгээний тоо – 9374 - Үнэлгээ өгсөн иргэдийн тоо – 1966 - Үнэлгээний дундаж – 4,8 - QR кодоор үнэлгээ өгсөн хүний тоо – 157 - QR кодоор өгсөн үнэлгэний дундаж – 4,9 Сүхбаатар аймгийн НДХэлтэс нь салбарын хэмжээнд ХНХЯамны КИОСК системийн үнэлгээний системийн хэрэгжилтээр 3-р байранд явж байна. " | үнэлэв. |
| 131 | | 3. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын нөхөн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | | | "Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын нөхөн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдт/даатгуулагч/-д 62 удаагий сургалт зохион байгуулж 1623 хүн хамрагдсан ба Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс" пэйж хуудсанд өөрсдийн бэлтгэсэн болон дээд газрын боловсруулсан мэдээ мэдээлэл, постер, бичлэг, зар зэрэг нийт 40 мэдээлэл оруулж 26230 хүн хүрсэн байна. Мөн Судалгаагаар аймгийн хэмжээнд хамрагдвал зохих малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч 5500 байгааг тодорхойлон сум бүрээр хамралтын төлөвлөгөө гарган 980 малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч хамруулахаас нийтдээ 1300 иргэн хамрагдсан байна. Үүнээс 2020-2021 онд 203, 2022-2023 онуудад 231, нийт 434 иргэн малчнаар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон " | 100% / 90%<br><br>2023-2024 оны Хүрэх түвшин тодорхойлоогүй. |
| 132 | 2.5.6. Өрхийн амьжиргааны | 1. Зорилтот өрхийн хөгжил, | 2021 - 2024 | 110 | | 600 | Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд тусламж | 90% / 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | түвшнийг дээшлүүлэх арга хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ. | хамгааллыг сайжруулах дэд хөтөлбөрийн хүрээнд өрхийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх | | | | | дэмжлэг үзүүлэх арга хэмжээг сумдын Засаг даргын тамгын газар, холбогдох байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлж байна. Уг арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд 127 өрх, иргэнд, 2022 онд 241 өрх, иргэнд, 2023 онд 208 өрх, 2024 онд 180 иргэнд тус тус дэмжлэг туслалцаа үзүүлсэн байна. | Арга хэмжээний хэрэгжилтийг Амьжиргааны түвшин дээшилсэн өрхийн тоогоор гаргаагүй дэмжлэг үзүүлсэн өрх, иргэний тоогоор тайлагнасан. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. Журам-ын 6.2.2.3-аар үнэлэв. |
| 133 | | 2. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах | 2021 - 2024 | 47 | | | Халамжаас хөдөлмөрт арга хэмжээний хүрээнд нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2022 онд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн 956 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулсан ба 178 иргэн байнгын ажлын байранд зуучлагдсан байна. Мөн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсөлд 126 иргэн, мэргэжил олгох болон бусад сургалтуудад 328 иргэнийг тус тус хамруулсан байна. 2024 онд зорилтот өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, ажилгүй 87 иргэнийг байнгын ажилд, 260 иргэнийг түр | 90% / 90%<br><br>2022-2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажлын байранд зуучилж, мэргэжил олгох, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх сургалтад 138 иргэнийг тус тус хамруулав. Халамжаас-Хөдөлмөрт арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд 7 сум хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг өрхгүй болсон. | |
| 134 | 2.5.7. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлж, нөлөөллийн ажлын нэр төрлийг нэмэгдүүлнэ. | 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2023 | 100 | | 400 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, төрийн албан хаагчдын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг агентлаг, төсөвт байгууллага, сумдын ЗДТГазар, Мерит төсөлтэй хамтран зохион байгуулж байна. Төрийн албан хаагчдын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр 2021-2023 онд давхардсан тоогоор 2500 гаруй төрийн албан хаагчдыг цахим болон танхимын сургалтад хамруулаад байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, нийгмийн үр шимээс хүртэж буй эрэгтэй, эмэгтэй хүний зөрүүтэй байдлыг бууруулахад чиглэсэн 11 бичил төслийг Мерит төсөл, удирдлагын академитай хамтран хэрэгжүүллээ. 2022 оны 10-р сард Жендэрийн үндэсний хороо, Хүний эрхийн үндэсний комиссын ажлын хэсэг орон нутагт ажиллаж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн, орон нутагт хийгдэж буй бодлого арга хэмжээтэй танилцан, холбогдох зөвлөмж, чиглэлийг өгөв. | 100% / 70%<br><br>2024 оны хэрэгжилт тодорхойгүй. Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг уялдуулж тайлагнах. Журмын 6.2.2.2-р үнэлэв. |
| 135 | | 2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран | 2021 - 2024 | 2 | | 10 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Үжин төв, аймгийн Залуучуудын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, Ахмадын холбоо зэрэг иргэний нийгмийн байгууллалага, Мерит олон улсын төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллаж байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасны дагуу Жендэрийн | 90% / 70%<br><br>2024 оны хэрэгжилт тодорхойгүй. Шалгуур үзүүлэлт, зорилтот |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллах | | | | | эрх тэгш байдлыг хангах зарим арга хэмжээг иргэний нийгмийн байгууллагатай хамтран гүйцэтгэхээр харилцан санал солилцож байна. | түвшиндээ хүрээгүй. Журам-ын 6.2.2.2-аар үнэлэв. |
| 136 | 2.6.1. Үндэсний үнэт зүйлсийг хадгалж, хамгаалан хойч үедээ өвлүүлэн уламжилна. | 1. Үл хөдлөх дурсгалуудыг хамгаалах, хүн чулууны хадгалалт, хамгаалалтыг сайжруулах | 2021 - 2024 | 6 | | 20 | Дарьганга сум 5 хүн чулуун хөргийг хашаажуулж, Хадатын булагт орших хүн чулуун хөргийг 2022 оны Улсын тооллогын дүгнэлтийг үндэслэн сумын Орон нутаг судлах музейд шилжүүлэн байрлуулсэн. Наран сум нь Сөдөтийн цагаан чулуу, Ноён хөндийн хүн чулуун хөргийн хашааг сэргээн шинэчилсэн. Мөн Мандалын хүн чулуун хөшөөний нүүрийг ахуйн будгаар будсан байсанг зориулалтын бодисоор цэвэрлэж сэргээсэн. Онгон сум суманд байх хүн чулуун хөргүүдийг бүрэн хашаажуулсан. Баяндэлгэр сумын уугуул ШУА-ын Археологийн Хүрээлэнгийн ЭШ-ний ажилтан докторант С.Далантайгаар ахлуулсан хээрийн судалгааны баг 2023 онд ТСҮХДЗ-ийн судалгааг хийж, урьдчилсан дүнгээр 800 орчим дурсгалыг илрүүлж байршлыг тогтоон баримтжуулсан. Судалгааны ажлын явцад доод палелотийн үеийн чулуун зэвсгийн суурин, неопалелотийн үеийн чулуун зэвсэгийн сууринтууд, хадны зураг, тамга тэмдгийн дурсгал, улаан зуух, хүннү, хүрлийн үеийн булшнууд, Монголын үеийн оршуулгын газар зэрэг онцгой чухал дурсгалууд илэрсэн. Мөнххаан сум байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд үл хөдлөх дурсгалуудаа сэргээн засварласан. Дарьганга, Онгон Мөнххаан, Сүхбаатар, Түвшинширээ, Түмэнцогт, Эрдэнэцагаан, Наран зэрэг 8 сумын 98 дурсгалт газрын 480 дурсгалыг гэрээтээр хамгаалуулж | 100% / 70%<br><br>2024 оны хэрэгжилт тодорхойгүй. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. Журам-ын 6.2.2.2-р үнэлэв. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. | |
| 137 | | 2. Соёлын биет бус өв тээгчдийн судалгааг бодитой болгон, өвлөн уламжлуулах арга хэмжээг зохион байгуулж, алдаршуулах | 2021 - 2024 | 253 | ОНТ 45.0 | 290 | Аймгийн соёлын биет бус өв тээгчдийн улсын үзлэг, судалгаа хийж, цахим бүртгэлд 38 өвлөн уламжлагчийг бүртгэж, 10 сумын 79 өвлөн уламжлагчийн үйл ажиллагааг баримтжуулсан. Ардын авьяастнууд, өв тээгчдийг олон нийтэд таниулан сурталчлах, алдаршуулах, үйл ажиллагааг нь түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Сүхбаатар 80" ардын урлагийн наадмыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан ба 13 сумын 430 ардын авъяастан 9 төрлөөр оролцсон.  Мөн УБ хотод ардын авьяастнууд, аймгийн театрын уран бүтээлчид, УБ хот дахь нутгийн гаралтай уран бүтээлчид, өв тээгчид оролцсон "Талын Монгол" тоглолтыг зохион байгуулж, дээрх 2 арга хэмжээний хүрээнд наадамд оролцсон Дарьганга, Эрдэнэцагаан, Сүхбаатар сумдын 3 төрөлт өвлөн уламжлагчийг шагнаж урамшуулсан. Тус 2 арга хэмжээний зардалд ЗДМХ хэрэгжүүлэх зардлаас 37,5 сая төгрөг зарцуулсан. Эрдэнэцагаан, Халзан, Мөнххаан, Дарьганга сумдын 6 биет бус өвлөн уламжлагчдын баримтат мэдээ, мэдээллийг бэлтгэн сошиал орчинд сурталчилсан.  Орон нутгийн ТВ-тэй хамтран 5 өв тээгчийн цуврал баримтат, контентийг хийж, олон нийтэд хүргэн, баримтжуулж хадгалсан. Сумд өөрсдийн орорн нутагтаа буй өв тээгчдийг урамшуулах, алдаршуулах, үйл ажиллагааг нь өвлөн уламжлуулах ажил арга хэмжээг тогтмол зохон байгуулж хэвшсэн. | 100% / 70%<br><br>2024 оны хэрэгжилт тодорхойгүй. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. Журам-ын 6.2.2.2-аар үнэлэв. |
| 138 | 2.6.2. Хүүхэд залуусыг | 1. Угсаатны зүйн  музейн | 2024 | | Улсын төсөв | 1 | Аймгийн угсаатны зүйн музейн цогцолборын барилга байгууламжийн зураг төслийг | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үндэсний өв соёл, ёс заншлаа дээдлэгч, өвлүүлэгч, хамгаалагч иргэн болгож хөгжүүлнэ. | стандартын шаардлага хангасан барилгын зураг төсвийг хийлгэж, газрын асуудлыг шийдвэрлэх | | | | | боловсруулах ажлын тендер зарлан тендерт "Криетив Монголиа" ХХК шалгарч тус ажлыг гэрээний хугацаанд гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Аймгийн хэсэгчилсэн төлөвлөгөөнд туссаны дагуу газрын асуудал шийдвэрлэгдсэн. | |
| 139 | | 2. Орон нутгийн угсаатны зүйн музейн үзмэрийг хүүхэд бүрд үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах | 2021 - 2024 | 20 | | 70 | Үндэсний бичиг соёлын өдрийг тохиолдуулан “Титэм арт” академитай хамтран "Их хаадын захидал" үзэсгэлэн, Номын баярыг тохиолдуулан нутгийн зохиолчдын зохиолчдын намтар түүх, номын үзэсгэлэн, ОУ-ын хүүхдийн эрхийн хамгаалах өдрийг тохиолдуулан хүүхдэд зориулсан үзсэгэлэнгүүдийг жил бүр тогтмол зохион байгуулж, сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийг хамруулж ажилласан. ЕБС, СӨБ-ийн хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирттсон музейн боловсролын үйлчилгээг жилд 4-өөс дээш удаа зохион байгуулж хэвшсэн. Мөн угсаатны өв соёл, ахуйг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Дьарьгангын мөнгөн урлалын үзэсгэлэнг тогтмол дэлгэн үзүүлсэн. Мөн гэр бүлд зориулан “Аав-Ээж-Би”, “Гэр бүл-Амьдралын бэлэг” “Гоё өдрүүд” музейн тайлбарт аялал арга хэмжээг зохион байгуулсан. “Монгол гэр”, “Эх хэл үндэсний дархлаа”, “Угсаатан” боловсролын ажил, СӨБ-ийн хүүхдүүдэд “Байгаль эх-Миний гэр” сургалт, боловсролын ажилуудыг зохион байгуулсан. | 100% / 70%<br><br>2024 оны хэрэгжилт тодорхойгүй. Музейн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн хувиар тайлагнах. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. |
| 140 | 2.6.3. Угсаатны өв соёл, ёс заншлыг | 1. "Өв соёл" -ын эвент арга хэмжээнүүд зохион | 2021 - 2024 | 1 | ОНТ 200.0 | 1 | "Ганга нуурын экосистем, ховор зүйл шувуудын хамгааллыг нутгийн иргэдтэй хамтран сайжруулах, орон нутагт чиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, Дарьгангачуудын аж | 100% / 75%<br><br>2024 оны хэрэгжилт |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | түгээн дэлгэрүүлнэ. | байгуулах | | | | | амьдрал ёс заншил, түүх соёлыг сурталчилах зорилгоор “Хунгийн баяр” эвент арга хэмжээг 2 жил дараалан зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд өв соёлын үзэсгэлэн, Дарьганга нүүдэл, бэр гуйх ёслол, идээ ундааны соёл, хувцас эд хэрэглэгдэхүүний үзэсгэлэн зэрэг олон талт арга хэмжээнүүд зохион байгуулсан. Хурдан морь болон адууны өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий ""Агтан хүрээт"" наадам уламжлал болгон зохион байгуулагдаж, арга хэмжээнд сумд адуучид, иргэдээ зохион байгуулан оролцуулахаас гадна соёл урлагийн байгууллагууд хамтран оролцож, үзэмчин болон Дарьганга соёлын өвийн үзэсгэлэн , Дарьганга ястны шавар зуух барих үзүүлбэр, эмээлийн ганзага мялаах ёслол, таван хошуу мал сэтэрлэх, гал тахих ёс, азарга тавих ёс зэргийг үйлдэж, жуулчид, наадамд оролцогчдод үзүүлж, өв соёлоо түгээн дэлгэрүүлж, сурталчилсан. Алтан Дарь овоог тайх их тахилгын 110 жилийн ойд зориулан Дарьганга өвийн наадам зохион байгуулан Дарьганга ястны соёл, өв уламжлалыг наадамчин олон түмэнд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор Дарьгангын сумд хэлхээ тоонот гэрээ барин, орон нутаг судлах музейн үзмэр болон иргэдийн гар дээрх үзмэрүүдээр дэглэж наадамчин олонд толилуулсан. Мөн угсаатны зүйн музей нь Дарьгангын мөнгөн урлал, цуглуулагч Дугарсүрэнгийн хүрэл зэвсгийн үеийн олдвор, зураач Д.Амараагийн Дарьгангын хүн чулуун хөргүүдийн зургуудаар хамтарсан үзэсгэлэн гаргаж Дарьганга нутаг болон угсаатны онцлог ондоошлыг олон нийтэд сурталчилсан. Мөн Сүхбаатар аймгийн Соёлын | тодорхойгүй, 2023 оны хэрэгжилтийг хуулбарласан. Журмын 6.2.1-р үнэлэв. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | биет бус өв тээгч Ш. Чимэдцэеэ, уртын болон ардын дуучид, үндэсний урлагийн их театрын уран бүтээлчид оролцож үндэсний онцлог бүхий урлагийн тоглолт, арга хэмжээг олон нийтэд толилуулсан. " | |
| 141 | | 2. . "Дарьганга соёлын өв", "Сүхбаатар аймаг" брэнд брэндбүүк бүтээн, соёл урлагийн болон сурталчилгааны контент шинээр бий болгож, олон нийтэд сурталчлах, сувгийн хөгжүүлэлт хийх | 2021 - 2024 | 0 | ОНТ 245 | 85 | "Дарьганга соёлын өв", "Сүхбаатар аймаг" брэнд брэндбүүк бүтээн, соёл урлагийн болон сурталчилгааны контентыг бий болгох ажлын хүрээнд аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн лого, эмблем, бэлэгдлийг бүтээж, сурталчилгаа хэвлэмэл хуудас, бэлэг дурсгал, урилга, хөтөлбөр зэрэгт ашиглахын хамт 80 жилийн ойн арга хэмжээг "Сүхбаатар аймаг"-ийн онцлог шинжийг илэрхийлсэн байдлаар зохион байгуулсан. Угсаатны урлаг соёлыг агуулсан "Талын Монгол" концертыг УБ хотод 2 удаа тоглосон. УЗМ нь Дарьганга мөнгөн урлалын үзмэрийг музейн гол бренд болгон УБ хотноо "Нандин өв" үзэсгэлэн, орон нутагт "Дарьганга өв аялаж байна" арга хэмжээг зохион байгуулсан. . Дарьганга угсаатны онцлог бүхий эвент бүтээх арга хэмжээний хүрээнд Дарьганга сум "Хунгийн баяр" арга хэмжээг 2 жил дараалан зохион байгуулсан.Угсаатны өв соёлыг хүүхэд багачууддаа өвлүүлэх, олон нийтэд сурталчлах зорилгоор ННС-ийн хамт олон Соёл, урлагийг дэмжих сангаас зарласан төслийн уралдаанд гавъяат багш Ш. Чулуунборын "Сониуч хүүгийн адал явдал" цуврал өгүүллэгээр дүрст видео ном, аудио сонсдог ном, дабль CD, хуурцаг / бүтээх төслөөр оролцож шалгарсан. Алтан Дарь овоог тайх их тахилгын 110 жилийн ойд зориулан Дарьганга ястны соёл, өв уламжлалыг наадамчин олон түмэнд түгээн дэлгэрүүлэх, | 90% / 50%<br><br>2024 онд хэрэгжилт тодорхойгүй. Хэрэгжилтийн зарим хэсэг 2.6.3.1-ийн тайлагнал, хэрэгжилттэй давхцаж байна. Төлөвлөлтийг оновчтой хийх. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сурталчлах зорилгоор Онгон, Наран, Баяндэлгэр, Дарьганга сумд Дарьгангын Хэлхээ тоонот гэрийг барьж, Орон нутаг судлах музейн үзмэр болон иргэдийн гар дээрх үзмэрүүдээр дэглэж наадмын өдрүүдэд угсаатны зүйн музей нь Дарьгангын мөнгөн урлал, цуглуулагч Дугарсүрэнгийн хүрэл зэвсгийн үеийн олдвор, зураач Д.Амараагийн Дарьгангын хүн чулуун хөргүүдийн зургуудаар хамтарсан үзэсгэлэн гаргаж Дарьганга нутаг болон угсаатны онцлог ондоошлыг олон нийтэд сурталчилсан. Мөн Сүхбаатар аймгийн Соёлын биет бус өв тээгч Ш. Чимэдцэеэ, уртын болон ардын дуучид, үндэсний урлагийн их театрын уран бүтээлчид оролцож үндэсний онцлог бүхий урлагийн тоглолт, арга хэмжээг олон нийтэд толилуулсан. | |
| 142 | 2.6.4. Аймгийн хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээнэ. | 1. Угийн бичиг хөтлөх арга хэмжээг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх | 2021 - 2024 | 38.7 | ОНТ 22.6 | 50 | "Аймгийн Засаг даргын захирамжаар “Угийн бичгээ хөтөлж, удмын сангаа хамгаалья” уралдааныг 3 жил дараалан аймгийн хэмжээнд зохион байгуулсан. СУГ, НТБТ, сумдын ЗДТГ хамтран 13 суманд ""Угийн бичиг хөтлөх арга зүй"" сургалт, “Ахмадаасаа суралцья”, Угийн бичиг-Удмын хэлхээ” сургалт, хэлэлцүүлэг, үзэсгэлэн зэрэг арга хэмжээнүүдийн зохион байгуулсан. ""Ахмадаас суралцъя"" угийн бичгийн үзэсгэлэнг СУГ, ГБХЗГ, аймгийн ""Ахмадын хороо"" хамтран зохион байгуулж, 1 дүгээр шат буюу сумаас шалгарсан угийн бичгүүдийг аймгийн уралдаанд оруулж шилдгүүдийг шалгаруулсан. Сум бүр угийн бичиг бичих арга зүйг иргэдэд сургах, туршлагатай ахмад настны зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж ажилласан. Дарьганга сум “Угийн бичиг” цахим програм худалдан авч, иргэдэд | 100% / 50%<br><br>Угийн бичиг хөтлөлтийн хувь зорилтод түвшинд хүрээгүй. 2024 оны хэрэгжилт тодорхойгүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | технологийн дэвшилийг ашиглан угийн бичгээ хөтлөх нөхцийг бүрдүүлсэн. 2023 оны байдлаар 13 суманд 42 сургалт, 32 арга хэмжээ зохион байгуулсан ба 1341 хүн хамрагдсан." | |
| 143 | 2.6.5. Соёл, урлагийн байгууллагын чадавхыг сайжруулна. | 1. Баяндэлгэр суманд стандартын шаардлага хангасан Соёлын төв барих | 2021 - 2024 | 0 | | 3 | Баяндэлгэр сумын 300 хүний суудалтай соёлын төвийн барилгын суурь, нэгдүгээр давхрын хучилтын ажил 35 хувьтай хийгдэж, гүйцэтгэгч компани цаашид ажлаа үргэлжлүүлэх боломжгүй болсон тул тухайн компанитай байгуулсан гэрээг цуцалж, барилгын ажил зогссон. | 30% / 0%<br><br>Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин уялдаагүй. Гэрээг цуцалж, барилгын ажил зогссон. |
| 144 | | 2. Соёлын төвүүдийг техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, алслагдсан хөдөөгийн иргэдэд соёлын явуулын үйлчилгээг хүргэх | 2021 - 2024 | 20 | УТ64.4 сая ОНТ253.8 сая | 100 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар түвшинширээ суманд 64.4 сая, Асгат Халзан, Мөнххаан, Түмэнцогт, Дарьганга сумдад орон нутгийн хөрөнгө оруулалтаар 93.9 сая, Баяндэлгэр, уулбаяно, Түвшинширээ, мөнххаан, Түмэнцогт, Дарьганга, Наран, Эрдэнэцагаан сумдад сум өөрийн хөрөнгөөр 159.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, хөгжмийн шинэчлэл хийсэн. | 100% / 70%<br><br>2024 оны хэрэгжилт тодорхойгүй. Төлөвлөлтийг оновчтой хийх. Соёлын төвүүдийг техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг шийдвэрлэсэн ч алслагдсан хөдөөгийн иргэдэд соёлын явуулын үйлчилгээний талаар зөвхөн 2022 онд тайлагнасан |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байна. Арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй. |
| 145 | | 3. "Жаахан шарга"" театрын акустик, галерей, тайзны болон хөгжмийн зэмсэгт шинэчлэл хийх | 2024 | - | - | 1 | Орон нутгийн хөрөнгө оруулалттаар хөгжмийн шинэчлэл хийх тендер зарлагдаж "Электрон техник" ХХК шалгарч иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангасан. | 100% / 100% |
| 146 | | 4. Виртуал технологид суурилсан соёлын өвийн танилцуулга, цахим музейтэй болоход шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх (АИТХ-ын 2023 оны 7-р тогтоолоор хассан) | 2022 | 0 | | | (АИТХ-ын 2023 оны 7-р тогтоолоор хассан) | 89% / 89%<br><br>Оновчгүй төлөвлөлт |
| 147 | 2.6.6. Номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1. Орчин үеийн, стандартын шаардлага хангасан Нийтийн номын сангийн байр барих | 2024 | 0 | | 1 | Номын сангийн барилгын асуудлаар холбогдох газар тогтмол хүргүүлэн ажиллаж ирсэн бөгөөд Соёлын дэд сайд өөрчлөгдсөнтэй холбогдуулж, номын сангийн барилгын асуудлаар 2024 оны 04 сарын 01-ний өдрийн №18 тоот албан бичгээр хүсэлт гаргаж, Соёлын дэд сайд П. Баттөрд хүргүүлсэн. Мөн 2025 оны аймгийн | 0% / 0% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөгжлийн төлөвлөгөөнд номын сангийн барилгын зургийн төсвийг шийдүүлэхээр саналаа өгсөн. | |
| 148 | | 2. Сумдын номын сангуудыг номын сангийн LIB4U нэгдсэн программд холбох | 2021 - 2024 | 1 | | | "Электон номын сан болон электрон каталоги байгуулан уншигчдад ашиглуулах, ном, тогтмол хэвлэл, эрдмийн ажил, аудио, видео гэх мэт материалуудыг бүртгэх, зураасан кодын тусламжтайгаар номын сангийн үйлчилгээ, тооллого хийх ажлыг автоматжуулах, тайлан, статистик мэдээллээр хангах LIV4U нэгдсэн програмд аймгийн 12 сумыг холбосон. Програм холбосонтой холбоотойгоор сумдын номын санчдад чадавхжуулах сургалт зохион байгуулж, програмын хэрэгжилтийг хангасан. | 100% / 90%<br><br>2022-2024 онуудад хүрэх түвшин тодорхойлоогүй. Тайлагнал 2021 оны хэрэгжилттэй ижил. Төлөвлөлт оновчтой хийх. Журмын 6.2.2.1-р үнэлэв. |
| 3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ | | | | | | | | |
| 149 | 3.1.1. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | 1. Удирдлагын багийг чадавхжуулах замаар үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн үр ашигтай ажиллах боломжийг бүрдүүлэх | 2021 - 2024 | | | 100 | ОНӨААТҮГ-ын дарга болон удирдах албан хаагчид засаглалыг сайжруулах талаар мэргэжлийн байгууллагатай хамтарч сургалт, арга зүйгээр ханга зорилгоор 2023 оны 02 дугаар сарын 09-10 ны өдрүүдэд Компаний засаглалын үндэсний зөвлөлтэй хамтран "Компаний засаглал"-ын талаар ОНӨААТҮГ-ын удирдлага, ТУЗ-ийн гишүүд, нягтлан бодогчид нийт 18 хуулийн этгээдийн 34 албан хаагчид сургалт зохион байгуулж, сертификат гардуулсан. Удирдлагын бүрэлдэхүүнийг сургалтад хамрагдснаар ОНӨААТҮГ-ын засаглал, хариуцлага, хяналтын тогтолцоо сайжирч, хөрөнгийн үр өгөөж нэмэгдэж, үр дүн, үр ашиг нэмэгдэж байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 шийдвэр болох 2020 оны 09, 2023 оны 05 дугаар тогтоолуудаар | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал болон бусад албан хаагчид олгох цалин хөлсийг ТҮ-1-ээс ТҮ-9-д харгалзан 2.5 дахин нэмэгдүүлсэнээс хэтрүүлэхгүй байхаар тогтоолгосноор ажилчдын нийгмийн баталгаа хангагдаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломж бүрдэж, үр ашиг нэмэгдэх боломжтой болж ирсэн. | |
| 150 | | 2. Санхүүгийн сахилга, хөрөнгийн ашиглалтыг сайжруулснаар алдагдлыг бууруулах | 2021 - 2024 | | | 20 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлын 49 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 419 захирамжаар ОНӨААТҮГ-ын захиралтай гэрээ байгуулах, дүгнэх журам, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын онцгой нөхцөлийн гэрээний загварыг батлаж түүний хүрээнд аймгийн Засаг даргын 2 шийдвэрээр 15 хуулийн этгээдийн "Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө" батлуулан хэрэгжилтийг дүгнэн ажилласнаар ОНӨААТҮГ-уудын мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 168.2 сая төгрөгөөс 1,345.9 сая төгрөг болж өссөн, авлага 2,556.1 сая төгрөгөөс 1,081.7 сая төгрөг болж буурсан, Үндсэн хөрөнгө 26,844 сая төгрөгөөс 29,547.3 сая төгрөг болж өссөн, өглөг 10,599 сая төгрөгөөс 7,716.8 сая төгрөг болж буурсан, хуримтлагдсан үр дүн 12,176.8 сая төгрөгөөс 11,402.5 сая төгрөг болж буурсан нь ОНӨААТҮГ-уудын захирал нартай байгуулах гэрээний заалтад санхүүгийн сахилга батыг сайжруулах хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулах зорилт, ашигт ажиллагаагаа дээшлүүлсэн нөхцөлд урамшуулал олгох, ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх боломжит хязгаарыг тогтоон өгч ажилласны үр дүнд санхүүгийн сахилга | 100% / 90%<br><br>Тодорхойлсон хүрэх түвшний хүрээнд үр дүн гарсан эсэх /алдагдлын бууралтын хувь/-ийг тайлагнах. Журмын 6.2.2.1-р үнэлэв. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сайжирч, ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх, үүссэн өр төлбөрөө барагдуулах эрмэлзлэх нэмэгдэж, цаашид өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг болох эхлэл тавигдаж байна. | |
| 151 | 3.1.2. Төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгож, сахилга хариуцлагыг сайжруулах замаар үр ашгийг нэмэгдүүлнэ. | 1. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгох | 2021 - 2024 | | | 100 | "Татвар төлөлчдийн тоо 2020 оноос 2023 онд 7500-аар нэмэгдэж , орон нутгийн төсвийн орлогын нийт хэмжээ урьдчилсан гүйцэтгэлээр 2020 онтой харьцуулахад 23.5 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ. Татварын хэлтэс нь 2023 онд цахимаар 24 төрлийн 25199 татварын тайланг 83,0 хувьтай хүлээн авсан байна. Татвар төлөгчдийн хүсэлтийг цахимаар хүлээн авч, цахимаар шийдвэрлэн ажилласнаар тайлан хүлээн авалт өмнөх оноос 19 хувиар өссөн байна. Үнэт цаас бичиж бэлэн мөнгөний тасалбараар татварын орлогыг хураан авдагийг халж 100 хувь цахимжуулсан. Нэхэмжлэлд суурилсан цахим системд шилжсэнээр татварын орлого буруу данс руу орох, төрийн санд орсон нэр, регистрийн дугааргүй орлогыг тодорхойлох зэрэг алдаа бүрэн арилсан. Татварын үйлчилгээг татвар төлөгчдөд хүндрэлгүй нэг дороос шуурхай үзүүлэх үүднээс “гэрэгэ киоск” машиныг орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авч Татварын хэлтсийн байранд байршууллаа. Киоск машин байршуулснаар өдөрт 30-50 татвар төлөгч банк руу явах шаардлагагүйгээр бүх төрлийн татварыг цахимаар төлөх, татварын нэхэмжлэх харах болон бусад төрийн үйлчилгээг нэг дороос авах боломж бүрдсэн. Мөн татвар төлөгчид татварын нэхэмжлэлийг ибаримт апп болон бүх төрлийн банкны интернет үйлчилгээгээр онлайнаар төлөх боломжтой болсон нь татвар төлөгчдөд татвар төлөх | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | таатай нөхцлийг бүрдүүлсэн."" " | |
| 152 | | 2. Төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгон төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх | 2021 - 2024 | | | 25 | "1.Төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын программыг УСНББОУ-ын стандартад нийцсэн, хууль тогтоомжийг шинэчлэлийг тусгасан, нягтлан бодогчид болон төрийн сангийн үйл ажиллагааг хөнгөвчилсөн CTS программаар шинэчлэн 58 төсвийн байгууллага, 30 төсөл сангийн үйл ажиллагаанд нэвтрүүлээд байна. Энэ программ хангамж нь онлайн горимоор ажиллах боломжтой, нярвын тайлан нь нягтлан бодогчийн тайлантай уялдсан, байгууллагын гүйлгээ төрийн сангийн төлбөр тооцооны fools, санхүүгийн тайлан нь э-тайлан системд хөрвөх боломжтой зэргээр нягтлан бодогчийн ажлын ачааллыг багасгаж үр дүнг нэмэгдүүлсэн давуу талуудтай болно. Мөн программ ашиглалтын талаарх сургалтыг хөгжүүлэгч байгууллагатай хамтран 2 удаа нийт 176 ажилтанг хамруулан зохион байгуулсан бөгөөд хэрэгжилт бүрэн хангагдсан. 2. ""Эрхийн бүртгэлийн сан"" системийн хөгжүүлэлтийг Сангийн яам хийж, түүний дата мэдээлэл болох аймгийн 124 төсвийн байгууллагын төлбөрийн баримтад 1,2 дугаар гарын үсэг зурах этгээдийн мэдээллийг цахим системд бүрэн оруулж дууссан. Төрийн сан, төсвийн байгууллагын систем хооронд мэдээлэл солилцох, цахимаар төлбөр тооцоо хийх, хяналт тавих боломжийг бүрдүүлэх зорилгоор 2022 оноос “Портал систем” буюу ТСУЦСистемийн ажлыг үе шаттай нэвтрүүлж бүрэн дууссан. Манай аймгийн хувьд 2023 оноос эхлэн ТСУЦСистемийг 124 төсвийн байгууллага ашиглаж эхэлсэн бөгөөд төрийн сангийн төлбөр тооцоо 100 хувь цахимаар | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийгдэж байна.  3. Төсвийн төлөвлөлтийн “Fiscal” программыг 13-н сумын төрийн санд суулгаж, санхүү албаны дарга , мэргэжилтнүүдэд программын сургалтыг зохион байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласнаар   программыг сумдад бүрэн нэвтрүүлсэн.  Тус  “Fiscal” программыг сумдын төрийн сан ашигласнаар  төсвийн төлөвлөлт, төсвийн хуваарь, төсвийн зохицуулалтын үйл ажиллагаа хялбар болж цаг хугацаа хэмнэх, төсвийн тооцооллын арифметик алдаа гаргахгүй байх, төсвийн байгууллагуудын санал хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх зэрэг олон давуу талууд бий болсон. | |
| 153 | | 3. Газар, үл хөдлөх эд хөрөнгө, авто тээвэр  өөрөө явагч хэрэгслийн бүртгэлийг сайжруулж, татварын хувь хэмжээг бууруулах замаар татварт хамрагдалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 0 | | 85 | "1.Татварын хэлтэс нь Улсын бүртгэлийн алба, АТҮТ-ийн бүртгэлд үндэслэн ҮХЭХАТ, АТБӨЯХАТ төлөгчийн бүртгэлийг цахимаас хөрвүүлэн,бүртгэлийн шинэчлэлийг тухай бүр хийн ажиллаж  байна.  Мөн 2022 оны жилийн эцсээр Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн онцлог, байгаль экологийн шинжийг харгалзан төрийн өмчийн газрыг эзэмшүүлж, ашиглуулсны төлбөрийн хэмжээг тогтоолгохоор ""Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүр, төлбөрийн хэмжээ""  төсөл боловсруулан Аймгийн ИТХ-д танилцуулсан. Тус хурлаар Баруун-Урт сумын газрын төлбөрийн итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээ болон Баруун-Урт сумаас бусад сумын газрын төлбөрийн бүсийг тухайн сумын хил заагаар тооцон, газрын төлбөрийн итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээг тус тус батлуулсан. 2. 2021-2023 онд ҮХЭХАТ төлөгчийн тоо 33-оор нэмэгдэж, 2023 онд татвар төлөгчийн тоо 576 болж өссөн байна. ҮХЭХАТ-аар  2023 онд 738167,2 мянган | 100% / 90%<br><br>2024 оны хэрэгжилт тодорхойгүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. ҮХЭХАТ-ын тухай хуульд 2021 онд УИХ-аас өөрчлөлт оруулж татварын хувь хэмжээг 0,6-2 хувь болгон нэмэгдүүлсэн хэдий ч аймгийн ИТХ-аас татвар төлөгч иргэн, хуулийн этгээдийн татварын хувь хэмжээг нэмэхээс илүүтэйгээр татварт хамрагдалтыг нэмэгдүүлэх замаар төсвийн орлогыг бүрдүүлэх байр суурьнаас хувь хэмжээнд өөрчлөлт оруулаагүй. 3. 2021-2023 онд АТБӨЯХАТ төлөгчийн тоо 1715 нэмэгдэж 16401 болж өссөн байна. АТБӨЯХАТ-аар 2023 онд 611095,3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ. АТБӨЯХАТ-ын тухай хуульд 2021 онд УИХ-аас өөрчлөлт оруулж татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн боловч аймгийн ИТХ-аар өөрчлөлт оруулаагүй болно. Газрын төлбөрөөр 2023 онд 577310,0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Татварт хамрагдалтын түвшин 2021-2023 оны байдлаар АТӨЯХТ-ыг 2,5 хувиар, ҮХЭХАТ-ыг 0,7 хувиар нэмэгдлээ. Мөн хөрөнгийн татварыг татвар төлөгч иргэд НӨАТ-ын буцаан олголтоосоо ямар нэгэн шимтгэлгүйгээр төлөх үйлчилгээг нэвтрүүлсэн, киоск машин болон бүх төрлийн банкны интернэт үйлчилгээгээр цахимаар төлөх боломжтой болсон. | |
| 154 | | 4. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан | 2021 - 2024 | 30 | | 45 | Зохион байгуулсан тендер шалгаруулалт бүрт тендерийн баримт бичигт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу тендерт оролцогчдод давуу эрх олгох тухай тусгаж давуу эрх тооцуулах боломжоор хангаж ажилласан. 2021 онд 15 тендерт 5029,4 сая | 90% / 90%<br><br>Шалгуур үзүүлэлтийн дагуу хүрсэн түвшинг тодорхойлоогүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлэх | | | | | төгрөг, 2022 онд 8 тендерт 2298,6 сая төгрөгийн дотоодын үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн, 2023 онд 14 тендерт 2061.5 сая төгрөгийн дотоодын үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн, 2024 оны жилийн эцсийн байдлаар 6 тендерт 2589.4 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн дотоодын үйлдвэрлэлээр тус тус худалдан авсан байна. | |
| 155 | 3.1.3. Банкнаас бусад олон талт санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1. Иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийн болон бусад үүсмэл санхүүгийн зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх | 2021 - 2024 | 0 | | 2000 | "Аймгийн хэмжээнд иргэдийн санхүүгийн боловсрол, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх ажлын хүрээнд Монгол банк бусад арилжааны банкууд, НТБТөв, ЕБ-ын 1,2,3,4-р сургууль, ГБХЗХГ газар гэх зэрэг нийт 44 байгууллагатай хамтран “Иргэдэд хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгох нь”, “Дэлхийн мөнгөний 7 хоног”, ""Ирээдүйнхээ төлөө хуримтлуулцгаая"", аян, сургалт хэлэлцүүлгийн үйл ажиллагааг 2 сарын хугацаанд аймгийн бүх сумдад 30 удаагийн давтамжтайгаар 943 сурагч, 55 иргэн, 58 төрийн албан хаагчдад зохион байгууллаа. Тус аяны хүрээнд иргэд болон сурагчдад мөнгө, үнэт цаас, үүсмэл болон хөрөнгийн зах зээлийн талаар зах зээлийн санхүүгийн мэдлэг мэдээллийг хүргэн, хэрхэн хөрөнгийн зах зээлд зөв, үр ашигтайгаар оролцох, тэдгээрийн давуу болон сул талууд, үүсмэл зах зээлийн хор уршиг зэрэг ойлголтуудыг олгосон давуу талтай сургалтууд болж өнгөрлөө. Мөн мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хууль 2023 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор МЗҮАжиллагаа эрхэлж буй ААНБ болон иргэдэд мэдээллийг түгээн ажиллаж байна. Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хууль батлагдсантай холбоотой зохицуулалттай байгууллагууд дүрмийн сангаасаа хамааран СЗХ, нийслэл болон АЗД-аас зөвшөөрлөө авах | 100% / 97.6%<br><br>Журмын 6.2.1 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болсон. Нэткапитал ХХК болон түүний салбар болох 5 аймаг, 2 дүүрэг зөвшөөрөл аван үйл ажиллагаа явуулж байна. NIBank-наас бэлтгэн гаргадаг хүүхдийн санхүүгийн боловсролд багаас нь мэдлэг олгох, санхүүгийн сахилга батыг суулгахад чиглэгдсэн цахим контент, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргаж буй мөнгөн зээлийн үйл ажиллагааны талаарх контент болон бусад санхүүгийн чиглэлийн контентүүдийг хэлтсийн цахим хуудаст байршуулан ажиллаж байна. /https://www.facebook.com/profile.php?id=100090797783648/ Цахим гэмт хэрэг, мөнгө угаалт, койны талаарх мэдээллийн орон нутгийн цахим мэдээллийн хэрэгслээр 16 удаагийн видео шторк, 41 удаагийн мэдээлэл, гарын авлагыг давхардсан тоогоор 1952 иргэн, хуулийн этгээдэд хүргэсэн байна. | |
| 156 | | 2. "Даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх" | 2021 - 2024 | 26 | | 35 | "Аймгийн хэмжээнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 126 иргэн байдаг бөгөөд аймгийн төвд болон 12 суманд гэнэтийн осол, эмчилгээний даатгал, хөрөнгийн даатгал, автотээврийн хэрэгслийн даатгал, мал амьтдын даатгал, автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал, урт хугацааны даатгал, ХЧТА-ны даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал гэх зэрэг олончиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. 2024 онд гэнэтийн ослын даатгалд 1680 иргэнийг 50,6 сая төгрөгөөр, хөрөнгийн даатгалд 15 иргэнийг 5,3 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн даатгалд 459 иргэнийг 268,9 сая төгрөгөөр, жолоочийн хариуцлагын даатгалд 7929 иргэнийг 425.8 сая төгрөгөөр, мал амьтдын даатгалд 164,4 сая | 100% / 90%<br><br>Даатгалын үйлчилгээнд хамрагдсан хувь тодорхойгүй. Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалд 1492 иргэнийг 78,6 сая төгрөгөөр, унаач хүүхдийн даатгал 150,7 сая төгрөг, зээлийн эрсдлийн даатгалд 1912 иргэнийг ,5 сая төгрөгөөр тус тус хамруулсан бөгөөд зуучлалын үйл ажиллагааны чиглэлээр 25,4 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна. Даатгалын нөхөн төлбөрт гэнэтийн ослын даатгалаар 58 иргэнд 20,2 сая, хөрөнгийн даатгалаар 6 иргэнд 4,5 сая, автотээврийн хэрэгслийн даатгалаар 45 иргэнд 66,1 сая, жолоочийн хариуцлагын даатгалаар 152 иргэнд 117,2 сая, эрүүл мэндийн даатгалаар 172 иргэнд 6,6 сая, МИД даатгалаар 26 иргэнд 16,9 сая төгрөг, зээлийн эрсдлийн даатгалаар 3 иргэнд 10,7 сая төгрөгийг тус тус нөхөн олговроор буцаан олгожээ. 2023 онд даатгалын үйлчилгээний хүртэмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлснээр даатгалд хамрагдалт болон орлого бүрдүүлэлт 15 хувиар өслөө. Даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Үндэсний давхар даатгал, албан журам, Монголын даатгалын холбооноос хамтран даатгалын төлөөлөгчдийн сургалт, шалгалтыг тус оны II улиралд зохион байгууллаа. Сургалтад нийт 35 иргэн оролцсон бөгөөд эрх олгох шалгалтад 10 иргэн тэнцэн “Монгол даатгал” ХК-д төлөөлөгчөөр ажиллах тусгай зөвшөөрлөө авлаа. | |
| 157 | 3.1.4. Статистик мэдээллийн хамрах хүрээ, тооллого, судалгааны | 1. Улсын хэмжээний тооллого, судалгааг зохион | 2021 - 2024 | | Орон нутгаас тооллогын зардлын дэмжлэг 99.8 сая | - - 100 | Статистикийн тухай хуульд заагдсаны дагуу давхардсан тоогоор улсын хэмжээний тооллогыг 8 удаа, түүвэр судалгааг 29 удаа зохион байгуулалтыг хийж амжилттай хийж гүйцэтгэсэн. Үүнд: Жил бүр жилийн эцсийн мал тооллого, Хагас жилийн малын түүвэр | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | байгуулах | | | төгрөг | | судалгаа, өрхөд суурилсан Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, Ажиллах хүчний судалгаа, Ардчилсан засаглал судалгаа, 2021 онд 5 жилд нэг удаа явагддаг Аж ахуйн нэгж байгууллагын тооллого, Бичил уурхайн судалгаа, 2022 онд 10 жилд нэг удаа явагддаг Хөдөө аж ахуйн тооллого, 2020 онд Малын ашиг шимийн судалгаа, 2021, 2023 онуудад Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа, 2022 онд Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, Түр хамгаалах байр/нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх судалгаа, Мал, махны үйлдвэрлэгчийн үнэ, борлуулалтын туршилт судалгаа, 2023 онд Цаг ашиглалтын түүвэр судалгаа, Ногоон ажлын байрны судалгаа, 5 жилд нэг удаа явагддаг Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, анх удаа Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа, 2021, 2024 онуудад олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн үнийн судалгаа, 2023, 2024 онд Малын ашиг шим, нэмүн өртгийн түүвэр судалгаа зэргийг чанартай гүйцэтгэсэн. 2024 оны жилийн эцсийн мал тооллогын бэлтгэл ханган ажиллаж байна. | |
| 158 | | 2. Статистикийн анхан шатны мэдээ, тайлангийн чанарт анхаарч сумд, ААНБ-д улсын байцаагч нарын хяналт, | 2021 - 2024 | - | | 13 сум, 90 ААНБ | Статистикийн хэлтсийн дарга, улсын байцаагч, мэргэжилтнүүдийн цуглуулсан салбарын анхан шатны мэдээнүүдэд жил бүр хяналт хийж, давхардсан тоогоор 183 аж ахуйн нэгжийн гарсан алдаа зөрчлийг дор бүр нь арилгуулж, анхаарч ажиллах санамжийг өгсөн. Аймгийн ЗДТГ, Статистикийн хэлтэс, Татварын хэлтсийн холбогдох албан хаагчид хамтран давхардсан тоогоор 1215 аж ахуйн нэгжийн жилийн эцсийн | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шалгалтыг хийх | | | | | санхүүгийн тайлан балансад хяналт, шалгалт хийж буруу гаргасан давхардсан тоогоор 152 аж ахуйн нэгжийн илэрсэн алдааг засуулан ажиллалаа. Мөн улсын хэмжээний мэдээ тайланг хугацаа хожимдуулах, алдаагүй гүйцэтгэх талаар сумдад 31 удаа хяналтыг хийж ажилласан байна. 2024 онд 13 сум, 118 ААН-үүдэд статистикийн мэдээний гаргалт, анхан шатны бүртгэл хөтлөлтийн шалгалтыг хийж 2 сумын хугацаа хоцролт, 6 ААН-ийн анхан шатны бүртгэл сайжруулалтад чиглэлийг өгч ажилласан. | |
| 159 | 3.2.1. Ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна. | 1. Байгаль, орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил арга хэмжээг, чанартай гүйцэтгүүлж, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж байгаа аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжин ажиллах | 2021 - 2024 | 90 3 | | 100 8 | БОАЖ-ын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар баталсан журмын дагуу тухайн жилийн байгаль орчны менежментийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын 2020 оны А/446 дугаар захирамжаар байгуулагдсан аймгийн БОАЖГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг 11-р сарын 01-ний дотор тайланг хүлээн авч, газар дээр нь ажиллаж дүгнэлт гарган БОАЖЯ-нд хүргүүлж ажилладаг. 2021 онд 8 аж ахуй нэгж, 2022 онд 5 аж ахуй нэгж тайлангаа ажлын хэсэгт дүгнүүлсэн. 2023-2024 оны байдлаар аймгийн хэмжээнд баяжуулах үйлдвэртэй 4 аж ахуй нэгж байна. үүнээс 3 аж ахуй нэгж усыг дахин ашиглах, хүдрийг боловсруулах дэвшилтэт технологи нэвтрүүлэн ажиллаж байна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт дүгнэх ажлын хэсэг ажиллаж эхлээд байна. | 90% / 70%<br><br>Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. |
| 160 | | 2. Уул уурхайн ашиглалт, | 2021 - 2024 | 3 | | 10 | Аймгийн Засаг даргын захирамжаар 2021 онд “Монголжүюаньли”, “Сунхунголд”, “Каскейд | 50% / 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг бууруулах, байгаль орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор бүтээгдэхүүн тээвэрлэлтийн экспортын хүнд даацын авто зам барих ажлыг үе шаттай хэрэгжүүлэх | | | | | майнинг”, "Бадмаараг хаш", "Эрдэнийн босго", "Андын Илч", “Премиум көүл”, “Олгой булаг” ХХК-иудад уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн чиглэлийг тогтоосон хугацааг сунгаж, авто зам засвар арчлалтыг хариуцан ажиллах үүрэг чиглэлийг өгсөн. "Бадмаараг хаш", "Олгойбулаг", "Сунхунголд" ХХК-иуд тээвэрлэлтийн чиглэлийн дагууд хэсэгчилсэн авто зам засварын ажлыг гүйцэтгэсэн.Бичигтийн боомтын үйл ажиллагаа 9 сараас туршилтын журмаар тээвэрлэлт явуулж эхэлсэн. 2022 онд "Хунт өгөөж", "Каскейд майнинг", "Олгойбулаг" ХХК-иуд тээвэрлэлт гүйцэтгэх түр чиглэл батлуулж, хэсэгчилсэн авто зам засварын ажлыг гүйцэтгэсэн. 2023 онд аймгийн Засаг даргын 2023 оны А/338 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Автотээврийн тухай хууль, авто замын тухай хуулийн дагуу Бичигт боомт чиглэлд уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн авто замын түр маршрутыг тогтоон баталгаажуулсан. "Хунт Өгөөж", "Эм эл цахиурт овоо", “Каскейд майнинг”, "Бадмаараг хаш", "Эрдэнийн босго", “Премиум көүл”, “Олгой булаг”, "Цэгээн үүдэн", "Цайрт минерал" зэрэг 9 аж ахуй аймгийн Засаг даргын захирамжаар тээвэрлэлтийн авто замын маршрут чиглэл батлуулан засвар, арчлалтыг хариуцан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар 4 аж ахуй нэгж тусгай зориулалтын хатуу хучилттай авто замын чиглэл, маршрут батлуулан авто зам барихаар ажиллаж байна. Эрдэнэцагаан сумын нутагт үйл ажиллагаа явуулах Эрээнтолгой ХХК Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | А/05 дугаар тушаалаар "Эрээн толгой" хүрэн нүүрсний уурхайгаас Бичигт боомтын чиглэлд 110.3 км тусгай зориулалтын авто замын чиглэл батлуулсан, 2023 онд авто зам барих төслийг эхлүүлсэн. 2024 онд 5 аж ахуй нэгж бүтээгдэхүүн тээвэрлэлтийн чиглэл батлуулан, авто замын засвар, арчлалтыг хариуцан ажилласан. Эрээн толгой ХХК, Дорнын чулуулаг ХХК-иуд тусгай зориулалтын авто зам барих ажлыг гүйцэтгэж байна. | |
| 161 | | 3. Орон нутгийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажилд шаардагдах ТТАМ-ын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд орон нутгаас санал санаачилга гарган ажиллах | 2021 - 2024 | | | 5 | Аймгийн хэмжээнд 2023 оны 11 дүгээр сарын 21-ний байдлаар хүчин төгөлдөр ТТАМ-ын хайгуулын тусгай зөвшөөрөл 9, ашиглалтын тусгай зөвшөөрөл 2 байна. ТТАМ-ын тухай хууль, холбогдох журмын дагуу хүсэлт гаргасан аж ахуй нэгжийн өргөдлийг бүртгэн авч, анхан шатны шүүлт хийн АМГТГ-т цахимаар хүргүүлсэн. 2022 онд 8 өргөдөл, 2023 онд 9 өргөдлийг цахимаар бүртгэн авч холбогдох саналуудыг авч ажиллаж байна. Улс, орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах ТТАМ-ын карьерын асуудал орон нутагт хүндрэлтэй хэвээр байна.Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа авто замын ажлуудад шаардагдах ТТАМ-ын карьерын солбилцолыг батлуулж, авто замын гүйцэтгэгч компаниар нөхөн сэргээлтийг хариуцуулан, төлбөрийг сум, орон нутагт төвлөрүүлэхээр мэргэжлийн байгууллагууд хяналтыг хэрэгжүүлэн ажиллах шийдвэр гаргуулан ажиллаж байна. Энэ онд уул уурхайн тусгай зориулалтын авто зам, газрын тосны шугам хоолойн бүтээн байгуулалтын төслүүдэд шаардагдах ТТАМ-ын карьерын | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | асуудлыг шийдвэрлүүлэх саналыг ЗТХЯ, УУХҮЯ-дад уламжилсан. 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Засгийн газрын 65 дугаар тогтоолоор ТТАМ хайх ашиглах карьерын солбилцлыг батлуулж, аймгийн Засаг даргын А/525 дугаар захирамжаар авто замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэгч "Монгол зам групп" ХХК-д ТТАМ хайх, ашиглах зөвшөөрлийг олгон холбогдох мэргэжлийн байгууллага сумд хяналтыг хэрэгжүүлж байна. | |
| 162 | 3.2.2. Уул уурхай, газрын тосны салбарын үйл ажиллагаанаас орон нутгийн хөгжил, иргэдэд үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | 1. Уурхайг ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай нутгийн захиргааны байгууллага хамтран | 2021 - 2024 | 1 | | 19 | Нийгмийн хариуцлагын хүрээнд Орон нутгийн хөгжлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг өргөжүүлэх зорилгоор Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгдчийн 2021 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 09 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2021 оны А/149 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг аж ахуй нэгжүүдтэй хэлцэл хийж, 2021 онд Аймгийн Засаг дарга, холбогдох сумын Засаг дарга ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 12 аж ахуй нэгжтэй, 2022 онд 8 аж ахуй нэгжтэй гэрээний хэлцэл зохион байгуулж 13 аж ахуй нэгжтэй, 2023 онд аймгийн Засаг даргын А/274 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 19 аж ахуй нэгжтэй хэлцэл зохион байгуулж 15 аж ахуй нэгжтэй ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГУРВАЛСАН ГЭРЭЭГ байгуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд аймгийн хөгжлийн санд жил бүр 2.0 тэрбум орчим төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна. 2024 оны 11 сарын байдлаар ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 16 аж ахуй | 100% / 97.72%<br><br>Журмын 6.2.1 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллах гэрээ байгуулж ажиллах | | | | | нэгжтэй орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | |
| 163 | | 2. Уул уурхайн салбарын хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, тусгай зөвшөөрөл, үйл ажиллагааны талаарх мэдээллийг орон нутгийн иргэдэд мэдээлэх | 2021 - 2024 | 2 | 5 | 8 | "Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр танилцуулах мэдээлэлд салбарт баримтлах бодлого, хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг танилцуулан мэдээлж ажиллаж байна. 2021, 2022 онд Уулбаян, Мөнххаан, Түмэнцогт, Сүхбаатар, Асгат, Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Түвшинширээ сумдын ИТХ-ын Төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газар, багийн ИНХ, иргэдийн сум тус бүрээс 30-35 төлөөлөлд уул уурхайн салбарын мэдээлэл, салбарын бодлого, хууль, тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор ""Уул уурхайн амьдралын мөчлөг"" сургалт, хэлэлцүүлгийг Мерит төсөл, Дорнод их сургуулийн багш нартай хамтран зохион байгуулж ажилласан. Эрдэнэцагаан сумын нутгийн зөвлөл, ОҮИТБС-ын үндэсний зөвлөлийн ажлын албатай хамтран Эрдэнэцагаан сумын уул уурхайн зөвлөгөөнийг иргэний нийгмийн байгууллагууд, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж байгууллагууд, иргэдийг оролцуулан хийсэн. ""Их бага баян шарга"" ТББ-ын санаачилгаар Аймгийн ОҮИТБС-ын дэд зөвлөл хамтран аймгийн уул уурхайн салбарын үйл ажиллагааны мэдээллийг иргэдэд ил тод хүргэх, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Баян шарга сонины тусгай дугаарыг 1000 ш хэвлүүлэн тараасан. Мөн Эрдэнэцагаан, Сүхбаатар, Уулбаян сумдад дэд зөвлөл байгуулах, чадавхжуулах сургалтууд зохион | 100% / 70%<br><br>2024 онд хийгдсэн ажил тодорхойгүй. Тайлагналаас шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрсэн эсэх нь тодорхойгүй. Журмын 6.2.2.2 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулсан. 2023 онд УУХҮЯ, ОҮИТБС-ын ажлын албанаас ""ОҮИТБС-ын аймаг, хөдөөгийн сум"" шилдэг тохиолдлууд видео контент бэлтгэн олон нийтэд бэлтгэн үзүүлэх ажлыг гүйцэтгэгч "Номадик контент" ХХК-тай хамтран ажиллаж оролцсон. 2024 онд хууль тогтоомжийг сурталчлан таниулах, салбарын үйл ажиллагааны мэдээллийг иргэдэд мэдээлэх ажлыг ""Их бага баян шарга"" ТББ байгууллагатай хамтран мэдээлэл бэлтгэн цахимаар болон танхимаар хүргэж ажилласан." | |
| 164 | | 3. Төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, уул уурхайн компаниуд болон орон нутгийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор салбарын зөвлөгөөн, уулзалтыг зохион байгуулах | 2021 - 2024 | 1 | | 2 | 2021 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, агентлаг, ОҮИТБС-ын ажлын алба, "Нээлттэй нийгэм форум", "Мерит" төслөөс зохион байгуулсан уул уурхайн салбарын цахим болон танхимын уулзалт хэлэлцүүлэгт холбогдох төлөөллийн хамт оролцсон, 2022 онд Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, ашигт малтмал газрын тосны газар, олборлох үйлдвэрийн ил тод байдлын ажлын дэд зөвлөл, Зам тээврийн яам, Мерит төсөл, иргэний нийгмийн байгууллагууд болон аж ахуй нэгжүүдтэй хамтран "Хариуцлагатай уул уурхай" салбарын бүсийн зөвлөгөөнийг 3, 10 сард тус бүр зохион байгуулсан. Энэ онд Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд төрийн захиргааны төв байгууллагаас зохион байгуулсан "Аж үйлдвэржилтийн үндэсний зөвлөгөөн", "Уул уурхайн салбарын 7 хоног" арга хэмжээнүүдэд оролцсон мөн 11 дүгээр сарын 16,17-ны өдрүүдэд Дорнод аймагт зохион байгуулагдсан салбарын бүсийн зөвлөгөөнд аймаг сумын дэд зөвлөл, ИНБ-ын төлөөлөлтэй хамт оролцсон. "Хариуцлагатай уул уурхай, орон нутгийн хамтын ажиллагаа | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2024" салбарын орон нутгийн жилийн уулзалт арга хэмжээг зохион байгуулсан. Төрийн байгууллага, 20 гаран аж ахуй нэгж, холбогдох сумдын удирдлага, ТББ-ын төлөөлөл нийт 80 гаран төлөөлөл оролцсон. Төрийн захиргааны төв байгууллагаас зохион байгуулсан "Уул уурхайн 7 хоног", "Монголын геологи хайгуул 2024" чуулга уулзалтуудад орон нутгийн төлөөллийг оролцуулж, мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. | |
| 165 | | 4. Аймгийн хэмжээнд уул уурхайн салбарын хайгуул, ашиглалтын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, хяналт шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах | 2021 - 2024 | 70 | | 85 | "2023 онд төлөвлөгөөт хяналт шалгалтыг Уул уурхайн чиглэлээр 15 ААН-д хийж илэрсэн зөрчил, дутагдлуудыг арилгуулахаар улсын байцаагчийн 65 заалттай 12 албан шаардлага хүргүүлсэн. Аж ахуйн нэгжүүдийн хууль сахин мөрдөлт нь 42.2% , эрсдэл үүсэх магадлал нь 45.2 хувь буюу дундаж эрсдэлтэй байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй 2 аж ахуйн нэгжид 4 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч бүрэн барагдуулсан. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бага өлгий ХХК, Сэвүүн уудам ХХК-д хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн цаашид авах арга хэмжээний талаар зөвлөгөө зөвлөмжийг өгсөн, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй Шарга ХХК, Үлэмж агро ХХК, Ноёдын ноён хөндий ХХК нь 2023 онд хийх хайгуулын ажлын төлөвлөгөөг хянуулсан. Уулбаян сумын нутагт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Шинэ ууж им орд ХХК нь Уул уурхайн ашигт малтмалын газрын Эрдэс баялагийн зөвлөлөөс өгсөн даалгаварын хүрээнд гүйцээх хайгуул судалгаа хийх ажлыг иргэд эсэргүүцэн үйл ажиллагаанд саад учруулсан зөрчилд Байгаль орчин аялал | 90% / 50%<br><br>Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар тайлагнаагүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | жуулчлалын газрын БОХУбайцаагчтай хамтарсан шалгалтыг хийж БОХУБ нь компани үйл ажиллагаанд саад учруулсан иргэдэд зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээг авсан. Хууль бусаар байгалийн өнгөт чулуу олборлосон 6 иргэнд зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйлийн 7 дах хэсгийн 7.1 дэх заалтаар 6 сая төгрөгөөр торгож шүүхээр албадан төлүүлсэн. Олборлосон 28 кг өнгөт чулууг Мөнххаан сумын ЗДТГ-ын орон бус зөвлөлд улсын орлого болгуулахаар шилжүүлсэн.    2024 онд уул уурхайн чиглэлээр 13 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлуудыг  арилгуулахаар  улсын байцаагчийн  33 заалттай 4 албан шаардлага хүргүүлж  албан шаардлагын биелэлт 51% хэрэгжилжиж байна. 9 аж ахуйн нэгжид хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж тус бүр 10 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. 4 ААН-д  зөрчлийн хэрэг нээж хэргийг шийдвэрлэн 1 ААН-ийн үйл ажиллагааг түр зогсоосон | |
| 166 | 3.2.3. Уул уурхайн орд газрыг түшиглэн экспортод чиглэсэн хүнд үйлдвэр байгуулах санал санаачилгыг | 1. Хөөт, Ерөөлт, Цахиурт овоогийн уурхайн ордыг түшиглэн хүнд үйлдвэр байгуулах төслүүдийн үйл ажиллагааг орон нутгаас бодлогоор | 2022 - 2024 | | | 1 | "Цахиурт овоогийн уурхайн баяжуулах гангийн үйлдвэр ашиглалтад ороод байгаа боловч хил гааль хаалттай байсан, ковидын дараах аж ахуй нэгжийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн хүндрэлээс болж зогсонги байна. Ерөөлтийн ордод ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг ""Дорнын чулуулаг"" ХХК-ийг түшиглэсэн нүүрс боловсруулах, угаах үйлдвэр технологийн паркын төсөл хэрэгжүүлэх санал гарсан, орон нутгаас мэдээлэл авч, санал солилцон ажиллаж байна. Шинэ сэргэлтийн бодлого | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дэмжинэ. | дэмжин хамтран ажиллах | | | | | боомтын сэргэлтийн хүрээнд Хөөт-Бичигтийн чиглэлийн 234 км төмөр зам барих ажлыг эхлүүлэхээр Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. Бичигт боомтын хил холболтын бүтээн байгуулалтын ажилд орон нутгаас бүх талын дэмжлэг үзүүлэхээр хамтран ажиллаж байна. " | |
| 167 | 3.3.1. Атрын IV аяныг хэрэгжүүлж, атаршсан газрын талбайн ашиглалтыг сайжруулан, тариалалтыг нэмэгдүүлнэ. | 1. Үр тарианы аж ахуй нэгжүүдийн талбайн ашиглалтыг сайжруулах | 2021 - 2024 | 6 | | 18 | Аймгийн хэмжээнд Түмэнцогт суманд "Үргэлж бадрал"ХХК, "Хэрлэн Алтай"ХХК, "Түмэн ургац"ХХК, "Газрын чимэг"ХХК, Сүхбаатар суманд "Дорнод шим агро"ХХК, Эрдэнэцгаан суманд "Номин богд"ХХК зэрэг 6 үр тарианы аж ахуйн нэгж 22150 га талбай эзэмшиж байна. 2024 онд аймгийн хэмжээнд овъёос 755 га, арвай 281 га, улаан буудай 2527 га, рапс нийт 3220 га зэрэг үр тариа, 2110 га талбайд малын тэжээлийн ургамал нийт 8893 га талбайд тариалалт хийсэн. Үүнээс овъёос 627.5 тн, арвай 252 тн, улаан буудай 1637 тн, рапс 878 тн, малын тэжээл 2260 тн тус тус хураан авсан. 2024 онд үр тариа 3563 га талбайд тариалсан.2021 онд 11630.30 га, 2022 онд 7548 га, 2023 онд онд 8365 га, 2024 онд 8893 га талбайд тус тус тариалалт хийж, жил бүр нийт тариалангийн талбайн 41.1 хувийг ашигладаг байна. | 90% / 70%<br><br>Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин уялдаагүй. Хүрэх түвшинг тодорхой бус төлөвлөсөн. Хэмжих нэгж? |
| 168 | | 2. Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээний 40-өөс доошгүй | 2021 - 2024 | 99.6 - | | 200 - | 2021, 2022 онуудад төмс 166 га, хүнсний ногоо100.6 га-д нийт 266.6 га талбайд тариалалт хийсэн. 2021 онд Баруун-Урт сумын иргэн өөрийн хөрөнгөөр 47.0 сая төгрөгний услалтын систем, бага оврын трактор, манагч худалдан авсан. 2023 онд орон нутгийн хэмжээнд 91 га талбайд төмс, 87,5 га талбайд хүнсний ногоо тариалж төмс 606 тн, хүнсний | 90% / 50%<br><br>Төлөвлөлт оновчгүй. Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хувийг хангах | | | | | ногоо 575 тн ургац хураан авсан нь хүн амын хэрэгцээт төмсний хангамжийн36.7 хувь, хүнсний ногооны хангамжийн 11.5 хувьд хүрсэн. 2024 онд орон нутгийн хэмжээнд 64.5 га талбайд төмс, 47.9 га талбайд хүнсний ногоо тариалж төмс 529.3 тн, хүнсний ногоо 561.6 тн ургац хураан авсан. Энэ нь хүн амын хэрэгцээт төмсний хангамжийн 22.4 хувь, хүнсний ногооны хангамжийн 10.9 хувьд хүрсэн. | хэрэгцээний 40-өөс доошгүй хувийг хангах гэж төлөвлөсөн ч зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй. Хүрэх түвшин тодорхойгүй. |
| 169 | | 3. Тариалангийн талбайг мал, тэжээвэр амьтны хөлөөс хамгаалах ажлыг эрчимжүүлэх | 2021 - 2024 | 8000 | | 500 | Тариалангийн талбайг малын хөлөөс хамгаалан чөлөөлөх шийдвэрийг жил бүр гаргаж малчин иргэдэд ухуулах хуудас тараах, тариалангийн тухай хуулийг багийн өдөрлөгүүдэд сурталчилах ажлыг зохион байгуулсан. Үүний үр дүнд орон нутагт газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 6 аж ахуй нэгж байнгын 3310 га, зөөврийн 5900 га талбайг хашиж хамгаалсан. Үүнд: Түмэнцогт суманд “Хэрлэн алтай” ХХК 800 га, “Газрын чимэг” ХХК 1300 га, Сүхбаатар сумын "Дорнод шим агро"ХХК зөөврийн 2000 га, байнгын 1210 га, Эрдэнэцагаан сумын Номин богд ХХК зөөврийн 3910 га талбайг хашаажуулсан байна. | 100% / 100% |
| 170 | 3.3.2. Малын эрдэс, тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 1. Малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэх /га/ | 2021 - 2024 | 502 | | 1500 | 2021, 2022 онуудад судан өвс, овъёос, арвай зэрэг малын тэжээлийн ургамлыг Түмэнцогт сумын " Хэрлэн Алтай" ХХК 1200 га, "Түмэнцогт ургац" ХХК 1670га, Эрдэнэцагаан сумын "Номинбогд" ХХК 400 га, Баруун-Урт сумын "Нараншарга агро" ХХК 23 га, Сүхбаатар суманд "Дорнод шим агро" ХХК 700 га, “Газрын чимэг” ХХК 130 га, Баруун-Урт сумын ЗДТГ 6 га талбайд ногоон тэжээл тус тус нийт 4130 га талбайд малын тэжээл тариалсан. 2023 онд | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | малын тэжээлийг 1926 га талбайд тариалалт хийсэн ба өмнөх оныхоос 774 га талбайгаар нэмэгдүүлсэн. 1685 тн тэжээл хураан авсан. 2024 онд малын тэжээлийг 12110 га талбайд тариалалт хийсэн ба өмнөх оныхоос 184га талбайгаар нэмэгдүүлсэн. 2260 тн тэжээл хураан авсан. Тухайлбал Түмэнцогт суманд 307 га, Асгат 50га, Сүхбаатар сум 300га ногоон тэжээл тариалаад байна. Мөн Мөнххаан сум малын тэжээлд зориулж Эрдэнэ шишийг туршалтаар тариалж байна. Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ланд шаф биологийн олон янз хамгаалах төслөөс 6 сарын 5нд малын ногоон тэжээл тариалах сургалт болж нийт 100 малчин хамрагдсан малчдад нийт 960тн ногоон тэжээлийн үр өгсөн. | |
| 171 | | 2. Орон нутагт эрдэс тэжээлийн цех байгуулах санал санаачилгыг дэмжих | 2021 - 2024 | 0 | 24,2 | | 2021 онд Баруун-Урт сумын иргэн сум хөгжүүлэх сангаас 24,2 сая төгрөгийн хөрөнгөөр багсармал тэжээл бэлтгэх зорилгоор зээл авсан. 2022 онд Сүхбаатар сумын иргэн "Холимог хүчит тэжээлийн үйлдвэрлэл" байгуулахаар бэлтгэл ажлаа хангасан. Сумдад хоршоо хөгжүүлэх сангаар дэмжлэг олгохоор тэргүүлэх чиглэлд тусгасан боловч 2023-2024 онд эрдэс тэжээлийн цех байгуулах санал санаачлага гаргаж төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэн, ААН гараагүй байна. Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ландшаффт биологийн олон янз байдал төслийн газраас малчдад өвөлжөө хаваржаанд ногоон тэжээл тариалах даршлах сургалт зохион байгуулж өвөлжөөний хөл бууцанд ногоон тэжээл тарьж даршлах сургалтанд 40 малчин хамрагдан 5 өрх ногоон тэжээл тариалж | 70% / 70%<br><br>2023-2024 онд хүрэх түвшин тодорхойлоогүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | даршлаад байна. | |
| 172 | | 1. Өвлийн хүлэмжийн аж ахуйг шинээр байгуулах | 2021 - 2024 | | 8.5 | 0.05 | Баруун-Урт сумын "Нутаг шим" ХХК өөрийн 200 сая төгрөгийн хөрөнгөөр 341 м.кв бүхий 4 улирлын өвлийн хүлэмжийг шинээр барьсан. Улсын 2024 оны төсвийн тухай хууль, ЗГ-ын 2023 оны Жагсаалт батлах тухай 409 дүгээр тогтоолоор хүнсний ногоо тарих зориулалт бүхий өвлийн хүлэмжний зураг төсвийг хийлгэж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Өвлийн хүлэмжийг Баруун-Урт суманд 1 га газарт барихаар шийдвэрлэсэн. | 50% / 50%<br><br>Хүрэх түвшинд хүрээгүй. Журмын 6.2.2.3. Хэмжих нэгж тодорхойгүй. |
| 173 | 3.3.3. Өвөл зуны хүлэмжийн болон зоорины аж ахуйг хөгжүүлж, хүнсний ногооны ургацыг нэмэгдүүлнэ. | 2. 3.3.3.2. Нийлэг хальсан хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 3 - | 80 | 3.5 - | "Шинэ хөдөө" төслийн 80.0 сая төгрөгийн хөрөнгөөр "Алтынсапа"ХХК-иас 60 м.кв 10 ширхэг, 32 м.кв 20 ширхэг хүлэмж тус тус худалдан авч сумдын тариаланч иргэдэд олгосон. Баруун-Урт сум 120 м.кв талбайтай 12 ширхэг, 32 м.кв талбайтай 7 ширхэг, Дарьганга, Баяндэлгэр сумдууд 32 м2 талбайтай нийт 50 ширхэг хүлэмж тус ус худалдан авч тариаланч иргэдэд хөнгөлөлттэй үнээр олгосон. 2021-2024 онд аймгийн хэмжээнд 4504 м.кв-аар нийлэг хальсан хүлэмжний аж ахуйг нэмэгдүүлсэн. Аймгийн хэмжээнд 4.5га талбайг нийлэг хальсан хүлэмж эзэлж байна. | 100% / 90%<br><br>Хэмжих нэгж тодорхойгүй. Дэмжлэг үзүүлсэн дүнгийн талаар тайлагнаагүй. |
| 174 | | 3. "Жимс, жимсгэнэ"-ний суулгац үржүүлгийг, эрчимжүүлэх, хамгаалалтыг сайжруулах | 2021 - 2024 | | 5 | 5 | Орон нутгийн жимс, жимсгэний үржүүлгийн төвийн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд 3.2 сая төгрөгөөр 0.4 га талбайн усалгааны систем худалдан авч суурилуулсан. Туркийн хамтын ажиллагааны байгууллага /TIKA/ - ын 44.0 сая төгрөгийн санхүүжилтээр гүн өрмийн худаг шинээр гаргаж, 43.0 сая төгрөгний өртөг бүхий 120 м2 талбай бүхий 5 | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ширхэг нийлэг хальсан хүлэмжийг шинээр байгуулсан. Тус төвд чавга, алим, интоор, чацаргана зэрэг жимс тариалдаг. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд жимс, жимсгэнэ суулгац үржүүлгийн төвд Дорнод монголын хуурай хээрийн төслөөс 60.0 сая төгрөг санхүүжилтээр 3000 ширхэг жимсний мод тариалалт хийсэн | |
| 175 | | 4. Зоорины аж ахуйн ашиглалтыг сайжруулж, иргэдэд чанартай хүнсний ногоо нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх | 2021 - 2024 | | | | Сүхбаатар сумын "Жавхлан хүслэн" ХХК 60.0 сая төгрөгөөр 50 тн-ийн багтаамжтай зоорь шинээр барьж ашиглалтанд оруулсан.Баруун-Урт сумын “Алтан цацал” хоршоо нь өөрийн хөрөнгө оруулалтаар 150 тн төмс, хүнсний ногоо хадгалах зоорийг шинээр барьж байна. Жил бүр 1000 гаруй тн төмс, хүнсний ногоо хураан авч байгаач ашиглалтанд байгаа 9 зоориний агуулах багтаамж 675 тн байна. Ашиглалт хэвийн 5 зооринд 280 тн төмс, хүнсний ногоо хадгалж байна. Баруун-Урт, Сүхбаатар, Түмэнцогт сумдад төмс, хүнсний ногоо хадгалах нийт 590 тонны 7 зоорийг ашиглаж байна. | 70% / 70%<br><br>Суурь түвшин, хүрэх түвшин тодорхойлоогүй. Журмын 6.2.2.2 |
| 176 | 3.3.4. Аймгийн хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр бүрэн хангах, хүнсний | 1. Хүн амын стратегийн болон гамшгийн үеийн хүнсний нөөц бүрдүүлэх ажлыг аймаг, орон нутгийн хэмжээнд зохион байгуулах | 2021 - 2024 | - 2 | | 2 | Жил бүр аймгийн стратегийн болон гамшгийн үеийн улирлын нөөц бүрдүүлэхээр 12 сумын 28 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байна, Аймгийн төвийн "ӨСӨХ ДЭЛГЭР УНДРАХ" ХХК, " НОМИН АГУУЛАХ ХУДАЛДАА"-ны төвийн агуулахад байршуулах Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг хавсралтаар батлуулж, улирлын нөөцөнд мах /тахиа,загас/ 194,0 тн, сүү 775,7 тн, гурил 484,9 тн, будаа 242,9 тн –ыг тус агуулахад байршуулахаар тусган ажилладаг. Мөн 2023 оны хаврын махны нөөцөд 34,0 тн мах нөөцлөж | 90% / 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна. | | | | | | худалдаанд гаргасан. Стратегийн болон гамшгийн үеийн өргөн хэрэглээний хүнсний нөөц гэрээний дагуу хэвийн хангагдаж байна. 2024 онд хаврын улирлын махны нөөцөнд 3 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, 40 тн мах бэлтгэн зах зээлийн худалдаанд гаргасан. | |
| 177 | | 2. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх /мах, сүү, гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо гэх мэт/ | 2021 - 2024 | 37.9 | | 45 | 2021 онд хүн амын хэрэгцээт төмсний хангамж 35,7% , хүнсний ногооны хангамж 8,6 %, мах 100 %, сүү 10.3%, 2022 онд мах 100%, сүү 30% , гурилан бүтээгдэхүүн 18% , төмс 34,6% , хүнсний ногоо 8,6% , өндөг 6.9% , цэвэр ус 2.8%-иар тус тус дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа нь жил бүр тодорхой хувиар өсөн нэмэгдэж байна. 2023 онд мах 100% /34.0 хувь нь үйлдвэрийн аргаар бэлтгэсэн /, сүү 30%, гурилан бүтээгдэхүүн 20.5%, төмс 36.7%, хүнсний ногоо 11.4%, өндөг 6.8 %, цэвэр ус 2.6 хувиар тус тус дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа нь жил бүр тодорхой хувиар өсөн нэмэгдэж байна. Дээрх тооцооллоос үзэхэд хүнсний ногоо 2.8 хувь, гурилан бүтээгдэхүүн 2.5 хувиар нэмэгдэж, шинээр 2800 өндөглөгчтэй тахианы аж ахуй байгуулагдсанаар өндөгний хангамж нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний 2024 оны хэрэгцээ, хангамж мах 100%, сүү 40,9%, цагаан идээ 18.4%, гурилан бүтээгдэхүүн 22.1%, төмс 25.9%, хүнсний ногоо 20.7%, өндөг 8.8%, цэвэр ус 1.6% тус тус дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна. 2023 онтой харьцуулахад түүхий сүү 10.9 тн, цагаан идээ 20.7 тн, гурилан бүтээгдэхүүн 1.6 тн, хүнсний ногоо 9.3 тн, өндөг 2.0 тн-оор тус тус нэмэгдсэн байна. | 100% / 90%<br><br>Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй уялдуулж тайлагнах. Нийт хүнсний бүтээгдэхүүний хангалтын хувиар хэрэгжилтийг гаргах. Үнэлгээг бууруулав. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 178 | | 3. Хүнсний үйлдвэр, нийтийн хоолны аюулгүй байдалд хяналт тавьж эрсдэлийг бууруулах | 2021 - 2024 | 43.5 | | 41.5 | 2021, онд хүнсний худалдаа эрхэлдэг 148 цэг, нийтийн хоолны 57, түгээлт тээвэрлэлтийн 6, хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг 8 цех, нийт 219 аж ахуй нэгж, иргэн хамрагдаж, 357 зөрчил илрүүлж,105 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч, 12 нэр төрлийн 30 ширхэг бүтээгдэхүүнээс дээж авч ажиллалаа. Хяналт шалгалтын явцад шаардлага хангаагүй 7 нэр төрлийн 269.0 мянган төгрөгийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн буцаан татан авалт хийлгэж, 188 нэр төрлийн 3205.0 мянган төгрөгийн үнэ бүхий чанарын шаардлага хангахгүй бараа бүтээгдэхүүнийг сумын устгалын комисс-т хүлээлгэн өгч учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэн аймгийн хэмжээнд хоол хүнснээс шалтгаалсан өвчлөл хордлого гараагүй болно. 2023 онд хүнсний үйлдвэр 4, хоол үлйвэрлэлийн 10 нийт 14 объектод хяналт шалгалтад хамрагдсан. Хүнсний үйлдвэрийн 33.9 % дунд эрсдэлтэй, хууль тогтоомжийн хэрэгжилт 66.1%-тай, хоол үйлдвэрлэлийн 36 % дунд эрсдэлтэй, хууль тогтоомжийн хэрэгжилт 64% -тай байна. 2021 оны дундажтай харьцуулахад эрсдэл 9 хувиар буурсан байна. 2024 онд Хүнсний үйлдвэр, нийтийн хоол, худалдаалах газрын хяналтын хүрээнд Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу урьдчилан сэргийлэх шалгалт-9, төлөвлөгөөт шалгалт-4, гүйцэтгэлийн шалгалт-8, төлөвлөгөөт бус шалгалт-4 хийсэн. Шалгалтаар нийт 339 объектийг хамруулан хийж 1473 зөрчил илрүүлэн газар дээр нь 78.2 хувийг арилгуулах арга хэмжээ авч улсын байцаагчийн 32 заалттай 3 зөвлөмж, 31 заалттай 14 дүгнэлт, | 100% / 90%<br><br>Хүрэх түвшинг зөв тодорхойлох ( 2021 онд эрсдэлийг 43% хувиар бууруулахаар төлөвлөсөн харагдаж байгаа тул хүрэх түвшинг зөв бичиж тодорхойлох). 2024 оны хэрэгжилтийг бууруулсан эрсдэлийн хувиар тайлагнаагүй. Үнэлгээг бууруулав. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 262 заалттай 30 албан шаардлага хүргүүлэн биелэлт 100 хувьтай хангасан байна. Аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн дэргэдэх итгэмжлэгдсэн лабораторит 14 үзүүлэлтээр 23 нэр төрлийн 54 дээжийг шинжилгээнд хамруулахад эерэг сорьц илрээгүй байна. | |
| 179 | 3.3.5. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээнэ. | 1. Бэлчээрт ашиглаж байгаа худаг, уст цэгийн тооллогыг явуулж байршил, ашиглалт, эзэмшигчийг тодорхойлж бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай болох | 2021 - 2024 | | | | 2020 оны жилийн эцэст аймгийн хэмжээнд нийт 3052 худаг тоологдсоноос гүн өрмийн 765 ширхэг, богино яндант 496 ширхэг, энгийн уурхайн 1786 худаг тоологдсон.2022 онд 3071 худаг тоологдсоноос гүн өрмийн 773 ширхэг, богино яндант 171 ширхэг, бетонон хашлагат 556, энгийн уурхайн 1795 худаг байна. “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох” АДАПТ төслийн хөрөнгөөр 8 сумын 29 цэгт геофизикийн хайгуулын ажлыг Улаанбаатар хотын “Ус амьдрал” ХХК-аар гүйцэтгүүлсэн. Уст цэгийн бүртгэл, тооллогын ажлыг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар, Буйр нуур мэнэнгийн талын сав газар, Голба-Өөш долоодын говь, Хэрлэн голын сав газрын захиргаанууд БХНСАХсангийн 40.0 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн Засаг даргын А/507 тоот захирамжаар усны тооллогын ажлыг хийж хэрэгжүүлээд байна. Урьдчилсан байдлаар аймгийн хэмжээнд 2996 худаг тоологдсоноос гүн өрмийн 989 ширхэг, энгийн уурхайн 2008 худаг байна. | 70% / 70%<br><br>Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин уялдаагүй. 2022-2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. |
| 180 | | 2. Бэлчээрт шинээр гүний худаг гаргах | 2021 - 2024 | 20 | 471 | 40 | 2021-2022 онд Улсын төсвийн хөрөнгөөр 15 худаг, төслөөр 7, түрээсийн өрмийн машинаар 7 цооног гаргасан. Малчид өөрсдийн хөрөнгөөр 33 гүн өрмийн худаг, 51 энгийн уурхай худаг | 100% / 96.25%<br><br>2024 оны хэрэгжилт хүрэх |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гаргасан. 2023 онд 45 гүн өрмийн худаг, 25 энгийн уурхай худаг ашиглалтанд оруулж 97,0 мян га бэлчээрийг усжуулаад байна. 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 16 инженерийн хийцтэй гүн өрмийн худаг /8 цооног/, төсөл хөтөлбөрөөр 8 худаг, орон нутгийн хөрөнгөөр 19 худаг /2 цооног/, малчид өөрсдийн санаачлагаар 21 худаг, уст цэг нийт 64 худгийг ашиглалтанд оруулж 95.0 мянган га бэлчээрт 200.0 мянган толгой малыг усжуулаад байна. 2024 онд Адапт төслийн 546.0 сая төгрөгийн санхүүжилтээр Асгат, Баяндэлгэр,Түвшинширээ, Уулбаян, Халзан, Эрдэнэцагаан, Наран, Дарьганга, Онгон сумдад нийт 15 инженерийн хийцтэй худаг шинээр гаргасан. Малчид 12 энгийн уурхайн худгийг 82.0 сая төгрөгөөр гаргасан. | түвшинд хүрээгүй. 2022-2023 оны хүрэх түвшин ойлгомжгүй. Журмын 6.2.1 |
| 181 | | 3. Бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг зохион байгуулах | 2021 - 2024 | 100 | 158 | 80 | 2021 онд малын тоо толгойн албан татвар гүйцэд төвлөрөөгүйн улмаас оготно устгалын намрын ажил хийгдээгүй. 2022 онд орон нутгийн 110.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бэлчээрийн мэрэгч амьтан үлийн цагаан оготнотой тэмцэх хаврын устгалыг Мөнххаан сум микробиологийн аргаар 3.0 мянган га талбайд 6 тн бактерийн бэлдмэлээр, Онгон сум энгийн механик биологийн аргаар 3.0 га талбайд хийж гүйцэтгэсэн. Намрын устгалыг Баяндэлгэр, Онгон, Түмэнцогт, Түвшинширээ, Асгат сумд микробиологийн аргаар буюу бактерийн хордуулсан будаа захиалан 26.1 мянган га талбайд нийт 32.1 мянган га талбайд тэмцэх арга хэмжээг тус тус зохион байгуулсан. Мөн Онгон сум шувууны 60 ширхэг суултуур, шувууны үүр 40 ширхэг тус тус байршуулсан. Түмэнцогт сум шувууны суултуур, үүр | 100% / 100%<br><br>Суурь болон хүрэх түвшин ойлгүмжгүй тул цаашид анхаарах. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байрлуулах 100 ширхэг шон бэлдсэн. Халзан сум шувууны суултуур 29 ширхэг, шувууны үүр 15 ширхэг, алсыг харагч 10 ширхэгийг тус тус зассан. 2023 онд Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнгээс аймгийн 3,7 сая га бэлчээрт мэрэгч амьтдын тархалт, олшролтын тодотгол хийсэн судалгаагаар 469.0 мян.га талбайд огтоно тархсанаас 200,0 мян га талбайд зайлшгүй тэмцэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан. Тус дүгнэлтийн дагуу ХХААХҮСайдын 2023 оны А/143 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/247 дугаар захирамжаар хавар 12 сумын 11.0 мян.га талбайд микробиологийн аргаар, намрын улсын төсвийн 48.0 сая төгрөгөөр Асгат 5.0 мян.га, Онгон 4.0 мян.га, Сүхбаатар 8.0 мян.га, Эрдэнэцагаан 8.0 мян.га, Баруун-Урт 5.0 мян.га нийт 30.0 мян.га талбайд энгийн механик аргаар тэмцэх ажлыг тус тус зохион байгуулж нийт 82.0 сая төгрөгөөр тэмцсэн. ХХААХҮсайдын 2024 оны А/96 тоот тушаал, аймгийн Засаг даргын А/574 захирамжаар энгийн механик биологийн аргаар 40 мянган га талбайд улсын төсвийн 63.2 сая төгрөгөөр Асгат 5.0 мян.га, Онгон 4.0 мян.га, Халзан 2.0 мян.га, Уулбаян 5.0 мян.га, Түмэнцогт 2.0 мян.га, Сүхбаатар 6.0 мян.га, Түвшинширээ 8.0 мян.га, Баруун-Урт 8.0 мян.га нийт 40.0 мян.га талбайд энгийн механик аргаар тэмцэх ажлыг зохион байгуулсан. | |
| 182 | | 4. Сум дундын болон сумын отрын бүс нутгийг тогтоох, хил заагийг | 2021 - 2024 | Хил заагаар баталгаажсан отрын бүс нутаг | 8 | 8 | Аймгийн Засаг даргын 2020 оны А/411 тоот захирамжаар Сүхбаатар, Наран, Дарьганга, Мөнххаан, Түмэнцогт сумдад 30 байршилд 397779.2 га газрыг сумын отрын нөөц нутгаар тогтоон зураглал мэдээллийн сан үүсгэсэн.2023 | 100% / 100%<br><br>Хүрэх түвшинг оновчтой |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тодорхойлж баталгаажуулах | | байхгүй. | | | онд Эрдэнэцагаан суманд Давхарын тал хэмээх газарт, Асгат сумын Тарвагант хэмээх газарт нийт 71400га газрыг сум дундын отрын бүс нутаг болгохоор шийдвэрлэсэн. Түвшинширээ сумын 2023 оны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 01 дугаар тогтоолоор Үнэгт багийн Майханы хяр орчмын 1152,28 га, Өгөөмөр багийн Лагт орчмын 73462,77 га талбайг тус тус орон нутгийн тусгай хэрэгцээний бэлчээрийн нөөц газарт авсан. | тодорхойлох. |
| 18 3 | | 5. Малчдын бүлгийн оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээх арга хэмжээ хэрэгжүүлэх | 2021 - 2024 | 2 | | 20 | 2021 онд  Сүхбаатар, Халзан, Түвшинширээ, Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Түмэнцогт  сумдад 37 бэлчээр ашиглагчдын хэсэг 2.609.440га бэлчээрийг бэлчээр ашиглуулах гэрээгээр ашиглаж нийт 251 цэгт бэлчээрийг фотомониторингийн аргаар үнэлж бэлчээрийн доройтол, сэлгээх өнжөөх зэргээр арга хэмжээ авч ажилласан.2022 онд  11 суманд МАЛЧДЫН ЗӨВЛӨГӨӨН зохион байгуулж,  бэлчээр ашиглалтыг сайжруулах,  доройтсон бэлчээрийг сэргээх, сэлгэх  талаар 1590 малчдад мэдээлэл хүргэн ажилласан. Сүхбаатар сум "Бэлчээр ашиглах журам" боловсруулан сумын ИТХ-аар баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн  бүртгэлд 5957 дугаарт бүртгүүлсэн. 2023 онд Эрдэнэцагаан, Дарьганга сумдад бэлчээр ашиглагч малчдын бүлгийг байгуулан үйл ажиллагаанд нь арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. 2024 онд Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох чадамж болон эрсдлийн менежментийг сайжруулах нь /АДАПТ/ төсөлтэй хамтран Мөнххаан сумын Наран сарангийн талд 100га хадлангийн талбай хаших ажил хийгдэж улсын комисс хүлээж | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | авсан.ХХААЯ-ны төрийн нарийн бичгийн даргын А/409 дугаар тушаалын дагуу зүүн 3 аймгийн бэлчээрийн менежментийг сайжруулах журмын төслийг боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулахаар бэлэн болгоод байна. | |
| 184 | | 6. Сумдад өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг хадгалах агуулах, саравч шинээр барих ажлыг үргэлжлүүлэх | 2021 - 2024 | 8 | 537.5 | | 2021 онд Онгон, Наран, Мөнххаан сумдад, 2022 онд  Асгат, Баруун-Урт сумдын онцгой үед ашиглах өвс, тэжээлийн агуулах барьсан. 2023 онд Түмэнцогт суманд "Хайлааст гарам"ХХКомпани “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслөөс 70 хувь, сумаас 30 хувь нийт 170,556,529 төгрөгөөр өвс, тэжээлийн агуулах саравчийг шинээр барьж ашиглалтад оруулсан. Мөн Халзан сумын өвс тэжээлийн агуулахын засварын ажлыг "Найдварт жигүүр"ХХКомпани “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн 100 %-ийн санхүүжилтээр 37, 499, 007 төгрөгөөр  хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. 2024 онд Адапт төслийн 359.1 сая төгрөгийн хөрөнгөөр "Молцог элс" ХХК Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт болон Халзан суманд өвс тэжээлийн агуулах хашаа саравчийг шинээр барьж ашиглалтад оруулсан. | 100% / 90%<br><br>2022-2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. Үнэлгээг бууруулав. |
| 185 | | 7. Сумын аюулгүйн нөөцийг бие даан бэлтгэх хүрээнд зарим | 2021 - 2024 | | 341.9 | | 2021 онд Баруун-Урт суманд трактор 2ш, 2 иртэй хадуур 2ш, хаман боогч 1 ширхэг, 2022 онд Баруун-Урт, Мөнххаан, Түмэнцогт, Наран сумдад 9 ширхэг өвс хаман боогчийг тус тус түрээс хэлбэрээр ашиглуулахаар гэрээ | 100% / 90%<br><br>2022-2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сумдад хадлан бэлтгэлийн техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх | | | | | байгуулсан. Мөн Сүхбаатар сум том, жижиг трактор тус бүр 1 ширхэг, хаман боогч, хадуур, тармуур зэрэг хадлангийн иж бүрэн тоног төхөөрөмж худалдан авсан. Түүнчлэн ХААДСангаас Онгон сум 110.0 сая төгрөгний хадлангийн иж бүрдэл /трактор, хадуур, тармуур, пресс/-ийг 2 жилийн хугацаатай эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр авсан. 2023 онд"Шинэ хөдөө" төслийн 111.9 сая төгрөгийн хөрөнгөөр "Агротрак"ХХК хадлан бэлтгэлийн дөрвөлжин хаман боогч 2 ширхэгийг нийлүүлж, Дарьганга, Баруун-Урт сумдад техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн."Шинэ хөдөө" төслийн хөрөнгөөр 2022 онд худалдан авсан ТУКАН-1500 маркын өвс хаман боогчийг түрээсийн гэрээгээр ашиглуулахаар нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Сонгон шалгаруулалтын үр дүн Түмэнцогт сумын хадланч иргэн аймгийн аюулгүйн нөөцөд 2 жил дараалан 2250 боодол өвс түрээсээр өгөхөөр гэрээ байгуулсан. | 2024 оны хэрэгжилт тодорхойгүй. Үнэлгээг бууруулав. |
| 186 | 3.3.6. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулах, хээлтүүлэгч болон цөм сүргийг мэргэжлийн байгууллагын хяналтад авах, генетик | 1. Жил бүр үржлийн малын 1-ээс доошгүй хувьд үзлэг ангилалт тогтмол хийж, ээмэгжүүлэн, бүртгэл мэдээллийн санд оруулах | 2021 - 2024 | 2019-2020 онд 8800 толгой мал | | 18000 | Үржлийн малын 1 хувьд үзлэг ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг жил бүр тодорхойлдог. 2021 онд 23232 толгой, 2022 онд 38264 толгой, 2023 онд 13502 малд үзлэг ангилалт хийсэн. 2023 онд 6517 малыг ээмэгжүүлэн,бүртгэл мэдээллийн санд оруулсан.2024 онд улсын төсвийн 23.4 сая төгрөгөөр Асгат, Баяндэлгэр, Түмэнцогт, Наран, Эрдэнэцагаан, Баруун-Урт сумдын 14320 толгой малд үзлэг ангилалт хийж, бүртгэл мэлээллийн санд оруулах ажил хийгдэж байна. | 100% / 93.75%<br><br>Журмын 6.2.1 |
| 187 | | 2. Хавар, намар малд хийх үзлэг | 2021 - 2024 | 3 | 44.9 | 13 | 2021 онд Аймгийн хэмжээнд одоогийн байдлаар нийт 10415 толгой малд үзлэг ангилалт хийж | 100% / 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нөөцийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, нэгжийн ашиг шимийг дээшлүүлнэ. | ангилалтад хяналт тавьж, үр дүнг тооцох | | | | | оны эхний нийт малын 23.2 хувь болох 1079860 толгой үржилд тэнцэхгүй болон эр сувай малыг эдийн засгийн эргэлтэд оруулах тооцоо гарсан. 2022 онд Жилийн эцсийн мал тооллогод үндэслэн дутагдах хээлтүүлэгчийг тооцон нөхөн тавих талаар үүрэг чиглэлийг мэргэжлийн байгууллагад өгснөөр 741 толгой бог малын хээлтүүлэгч шинээр нөхөн тавьж хээлтүүлэгийн ажлыг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд нэг хуцанд 67 эм хонь, нэг уханд 68 эм ямаа оногдож 5643 толгой хуц, 3543 толгой ухна нийт 9186 толгой бог малын хээлтүүлэгч дутагдалтай гэсэн судалгаа гарсан. 2023онд 3082 хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад хамруулаад байна. 2024 онд ХХААХҮ-ийн сайдын 2024 оны А/136 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгөөр Асгат, Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Наран, Баруун-Урт, Түмэнцогт сумдын 14320 толгой үхэр, хонь, ямаанд, орон нутаг, малчид иргэдийн хөрөнгөөр үржлийн малын 1 хувиас доошгүй малд үзлэг ангилалт хийж генетик нөөцийн төлөв байдлын тодорхойлох, үнэлэх ажлыг хийж байна. | Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. 3.3.6.1-р арга хэмжээний хэрэгжилтийг давтан тайлагнасан. Журмын 6.2.1 |
| 188 | | 3. Эрчимжсэн МАА-г хөгжүүлэх зорилгоор малыг шахан бордох цэгийг орон нутагт турших | 2021 - 2024 | | 75 | | 2021 онд Зах зээл бэлчээрийн удирдлага төслөөс махны чиглэлийн үхрийн бордооны аж ахуй эрхлэх "Арга түшиг" ХХК-д 75.0 сая төгрөгийн зээлийг олгосон. Сүхбаатар сумын "Манхат баян уул" ХХК, Баруун-Урт сумын "Арга түшиг" ХХК-иуд 100 эр бяруу бордож эхэлсэн.Сүхбаатар, Түмэнцогт, Мөнххаан сумдад Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлыг хамгаалах төслөөс байгалийн ургамлыг даршлах, гар тэжээл бэлтгэх сургалтыг сумын төвд 120 малчин оролцуулан | 90% / 50%<br><br>Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. Хэрэгжилтийг зөв бичиж тайлагнах. 2022-2023 оны хэрэгжилт хангалтгүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохион байгуулсан үүний үр дүнд 11,5 тн ногоон тэжээл даршилсан. 2024 онд Сум бүр гар тэжээл бэлтгэх талаар малчид, мал бүхий иргэддээ үүрэг чиглэл өгч ажилласнаар аймгийн хэмжээнд 204 тн гар тэжээл бэлтгэсэн.Уулбаян сумын "Агула мөнх агро" ХХК нь Баруун-Урт сумын Одкон хотхонд мах махан бүтээгдэхүүний нэрийн дэлгүүр байгуулан хаврын хүн амын хүнсний хэрэгцээнд зориулж 140 бяруу шахаж бордон худалдан борлуулсан.Адапт төслийн хүрээнд өвс хэрчигч,тэжээл бутлагч машиныг ногоон тэжээл тариалсан 8 хоршоонд олгохоор хуваарилалт хийж хүлээлгэн өгсөн. | Журмын 6.2.2.3-р үнэлэв. |
| 189 | | 4. Бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад бүрэн хамруулж анги чанарыг тодорхойлох ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | 664 | 24.2 | 27500 | 2021, 2022онд 13 сумын 23380 толгой малд ангилалт хийж ээмэгжүүлсэн. 2022 онд 741 толгой бог малын хээлтүүлэгч шинээр нөхөн тавьж хээлтүүлэгийн ажлыг зохион байгуулж байна. Аймгийн хэмжээнд нэг хуцанд 67 эм хонь, нэг уханд 68 эм ямаа оногдож 5643 толгой хуц, 3543 толгой ухна нийт 9186 толгой бог малын хээлтүүлэгч дутагдалтай байна. 2023 онд 3082 хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад хамруулаад байна. 2024 онд ХХААХҮ сайдын 2024 оны А/136 дугаар тушаалаар сгат, Баяндэлгэр, Наран, Эрдэнэцагаан, Баруун-Урт сумдын хонь-5200, ямаа-5120 нийт 10320 толгой малд үзлэг ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлсон. | 100% / 70%<br><br>Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшиний дагуу тайлагнах. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. |
| 190 | | 5. Бог малын хээлтүүлэгчийг бүрэн ээмэгжүүлж, мэдээллийг | 2021 - 2024 | 0.9 | 2.5 | 2.5 | 2021- 2022 онд 23380 толгой бог малыг ээмэгжүүлж бүртгэл, мэдээллийн санд оруулсан. ХХААХҮСайдын А/473 дугаар тушаал, Үржлийн малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах тухай аймгийн Засаг даргын | 90% / 70%<br><br>2024 оны хэрэгжилт 3.3.6.4-тэй ижил |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулах | | | | | 2023 оны А/562 дугаар захирамжийн дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 13 сумын 22325 толгой хээлтүүлэгчийг ангилалтад хамруулахаар 9 МҮТАҮНэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан. одоогийн байдлаар Баяндэлгэрийн улаан үүлдрийн ухна 2593толгой, Үзэмчин үүлдрийн хуц 5760толгой нийт 8353 толгой хээлтүүлэгчийг ялган тэмдэглэж, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх ажлыг зохион байгуулаад байна.2024 оны ХХААХҮ сайдын А/136 дугаар тушаалаар 4 сумын хонь-5200, ямаа-5120 нийт 10320 толгой малд үзлэг ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ажил хийгдэж байна. | тайлагнасан. Эзэмгжүүлсэн хээлтэгч малын эзлэх хувь тодорхойгүй. |
| 19<br>1 | | 6. Мал үржүүлэг технологийн нэгж болон шинээр байгуулагдсан аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагаагаа эхлүүлэхэд нь нэг удаагийн дэмжлэг үзүүлэх /Дэмжлэг: хуцан хурга, ухна ишиг/ | 2021 - 2024 | 4 | 70.7 | 5 | 2021 онд Түмэнцогт суманд мал үржүүлэг технологийн нэгж шинээр байгуулах 1 иргэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласны үр дүнд "Баян сүрэг" МҮТАҮН /мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж/ шинээр байгуулагдсан. Баруун-Урт сумын “Билүүт өсөх” хоршоо үйл ажиллагаагаа сэргээн ажиллаж эхэлсэн. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 5 МҮТАҮН, бүх сумдын ХАА-н тасагт мал ангилалтын багаж /палкметр, лентметр, ээмэгний бахь/ 13 суманд бод малын үзлэг ангилалтын зогсоол олгосон. 2022 онд Наран, Баяндэлгэр сумдад МҮТАҮНэгж шинээр байгуулагдсан. Түмэнцогт сумын "Баян сүрэг" ХХК, Мөнххаан сумын “Баясгалант сүрэг” ХХК, Баруун-Урт сумын “Билүүт өсөх” хоршоо болон Мөнххаан сумын хөдөө аж ахуйн тасагт мал ангилалтын багаж, тоног төхөөрөмж болох бог малын хашаа, пүү, палкметр, лентметр, ээмэгний бахь, Сүхбаатар, Мөнххаан, | 100% / 85%<br><br>2024 онд Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. Журмын 6.2.1 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Түмэнцогт сумдын МҮТАҮНэгжид тус бүр 65 толгой үзэмчин үүлдрийн хурган хуц болон 50 толгой Баяндэлгэрийн улаан ишгэн ухныг тус тус ДМХХТЛБОЯБХТөслөөс олгосон. Мөн ХХААХҮЯамнаас 13 сумын Хөдөө аж ахуйн тасагт бог малын палкметр, лентметр, өргөдөг килограмм олгосон. 2023 онд ХХААХҮСайдын "Бог малын хээлтүүлэгч нийлүүлэх хуваарь батлах тухай" А/198 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/564 тушаалаар "Бог малын хээлтүүлэгч хүлээн авах тухай" комисс томилогдсон. Тус ажлын хүрээнд Баяндэлгэрийн Улаан үүлдрийн ухна 30 толгой, Үзэмчин үүлдрийн хуц 30 толгой хээлтүүлэгчийг "Баруун бүслүүр" ,"Билүүт өсөх" хоршоодоос авсан. Авсан 60 толгой хээлтүүлэгчийг Наран сумын Авшигт сүрэг ХХК -д 16 хуц, Мөнххаан сумын Баясгалант сүрэг ХХК-д 14 хуц,, Баруун-Урт сумын "Шавхагдашгүй баялаг" ХХК-д 30 толгой шүдлэн ухныг гэрээ байгуулан хүлээлгэж өгсөн. 2024 онд ХХААХҮЯ/202212046 тоот гэрээний дагуу 28.0 сая төгрөгний санхүүжилтээр Шавхагдашгүй баялаг ХХК МҮТАҮН-д 50 толгой, Түмэнцогт сумын ОНӨАТҮГ-т 30 толгой хуц ухныг тус тус гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн. | |
| 192 | | 7. Сумдын ХАА-н тасгийн малын бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтнийг бүртгэл мэдээллийн нэгдсэн сан | 2021 - 2024 | 2 | 285.4 | 13 | 2021 онд Баяндэлгэр, Мөнххаан, Халзан сумдын ЗДТГазар ХАА-н тасгийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтний компьютерт шинэчлэл хийсэн.13 сумын Хөдөө аж ахуйн тасгийн компьютерт малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн программыг суулгаж хариуцсан мэргэжилтэнгүүдийг сургалтанд | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үүсгэх боломж бүхий компьютер, тоног төхөөрөмжөөр хангах | | | | | хамруулсан.2022 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын STREAM төсөлтэй хамтран “Зүүн бүсийн аймгуудын малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, түүний дэд сангуудын нэвтрүүлэлт” сэдэвт зохион байгуулагдсан сургалтад ХХААГазраас МҮАлбаны дарга, 2 мэргэжилтэн, 13 сумын ХАА-н тасгийн Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэнүүд, Мал үржүүлэг технологийн ажил, үйлчилгээний 6 нэгжийн дарга нар нийт 22 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. 2024 онд "Шинэ хөдөө" төслийн хүрээнд13 сумын багийн дарга нар болон хөдөө аж ахуйн тасгийн 16 малын үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэнүүд зөөврийн компьютероор хангагдсан.Мөн малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программ хөгжүүлэлтийн талаарх аймаг сумын мэргэжилтэнүүдийг чадавхижуулах 4 хоногийн вакум сургалтанд 9-н сумын үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэнүүдийг хамрууллаа. | |
| 193 | 3.3.7. Өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үүлдрийн үхэр, гахай, шувууны эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, ашиг шимийг нь | 1. Цэвэр үүлдрийн болон эрлийз, цус сайжирсан малын тоог нэмэгдүүлэн гадаадын өндөр ашиг шимт эцэг малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг | 2021 - 2024 | 50 | | 350 | 2023 онд аймгийн хэмжээнд Дорнод монголын улаан үүлдрийн үхэр, Үзэмчин үүлдрийн хонь, Баяндэлгэрийн улаан үүлдрийн ямааг бие даасан үүлдрээр батлуулан өсгөн үржүүлж байна. 2022 оны жилийн эцэст Дорнод монголын улаан үүлдрийн цэвэр болон эрлийз, сайжирсан үхэр нийт үхрийн 14.6 хувь болох 49776 толгой, Үзэмчин үүлдийн цэвэр болон эрлийз, цус сайжирсан хонь нийт хонины 52.0 хувь болох 1252999 толгой, Баяндэлгэрийн улаан үүлдрийн цэвэр болон эрлийз, сайжирсан ямаа нийт ямааны 64.9 хувь болох 962585 | 100% / 58.29%<br><br>Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. Журмын 6.2.1 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлнэ. | хийх/тариф-50.0 ₮/ | | | | | толгой тус тус тоологдсон. Өндөр ашиг шимт Ангус, Герефорд, Симменталь, Алатау, Хар тарлан үүлдрийн бухны гүн хөлдөөсөн үрээр Баруун-Урт, Түмэнцогт, Сүхбаатар сумдын 35 иргэн, аж ахуй нэгжийн 170 толгой үнээнд, махны чиглэлийн суффолк хуцны халуун үрээр Мөнххаан сумын 160 хонинд зохиомол хээлтүүлэг хийсэн. 2024 онд өндөр ашиг шимт малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийлгэх хүсэлтэй иргэн, ААН-ийн төлөөллийг оролцуулан зохиомол хээлтүүлэгийн ач холбогдолын талаарх сургалт хийж, захиалга авах ажлыг зохион байгуулсан. Малын удмын сангийн үндэсний төвөөс махны чиглэлийн Хар ангус, Герефорд, сүүний чиглэлийн Хар тарлан, хосолмол ашиг шимт Алатоу, Семминталь үүлдрийн бухны гүн хөлдөөсөн 300 тун үрийг татан авч Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулдаг "Шавхагдашгүй баялаг" ХХК мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжтэй хамтран Билүүт хэмээх газар суурилан  Ангус, Симменталь, Алатау үүлдрийн бухны гүн хөлдөөсөн үрээр 35 үнээнд,зохиомол хээлтүүлэг хийсэн.Мөн Нэмэр-Их ХХК нь Алатау, Симментал, Хар улаан ангус, Лимузин үүлдрийн бухны гүн хөлдөөсөн үрээр 50 үнээнд зохиомол хээлтүүлэг хийсэн. ДМТЛБОЯБХ төслийн хүрээнд Сүхбаатар суманд 22 иргэний 104 үнээнд, Түмэнцогт суманд 15 үнээнд  Алатау, Симменталь, Ангус үүлрийн бухны гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн. | |
| 194 | | 2. Гойд ашиг шимт малын үзэсгэлэн | 2021 - 2024 | | | 1 | 2021 онд Мал амьтны халдварт өвчин гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 09-р сарын 22-ны өдрийн | 90% / 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | худалдааг жил бүр зохион байгуулах | | | | | захирамжаар “Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, хяналт тавих” тухай захирамж гарсан тул уг ажил хийгдээгүй. 2022 онд Намрын ногоон өдрүүд- Сүхбаатарт үйлдвэрлэв 2022 ШИЛМЭЛ МАЛ үзэсгэлэн худалдааг Баруун-Урт хотноо амжилттай зохион байгуулсан. “Бог мал”-ын төрлөөр нийт 8 сумын 15 иргэн, 5 ААН-ийн 128 толгой мал оролцсон. Үзэмчин үүлдэр, Баяндэлгэрийн улаан үүлдэр, Импорт болон зохиомол хээлтүүлгээр гаргаж авсан мал гэсэн 3 төрөлд бүдүүн хуц, төлгөн хуц, эм хонь гэсэн ангилалаар 30 номинацыг шалгаруулж байр эзлүүлсэн.2023 онд хонины мялзан өвчин аймгийн хэмжээнд 4 суманд гарсан учир үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаагүй . 2024 оны 9-р сарын 20-21-ны өдрүүдэд малчдын орлогыг нэмэгдүүлэх, малын хээлтэгч хээлтүүлэгчийн тохироог бүрдүүлэх зорилгоор Намрын ногоон өдрүүд-Сүхбаатарт үйлдвэрлэв арга хэмжээний хүрээнд “Шилмэл малын 2024” үзэсгэлэн худалдааг Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт хотод зохион байгуулсан. Нийт 9 сумын 21 иргэн, 9 аж ахуй нэгжийн 130 гаруй толгой мал оролцсон. Уг үзэсгэлэн худалдаа нь Махны чиглэлийн үхэр, Сүүний чиглэлийн үхэр, Үзэмчин үүлдрийн хонь, Баяндэлгэрийн улаан үүлдрийн ямааны хээлтэгч, хээлтүүлэгч гэсэн төрлөөр явагдсан. Төрөл тус бүр дээр тэргүүн, дэд, тусгай байр эзлүүлсэн. Гойд ашиг шимт малаар 16, тусгай байрын өргөмжлөлөөр 8 малыг шалгаруулж, медаль, өргөмжлөл,тууз, мөнгөн шагналыг гардуулсан. | |
| 19 | | 3. Эрчимжсэн аж ахуй | 2021 - | | 979.6 | | 2021 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Түмэнцогт сумын 1 иргэнд эрчимжсэн аж ахуйн | 100% / 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | | эрхлэгчийг дэмжих | 2024 | | | | чиглэлээр 3.0 сая, сум хөгжүүлэх сангаас Баруун-Урт сумын 3 иргэнд мах, сүүний эрчимжсэн аж ахуйн чиглэлээр 68.0 сая, Баяндэлгэр сумын 1 иргэнд гахай, тахианы аж ахуй эрхлэх чиглэлээр 10.0 сая төгрөгний зээлийг олгосон. 2022 онд ЖДҮ хөгжүүлэх сангаас Баруун-Урт сум эрчимжсэн аж ахуйн чиглэлээр 1 нөхөрлөлд 72.4сая/төг, Хоршоо хөгжүүлэх сангаас  Сүхбаатар сум Тахианы аж ахуй байгуулах чиглэлээр 1 хоршоонд 85 сая/төг, Онгон сум малын хашаа, мах сүүний үхэр үржүүлэх чиглэлээр 1 ААН-д 10 сая/төг, Асгат сум эрчимжсэн аж ахуйн чиглэлээр 1 ААН-д 60сая/төг, ДМХХТЛБОЯБХТөслөөс Сүхбаатар сумын “Манхат баян уул”ХХК-д эрчимжсэн аж ахуйн чиглэлээр /үйл ажиллагаа өргөтгөх/ 75 сая/төг, нийт аймгийн хэмжээнд 4 сумын 5 аж ахуй нэгж эрчимжсэн аж ахуйг дэмжих чиглэлээр 302.5 сая төгрөгийн зээлд хамрагдсан. 2023 онд "Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгодог хөнгөлөлттэй зээлд гахайн аж ахуй эрхлэх чиглэлээр 1, эрчимжсэн аж ахуй эрхлэх 2, өсвөр хээлтүүлэгч бойжуулах аж ахуй байгуулах чиглэлээр 1 нийт 4 аж ахуй нэгжид 596,1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. 2024 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд эрчимжсэн аж ахуйн чиглэлээр 3 аж ахуй нэгжид 567.5 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэгдсэн. Үүнд: ( Халзан сумын “Арга түшиг” ХХК махны үхрийн аж ахуйг өргөжүүлэхэд 100.0 сая төгрөг, Баруун-Урт сумын “Ашид баян арвижих дүүрэн” ХХК мах сүүний хосолмол үхрийн ферм байгуулах 187.5 сая төгрөг, Баяндэлгэр сумын “Жигүүр ундрага” ХХК сүү махны үхрийн аж ахуй эрхлэхэд 280.0 | 2022-2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. Үнэлгээг бууруулав. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сая төгрөг) | |
| 196 | | 4. Үйлдвэр технологийн паркийн үйл ажиллагааг өргөтгөж, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах төв байгуулах | 2021 - 2024 | 1 | 600 | | "Үйлдвэрлэлийн дэд бүтцийг хөгжүүлж, үйлдвэрлэл технологийн паркын үйл ажиллагааг өргөтгөх, зорилгын хүрээнд “Сүхбаатар хөгжил ҮТП” ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэлийн нэгдүгээр бүсэд улсын төсвийн нийт 2,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий дэд бүтэц, хоногт 500 литр сүү боловсруулах сүүний үйлдвэрийн барилгын ажлыг 2024 онд хийж гүйцэтгээд байна. Тус сүүний үйлдвэрийг 2025 онд ашиглалтанд оруулахаар НҮБ-н хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах төсөлтэй хамтран тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулан ажиллж байна. Мөн үйлдвэр технологийн паркын үйлдвэрлэлийн хоёрдугаар бүс болох хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийн зураг төслийн ажлыг орон нутгийн 200 сая төгрөгийн санхүүжилтээр ""Ланд овнер"" ХХК компани гүйцэтгэж хүлээлгэн өгөөд байна. " | 90% / 70%<br><br>2022-2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. Журмын 6.2.2.2 |
| 197 | 3.3.8. Малын гоц халдварт, халдварт, зооноз, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлж, малын өвчнөөр тайван бүсийг тогтооно. | 1. Үхрийн цээж, ямааны годрон өвчнөөр тайван байдлыг баталгаажуулах /хувиар/ | 2022 - 2024 | 1 | - | баталгаажуулалт хийж үр дүнг тооцох | УМЭАЦТЛ, Мал эмнэлгийн хүрээлэнтэй хамтран жил бүр (2018-2022 он) дээж цуглуулж тандалт шинжилгээг хийж хэрэгжүүлснээр 2022 оны 05 дугаар сарын 25-нд Монгол улсын хэмжээнд "Үхрийн цээж өвчнөөр эрүүл, тайван" байдлыг баталгаажуулсан гэрчилгээ авсан. Үхрийн цээж өвчин нь ДМАЭМБ-аас зарласан олон улсын худалдааны хорио цээрт 6 өвчний нэг бөгөөд гоц халдварт өвчин юм. Мөн ямааны годрон өвчнөөр эрүүл тайванг баталгаажуулах шинжилгээнд 2022-2024 онд жил бүр 120 ямаанаас дээж авч Дэлхийн МАЭМ-ийн байгууллагад хүргүүлэн эрүүл тайван байдлаа | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хадгалан ажиллаж байна. | |
| 198 | | 2. Халдварт зоонози өвчний гаралтыг багасган уг өвчнөөр тайван, халдваргүй бүсээр баталгаажуулах | 2021 - 2024 | | | Баталгаажуулалтын ажлын хэсэг ажиллах | 2021-2022 онд Түмэнцогт сумын Хар ганга, Хан хөхий, Тарнат холбоо зэрэг 3 малчны бүлгийн 12 өрхийн мал сүргийг гоц халдварт, халдварт зоонози өвчингүй, тайван нутаг дэвсгэрийг тогтоон шүлхий, мялзан, цэцэг, үхрийн сүрьеэ, бруцеллёз өвчнүүдээс эрүүл тайванг баталгаажуулан батламж өгсөн. 2021-2024 онуудад Түмэнцогт сумын батламж авсан 12 өрхийн 360 мал сүрэгт тандалт шинжилгээг тогтмол хийж, гоц халдварт, халдварт өвчин гараагүй эрүүл тайван байдлаа хадгалан ажиллаж байна. | 100% / 70%<br><br>Шалгуур үзүүлэлт тодорхойлоогүй. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй (Халзан суманд судалгаа хийгдсэн эсэх). |
| 199 | | 3. Эрсдэлт бүс нутгийн өвчлөмтгий мал сүргийг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд бүрэн хамруулах | 2021 - 2024 | 3.5 - 3.5 | | 3.6 - - | "2021-2024 онуудад эрсдэлт бүс нутгийн өвчлөмтгий мал сүргийг жил бүр гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулан ажилласан.Үүнд: 1.Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад жилд 1 удаа бүх хонь, хурганд давхардсан тоогоор 3.6 сая хонь 2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг жилд 2 удаа бүх үхэр сүргийг хамруулан нийт 4 жилд 2.2 сая үхэрт 3. Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 2021-2023 онд эрсдэлт нутгийн 394.8 мянган үхрийг 4. Бог малын мялзан өвчний дархлаажуулалтад 2.6 сая бог малыг тус тус хамруулсан. " | 100% / 70%<br><br>Суурь болон хүрэх түвшинг ойлгомжгүй тодорхойлсон. Хэмжих нэгж тодорхойгүй. Вакжинжуулалтын урамшуулалтай холбоотой хэрэгжилт тайлагнаагүй. Төлөвлөлтийг оновчтой хийх. |
| 200 | | 4. Шимэгчтэх өвчний халдварлалтыг бууруулах | 2021 - 2024 | 26 | | 15 | 2021-2024 онд угаалга, тулгалт, боловсруулалтын арга хэмжээг жил бүр сумдад даалгавар өгч ажиллаж ирсэн ба жилд нийт малын 85,6-98,9 %-ийг хамруулан шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлснээр өвчний | 100% / 9.09%<br><br>Арга хэмжээний хэрэгжилт суурь түвшинд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | халдварлалт, дэгдэлт 25 %-иар буурсан. | хүрээгүй. "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1-ийг үндэслэв. |
| 201 | | 5. Бэлчээрийн эрүүл ахуйг сайжруулах хүрээнд ариутгал, халдваргүйтгэл хийх | 2021 - 2024 | 3.3 | | 4 | Орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээг сум, орон нутагт ажиллаж байгаа анхан шатны Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, тасаг, сумдын Засаг даргын тамгын газар, Онцгой комиссын гишүүд, малчид, малын эмч нарын хүчээр хийж хэрэгжүүлэн ажиллаж, хашаа хороо, өтөг бууц, худаг уст цэг, тээврийн хэрэгсэл, нийтийн эзэмшлийн талбай зэргийн нийт давхардсан тоогоор жилд 2.8-3.8 сая м.кв талбайд халдваргүйтгэлийг хийж, 300.0 мянгаас 1.8 сая толгой хүүр сэг зэмийг цуглуулан устгалын цэгт устгасан. | 100% / 71.43%<br><br>Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1-ийг үндэслэв. |
| 202 | 3.3.9. Мал эмнэлгийн | 1. Мал эмнэлгийн | 2021 - 2024 | 60.0 - | 299.1 | МЭЛ-д леминар бокс, суурин | 2021-2024 онуудад Мал эмнэлгийн газрын орчин нөхцлийг сайжруулахаар мал эмнэлгийн | 100% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | лабораторийн орчин нөхцөлийг сайжруулж, хувийн хэвшлийн мал эмнэлгүүдэд стандарт мөрдүүлнэ. | газрын барилгад их засвар хийж, лабораторийг техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх | | | | шатаах зуух, стандартын ширээ сандалтай болгох | лабораторид барилгын цахилгаан мантажны их засварт 12.0 сая төгрөг, дуудлага үйлчилгээний 4 машины гражын дээврийн засварт 6.0 сая төгрөг, мал эмнэлгийн газрын барилгын дээврийн их засварт 15.0 сая төгрөг, байгууллагын гадна гэрэлтүүлэгийг нэмэгдүүлэхэд 10.0 сая төгрөг, Мал эмнэлгийн лабоарторийн оношлогоо шинжилгээний чадавхыг сайжруулах, хүн амыг эрүүл хүнсээр хангахад зориулан эмийн үлдэгдэл, биохимийн аппарат бусад техник тоног төхөөрөмж авахад 68.1 сая төгрөг, лабораторийн аюултай хог хаягдлын устгалд 30,0 сая төгрөг нийт 141,1 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгаас санхүүжүүлж ажилласан. Мөн гамшгаас хамгаалах нөөц сангаас олон жил хадгалагдаж байсан химийн хортой бодис устгахад 123,0 сая төгрөг, ариутгалын бодис бусад хэрэгсэлд 35,0 сая төгрөг тус тус гарсан. Нийт 299.1 сая төгрөгийн зардалтай 8 үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. | Шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжилтийг тайлагнаагүй. Хүрэх түвшинтэй холбоотой хэрэгжилт тодорхойгүй. |
| 203 | | 2. Сум дундын мал эмнэлэг, ариун цэврийн анхан шатны лаборатори байгуулах (АИТХ-ын 2023 оны 7-р тогтоолоор хассан) | 2021 | | | Сум дундын мал эмнэлгийн жишиг лабораторитой болсон байна. | (АИТХ-ын 2023 оны 7-р тогтоолоор хассан) | 89% / 89% |
| 204 | | 3. Цахим системийн ашиглалтыг | 2021 - 2024 | 65 | | мал эмнэлгийн нэгдсэн системийг аймаг | 2021-2024 онд Мал эмнэлгийн нэгдсэн цахим системийн хэрэгжилтийг сайжруулах, халдварт өвчнийг эрт илрүүлэх талаар мал эмнэлгийн | 100% / 90%<br><br>2024 оны |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | чанаржуулж, мал эмнэлгийн бүх ажил үйлчилгээг нэгдсэн системд оруулах | | | | сумын удирдлагын түвшинд дотоод шүлжээгээр холбогдон нэгтгэх. | тасаг, үйлчилгээний нэгжүүдэд бүсчилсэн байдлаар сургалтыг Мөнххаан, Дарьганга, Түвшинширээ, Баруун-Урт сумдад зохион байгуулж нийт 48 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид "Samsung Tab A" маркийн таблет олгосон. 2023 оноос МЭНС 2.0 шинэчлэсэн хувилбар улсын хэмжээнд нэвтэрснээр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн 53, мал эмнэлгийн тасгийн 22, Мал эмнэлгийн газрын 10, мал төхөөрөх болон боловсруулах 12 үйлдвэрийн 13 нийт 98 малын эмч нарын бүртгэлжүүлэн, үйл ажиллагааны хэрэгжилтэд мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч нар хяналт тавин ажиллаж байна. Тус цахим системд мал эмнэлгийн бүх төрлийн үйлчилгээ (урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мал амьтны отор нүүдэл шилжилт хөдөлгөөн, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олголт)-г бүртгэгдсэн. Тус цахим систем нэвтэрснээр малын хулгайтай тэмцэх чиглэлээр Цагдаагийн байгууллага хамтран ажилладаг. | хэрэгжилт тайлагнаагүй. |
| 205 | 3.3.10. Шинэ технологи, инновацын ололтод суурилсан эдийн засгийн үр ашигтай орон нутгийн эко бизнес, хөнгөн үйлдвэрлэл, худалдаа, | 1. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг орон нутаг, улс, олон улсын түвшинд сурталчлан таниулах зорилготой цахим | 2021 - 2024 | Цахим катологийн туршилтын ажил 2020 онд хийгдсэн | | 100 | "Зүүн бүсийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих нь төслийн хүрээнд Зүүн бүсийн аймгуудын аж ахуйн нэгжид үйлдвэрлэж байгаа хүнсний болон бусад бараа таниулах зорилготой "Mon biz" каталоги системийг боловсруулан Жижиг дунд үйлдвэрийн газарт хүлээлгэн өгсөн. Цахим катологит орон нутгийн бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилан таниулах зорилгоор хөтлөн явуулж байна. | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээг хөгжүүлнэ. | катологийг ашиглалтад оруулах | | | | | | |
| 206 | | 2. Хөнгөн үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах гадаад, дотоодын зах зээлийг өргөтгөх ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | 4.7 | | 7.3 | Баруун-Урт сумын "Мөнх сайн гүд" ХХК-нь бэлэг дурсгалын бүтээгдэхүүндээ оюуны өмчийн патент авахаар ажиллаж байна.2022 онд Нэгдсэн Үндсэний Байгууллагын Ерөнхий ассемблейгаас жил бүрийн 06 сарын 27-ны өдрийг "Дэлхийн жижиг дунд үйлдвэрийн өдөр" болгон тэмдэглэдэг бөгөөд тус өдрийг тохиолдуулан жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчилан таниулах, зах ээзлийг тэлэх борлуулалтыг дэмжих зорилгоор Жижиг дунд үйлдвэрийн газраас "Дэлхийн жижиг дунд үйлдвэрийн өдөр-2022" арга хэмжээг Улаанбаатар хотноо 2022 оны 06 сарын 24-өөс-27-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Энэ арга хэмжээнд Чамбай фейшн" оёдлын цех оёмол бүтээгдэхүүнээр амжилттай оролцсон. . 2022 оны 10 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 272240.3 сая төгрөг, хөнгөн үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2725,4 сая төгрөг буюу 1 хувь, хүнсний үйлдвэрлэлийн салбарын нийт үйлдвэрлэл 13859.5 сая төгрөг буюу 5 хувь байна. Дотоодын салбарын нийт үйлдвэрлэл 11967.4 сая төгрөг буюу 1 пунктаар өссөн байна. 2023 онд Нэгдсэн Үндсэний Байгууллагын Ерөнхий ассемблейгаас жил бүрийн 06 сарын 27-ны өдрийг "Дэлхийн жижиг дунд үйлдвэрийн өдөр" болгон тэмдэглэдэг бөгөөд тус өдрийг тохиолдуулан жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа | 70% / 50%<br><br>Аж үйлдвэрийн салбарт хөнгөн үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүний эзлэх хувиар хэрэгжилтийг тайлагнаагүй. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчилан таниулах, зах зээлийг тэлэх борлуулалтыг дэмжих зорилгоор Жижиг дунд үйлдвэрийн газраас "Дэлхийн жижиг дунд үйлдвэрийн өдөр-2023" арга хэмжээг Улаанбаатар хотноо 2023 оны 06 сарын 26, 27, 28-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Энэ арга хэмжээнд " Бумбат Алтан шаглаа" хоршоо оёмол бүтээгдэхүүнээр оролцсон. 2024 онд Улаанбаатар хотод Монгол Улсад “БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ӨДӨР 2024” үзэсгэлэн, "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалд Баруун-Урт сумaнд үйл ажиллагаа явуулж буй Чулуун Дарь овоо ХХК буюу Баян шарга Арьсан эдлэлийн үйлдвэр нь 10 гаруй нэр төрлийн арьсан бүтээгдэхүүнтэй оролцож борлуулалт хийсэн. | |
| 207 | 3.3.11. Оюуны өмчийн патент, чанар стандартын баталгаатай орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ. | 1. Бүтээгдэхүүн, үйлчилгээний оюуны өмчийн патент, чанар стандартыг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагын зөвлөн туслах үйлчилгээг бизнес эрхлэгчдэд хүргэх ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | 2 | | 4 | " Өнөөдрийн байдлаар Цайрт минерал ХХК нь ISO 14001 байгаль орчны олон улсын стандарт, ISO 45001 олон улсын хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартыг нэвтрүүлсэн. Дарь шүтээн ХХК, Дөрвөн гэгээн эрдэнэ ХХК нь ISO 9001, олон улсын удирдлага, ISO 22000 HACCP стандартыг 2022 онд нэвтрүүлсэн. Баруун-Урт сумын ""Хийморьт Агшуун"" ХХК нь 2023 онд шинэ технологи нэвтрүүлж нэр төрлөө15 төрлөөр баяжуулсан. Мөн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд Засаг даргын Тамгын газар, Худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран бүтээгдэхүүн, үйлчилгээний оюуны өмчийн патент, чанар стандартыг нэмэгдүүлэх зорилгоор “Миний өөшгөө” ХХК-ийн Дарьганга хийцтэй цай бүтээгдэхүүний Дарьганга эхнэр, Дөрвөлжин монгол бичиг, | 90% / 50%<br><br>Хүрэх түвшинд хүрээгүй. Журмын 6.2.1-р үнэлэв. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үзэгний сав зэрэг 3 барааны тэмдэгтийн патентыг оюуны өмчийн газраар баталгаажуулсан байна. " | |
| 208 | | 2. Олон улсын стандарт нэвтрүүлэх ажлыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах | 2021 - 2024 | 0 | | 3 | "Хүнсний аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 36 дугаар тогоолын хүрээнд аймгийн ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс хамтран "Органик хүнсний бүтээгдэхүүний баталгаажуулалт", MNS ISO 9001 : 2016 "Чанарын менежментийн тогтолцоо" сургалтыг зохион байгуулсан. Стандарт хэмжил зүйн газраас мэдээлэл хийж, сургалтанд төрийн албан хаагч 45, үйлдвэр эрхлэгч 78, нийт 123 хүн хамрагдсан. 2024 онд Стандартын хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэх жил, "Стандарттай Монгол" нөлөөллийн аяны хүрээнд Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж буй "Чулуун-дарь овоо" ХХК-ны "Баян шарга" арьсан эдлэлийн үйлдвэр нь арьсан цүнх, нурууны бүс, өргөлийн уут зэрэг бүтээгдэхүүндээ олон улсын байгууллагын стандарт нэвтрүүллээ. | 90% / 33.33%<br><br>Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. Журмын 6.2.1-р үнэлэв. |
| 209 | | 3. Орон нутгийн бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалтыг нэмэгдүүлж, холбогдох төрийн байгууллагуудтай хамтарч сургалт зохион байгуулах | 2021 - 2024 | 4 | | 17 | 2021 онд Баруун-Урт сумын найман гал шарга ХХК-ны 8 төрлийн гурилан бүтээгдэхүүн, Төгс тээвэр ХХК-ны шимийн архины үйлдвэрт баталгаажуулалт хийж тус тус тохирлын гэрчилгээ олгосон байна. 2022 онд Аймгийн хэмжээнд 106 аж ахуйн нэгжид орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын баталгаажуулалтыг хийсэн. Аймгийн ЗДТГ-тай хамтран "Бизнесийн дуу хоолой" өдөрлөгийг зохион байгуулж 9 сумын худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч 160 гаруй иргэдийг хамруулсан.2023 онд "ДЭЛХИЙН ЧАНАРЫН | 100% / 70%<br><br>Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. 2024 оны хэрэгжилт тодорхойгүй. Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний дагуу |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ӨДӨР"-ийг тохиолдуулан аймгийн СХЗХэлтэс нь аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран Стандарт, хэмжилзүйн газрын 2 сургагч багш нарыг урин “ҮНДЭСНИЙ ЧАНАРЫН ХӨГЖҮҮЛЭЛТ” сэдэвт 2 өдрийн сургалт, хэлэлцүүлгийг 11 сарын 09, 10-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд эрхлэгчид тавих шаардлага стандарт, өдрийн ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо–Шаардлага стандартын сертификаттай сургалтыг тус тус зохион байгуулж, 13 сумын ЗДТГ-ын Худалдаа, үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүд, төр болон хувийн хэвшлийн байгууллагын 90 иргэн болон аймгийн ЗДТГ, холбогдох төрийн байгууллагын 47 албан хаагчийг хамруулав. | тайлагнах. Журмын 6.2.2.2 |
| 210 | | 4. Үйлчилгээний байгууллагын стандартын түвшнийг ахиулах зорилгоор 2 жилд нэг удаа мэргэжлийн байгууллагууды н хамтарсан аттестатчиллын шалгалтыг үе шаттайгаар зохион байгуулах | 2021 - 2024 | | | 70 | 2021 ондКовид-19 цар тахлын улмаас зохион байгуулаагүй байна. Аймгийн засаг даргын 2022 оны А/294 дүгээр захирамжаар Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж байгаа 8 Зочид буудлыг мэргэжлийн байгууллагын хамтарсан аттестатчилалыг хийж стандарт түвшинг тогтоон хэрэгжилтийг хангаж ажилласан. Шалгалтын үр дүнгээр Стандартын хэрэгжилт 67.1 %-тай байсан бол шалгалтынн үүрэг даалгаврын үр дүнд нь 5 зочид буудал стандартын шаардлага ханган 3 зочид буудал нь тохирлын гэрчилгээ аван стандартын хэрэгжилт 85.9 болсон байна. 2023 онд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх эрх бүхий аж ахуй нэгжүүдэд шинэчилсэн хууль, журмыг сурталчлан таниулах, үйл ажиллагааны эрүүл ахуй, стандартыг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагын хамтарсан "Хяналт | 100% / 50%<br><br>Шалгуур үзүүлэлт зорилтод түвшиндээ хүрээгүй. Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах. 2022 оноос хойш мэргэжлийн байгууллагуудын хамтарсан аттестатчиллын шалгалтыг үе шаттайгаар зохион байгуулсан эсэх |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шалгалт хийж, зөвлөн туслах, сургалт зохион байгуулах" ажлын хэсгийн бүрэлдэхүүн ажилласан. Ажлын хэсэг 13 сумын эрх бүхий 231 аж ахуй нэгжийн 261 обьектод хяналт хийж, шаардлага хангаагүй 18 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлж, 46 аж ахуй нэжгийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Холбогдох хууль, тогтоомж, мэргэжлийн байгууллагын шаардлага хангасан 210 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийг 2024 онд шинээр олгоод байна. | нь тодорхойгүй. |
| 211 | 3.3.12. Экспортын баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 1. Экспортын гэрчилгээтэй бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлж, стандартын бодлогоор дэмжих ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | 3 | | 5 | "2021 онд Аймгийн Цайрт Минерал ХХК-ны 602 тн цайрын баяжмалд 10 ширхэг гэрчилгээ олгосон. 2022 онд Баруун-Урт сумын ""Дарьт шүтээн"" ХХК-ний ""Баян тал"" махны үйлдвэр нь Иран улсад 160.0 тн хурганы мах, адуу үхэр, хонины 240.0 тн, нийт 400.0 тн мах экспортолсон. Дээрх үйлдвэр нь улсын “Намрын ногоон өдрүүд“ үзэсгэлэн худалдаанаас “Шилдэг мах / хурга/ экспорлогч”-оор, “ Сүхбаатар хөгжил” арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан “ Эрүүл хүнс” үзэсгэлэн худалдаанд “Орон нутгийн бренд бүтээгдэхүүн”-ээр шалгарсан. /бренд бүтээгдэхүүний гэрчилгээ/ Улаанбаатар хот, Өмнөговь аймагт салбар агуулах, дэлгүүр нээж, нийслэлийн болон орон нутгийн хүн амын махны хэрэгцээг ханган ажиллаж байна. 2024 онд Дарьт шүтээн ХХК-ийн Баян тал мах боловсруулах үйлдвэр нь Иран улсад хонь 430.0 тн, адуу 70.0 тн мах экспортонд гаргасан байна. " | 100% / 50%<br><br>2023, 2024 онд олгосон гэрчилгээ тодорхойгүй. Шалгуур үзүүлэлт зорилтод түвшиндээ хүрээгүй. Журмын 6.2.2.3 |
| 212 | 3.3.13. Жижиг, дунд үйлдвэр, | 1. Сум хөгжүүлэх сан, ЖДҮ сан, Төсөл | 2021 - 2024 | 330 | | 560 | 2021 онд сум хөгжүүлэх сангаас аймгийн хэмжээнд 7 суманд нийт 63 үйлдвэр эрхлэгчдэд нийт 768.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл | 100% / 54.47%<br><br>Тухайн жилд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бизнес эрхлэгчдэд олгосон санхүүжилтийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | хөтөлбөрийн хүрээн дэх хөнгөлөлттэй зээл олголтыг орон нутгийн үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан олгож, ажлын байрыг нэмэгдүүлэх | | | | | олгосон байна. Мөн Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд Ажлын байр дэмжих 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай зээлийг арилжааны банкаар 338 иргэн, аж ахуйн нэгжид 18.1 тэрбум төгрөгийн зээлийг олгосноос 601 ажлын байр бий болсон байна.2022 онд аймгийн хэмжээнднийт 489.4 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 39 ажлын байр бий болсон. 2023 онд Жижиг дунд үйлдвэрийн хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын дагуу зохион байгуулж, нийт 22 аж ахуйн нэгж 2,2 тэр бум төгрөгийн зээлийн хүсэлт цахим системд ирсэн. Ирүүлсэн төслүүдэд журмын дагуу 4 шатны үнэлгээ хийгдэж 8 аж ахуйн нэгжид 963,9 сая төгрөгийн зээл олгосон. Зээлийн хүрээнд 27 шинэ ажлын байр бий болсон. Орон нутгийн үйлдвэр эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн үүсвэрийг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор 2023 онд орон нутгийн төсвөөс 300.0 сая төгрөгийн хөрөнгийг Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулсан. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг дарга нарын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Ерөнхий нөхцөл тохирох, хамтран ажиллах гурван талт гэрээ”-ний дагуу Жижиг дунд үйлдвэрийн хөгжүүлэх сангаар дамжуулж, үйлдвэр эрхлэгчид хөнгөлөлттэй зээл олгох үйл явцыг эхлүүлсэн. Журмын дагуу 4 шатны үнэлгээ хийгдэж 3 аж ахуйн нэгжид 192,7 сая төгрөгийн зээл олгох | тодорхойлсон хүрэх түвшинд хүрээгүй. Хэрэгжилт хангалтгүй.Нэмэгдсэн ажлын байрны тоо тодорхойгүй. Журмын 6.2.1 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шийдвэр гарсан. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор 2024 онд ОНТ-с 300.0 сая төгрөгийг батлаж, санд төвлөрүүлсэн. Сангаас 2024 онд нийт 1.4 тэрбум төгрөгийг нийт 11 аж ахуй нэгжид олгосон. Хоршоо хөгжүүлэх сангаас Дарьганга сум 2 хоршоонд 70.0 сая төгрөг, Баруун-Урт сум 1 хоршоонд 40.0 сая төгрөгийн хөнгөлөл | |
| 213 | | 2. Мах, ноос ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэр байгуулах аж ахуй нэгжийн санаачилгыг хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр дэмжих | 2021 - 2024 | | | 1 | 2023 онд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд Халзан сумын "Гал бадрах өөдөө" ХХКомпанид 100.0 сая төгрөг, Хүнсний хувьсгалын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Баруун-Урт сумын Дарьт шүтээн ХХК нь мах боловсруулах чиглэлэээр 2.0 тэрбум төгрөг, Загвар хоршоог дэмжих хүрээнд Баруун-Урт сумын Түмэн цагаан ноос хоршоонд мах боловсруулах чиглэлээр 166.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгож төслийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж байна. 2024 онд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд Баруун-Урт сумын Бугат аав ХХК нь мах, махан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлэээр 280.0 сая төгрөг авч төслийн үйл ажиллагааг эхлүүлээд байна. Мөн Хоршоо хөгжүүлэх сангаас Баруун-Урт сумын мах, махан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр 2 иргэнд 80,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. | 100% / 100% |
| 214 | 3.3.14. Махны үйлдвэр, хорио цээрийн бүс | 1. Махны үйлдвэр цогцолбор байгууламж | 2024 | | | 1 | (Аймгийн ИТХ-ын 2023.01.31-ний 07 дугаар тогтоолоор "Төслийг орон нутагт хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах" гэж өөрчлөгдсөн) "“Хийморь Сүхбаатар мах импекс” ХХК | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүхий цогцолбор байгууламж барих төслийн хүрээнд хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах төвийг байгуулна. | барих төслийн хүрээнд ХАА-н түүхий эд боловсруулах төвийг байгуулна. | | | | | үндэсний болон гадаадын шилдэг мэргэжилтнүүдийн оролцоотой баригдсан хамгийн орчин үеийн дэвшилтэт технологи бүхий “МАЛ ТӨХӨӨРӨХ, МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОВСРУУЛАХ” үйлдвэрийг 2023 онд байгуулсан. Тус үйлдвэр нь 2024 оны 1 дүгээр улиралд үйл ажиллагаагаа явуулж эхлэсэн бөгөөл мал төхөөрөх, ангилах болон олон нэр төрлийн дайвар бүтээгдэхүүн боловсруулж дотоодын зах зээлээс гадна гадаадад экспортлох зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ үйлдвэрийн нэг онцлог нь Чех улсын “Khaanzaa” ХХК-ийн махны үйлдвэрийн зориулалттай цэвэрлэх_байгууламжийг Монголд анх удаа нэвтрүүлсэн байна. Бие даасан энэхүү байгууламж нь үйлдвэрийн бохир усыг 95% цэвэршүүлж, саарал_ус ялган авдаг. Тус үйлдвэр нь 150-200 хүнийг ажлын байраар хангах бөгөөд хувийн хэвшлийн 15.0 тэр бум төгрөгийн санхүүжилтээр баригдсан." | |
| 215 | | 1. Төслийг орон нутагт хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах | 2021 - 2024 | - | - | | “Хийморь Сүхбаатар мах импекс” ХХК үндэсний болон гадаадын шилдэг мэргэжилтнүүдийн оролцоотой баригдсан хамгийн орчин үеийн дэвшилтэт технологи бүхий “МАЛ ТӨХӨӨРӨХ, МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОВСРУУЛАХ” үйлдвэрийг 2023 онд байгуулсан. Тус үйлдвэр нь 2024 оны 1 дүгээр улиралд үйл ажиллагаагаа явуулж эхлэсэн бөгөөл мал төхөөрөх, ангилах болон олон нэр төрлийн дайвар бүтээгдэхүүн боловсруулж дотоодын зах зээлээс гадна гадаадад экспортлох зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ үйлдвэрийн нэг онцлог нь Чех улсын “Khaanzaa” ХХК-ийн махны | 100% / 0%<br><br>Арга хэмжээг давхардуулан төлөвлөсөн. 3.3.14.1-тэй хэрэгжилт ижил. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлдвэрийн зориулалттай цэвэрлэх_байгууламжийг Монголд анх удаа нэвтрүүлсэн байна. Бие даасан энэхүү байгууламж нь үйлдвэрийн бохир усыг 95% цэвэршүүлж, саарал_ус ялган авдаг. Тус үйлдвэр нь 150-200 хүнийг ажлын байраар хангах бөгөөд хувийн хэвшлийн 15.0 тэр бум төгрөгийн санхүүжилтээр баригдсан. | |
| 216 | 3.3.15. Бизнес эрхлэгчдэд бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх бизнес инкубаторын үйлчилгээг нэвтрүүлнэ. | 1. "Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх" аймгийн дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | | 100 | 2021 онд Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөрийг орон нутагт 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдөр аймгийн Засаг даргаар батлуулсан. ЖДҮ-г эрхлэгчдийг дэмжих чиглэлээр нийт 10 ажил арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 400 гаруй бизнесийн төлөөллийг хамруулсан. 2022 онд дэд хөтөлбөрийн биелэлт 65 % хэрэгжсэн. 2023 онд Төлөвлөгөөний биелэлт 85 хувьтай хэрэгжиж байна. Тус төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд нийт 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд 2024 оны байдлаар 22 арга хэмжээг 100%, 2 арга хэмжээ 70%, 1 арга хэмжээ 50% -ийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. | 100% / 95.6%<br><br>2024 оны байдлаар 22 арга хэмжээг 100%, 2 арга хэмжээ 70%, 1 арга хэмжээ 50% -ийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байгааг дундажлан үнэлэв. |
| 217 | | 2. Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 2021 - 2024 | 2 | | 4 | 2021 онд Номин холдинг ХХК-ийн 30 жилийн ойн хүрээнд дотоодын жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих зорилгоор "21- АЙМАГ-21 БРЭНД" хөтөлбөрийн хүрээнд Халзан сумын "Таанын сорс" бүтээгдэхүүн шалгарч, Номин сүлжээ дэлгүүрийн байнгын ханган нийлүүлэгч болсон. Зүүн бүсийн анхдугаар чуулганы хүрээнд бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтуудыг 2022 оны 09-р сарын 28-29-ний өдрүүдэд нийт 3 аймгийн 120 бизнес эрхлэгч, төрийн албан хаагчдад зохион байгуулсан. | 100% / 70%<br><br>Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй. Шалгуур үзүүлэлт зорилтод түвшиндээ хүрээгүй. Журмын 6.2.2.2 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Мөнх-Арингил” ХХК, Мөнх сайн үүд ХХК, Чамбай фейшны бэлэг дурсгалын бүтээгдэхүүнийг бүртгүүлэхээр материалыг МҮХАҮТ-ын патентын газарт хүргүүлсэн. 2023 онд НЭГ СУУРИН-НЭГ БҮТЭЭГДЭХҮҮН " аяны хүрээнд 21 аймгийн бренд бүтээгдэхүүний цахим каталог бий болгохтой холбогдуулан орон нутгийн онцлог шинжийг харуулсан бренд бүтээгдэхүүнээ цахим каталогт 5 төрлийн бүтээгдэхүүн орсон. 2024 онд Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнд “Миний өөшгөө” ХХК-ийн Дарьганга хийцтэй цай бүтээгдэхүүний дарьганга эхнэр, дөввөлжин монгол бичиг, морьны зураг зэрэг 3 барааны тэмдэгтийн патентыг баталгаажуулсан байна. Мөн Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж буй "Чулуун-дарь овоо" ХХК-ны "Баян шарга" арьсан эдлэлийн үйлдвэр нь арьсан цүнх, нурууны бүс, өргөлийн уут зэрэг бүтээгдэхүүндээ байгууллагын стандарт нэвтрүүллээ. | |
| 218 | | 3. Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөтгөх, харилцан туршлага солилцох зорилгоор гадаад, дотоодын үзэсгэлэн худалдаа, | 2021 - 2024 | 20 | | 40 | Жижиг дунд үйлдвэрийн газартай хамтран Жижиг дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээл, Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн мэдээлэл, Хөгжлийн шийдэл ТББ-ын Бест хөтөлбөртэй хамтран жижиг дунд бизнесийг чадавхжуулах сургалт, Монгол банк, Жижиг дунд үйлдвэрийн газар, зээлийн батлан даалтын сан хамтран "Бичил жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэг дээшлүүлэх" сургалт, Канадын Мерит хөтөлбөртэй хамтран Канадын бизнес эрхлэгчдийн маркетингийн туршлага, Цэвэр хөрсний шим хоршооны маркетнигийн | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | туршлага судлах аялал, бусад арга хэмжээнд дэмжин оролцуулах | | | | | туршлагын талаар сургалт, Тогтвортой ноос ноолуурын эвсэл төрийн бус байгууллагатай хамтран Баяндэлгэр суманд хоршооны сургалтуудыг зохион байгуулж жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид, хоршоод, малчдыг мэдлэг мэдлэлээр хангасан байна. Мөн аймгийн " Хөрөнгө оруулалт хөгжлийн чуулга"-нд орон нутгийн бизнес эрхлэгчдийг хамруулж, орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн үзэсгэлэнг зохион байгуулсан. Сургалт зөвлөгөөнд орон нутгийн 220 гаруй бизнес эрхлэгчидийг хамруулсан. 2024 онд орон нутгийн бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцан туршлага судлах зорилгоор улс, орон нутгийн цагаан сарын үзэсгэлэн худалдаа, Сүхбаатарт үйлдвэрлэв -2024" арга хэмжээний хүрээнд "Эрүүл хүнс", "Алтан намар" ,"Хөнгөн үйлдвэрлэл", "Шилмэл мал" үзэсгэлэн, "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль, Хоол үйлдвэрлэл, Үсчин гоо сайханчдын улс, бүс, аймгийн аварга шалгаруулах тэмцээн, малчид , үйлдвэрлэл эрхлэгчдийг Шилийн гол аймаг, Манжуур хотод туршлага судлуулах аялал гэх мэт 15 удаагийн арга хэмжээнд нийт 500 төлөөлийг хамруулсан банйа. | |
| 219 | | 4. Сүхбаатар хөгжил арга хэмжээний хүрээнд "Эрүүл хүнс", "Алтан намар","Сүхбаатарт үйлдвэрлэв" | 2021 - 2024 | | | 140 | Малчид, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулах, борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох хүрээнд"Намрын ногоон өдрүүд - Үндэсний үйлдвэрлэл " арга хэмжээний хүрээнд "Эрүүл хүнс", "Алтан намар", "Сүхбаатарт үйлдвэрлэв" , "Шилмэл мал үзэсгэлэн худалдааг 2021-2024 | 100% / 88.6%<br><br>Шалгуур үзүүлэлт зорилтод түвшиндээ хүрээгүй. Журмын 6.2.1 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулах | | | | | онд Баруун-Урт суманд зохион байгуулж ажилласан. Тус арга хэмжээнд давхардсан тоогоор 13 сумын 443 үйлдвэр эрхлэгчид оролцож, нийт 453.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн худалдан борлуулсан байна. | |
| 220 | | 5. Бизнес эрхлэгчдэд инкубаторын үйлчилгээ үзүүлэх | 2021 - 2024 | 6 | | 14 | 2021-2024 онд "Сүхбаатар хөгжил-ҮТП" ОНӨААТГазар бизнес эрхлэгчдэд инкубаторын үйлчилгээг тогтвортой үзүүлж ажилласан бөгөөд одоогоор тус байгууллагын бизнес инкубатор төвд 5 иргэн, аж ахуй нэгж оёдол, гурил, гурилан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. | 50% / 46.43%<br><br>Хүрэх түвшинд хүрээгүй. Журмын 6.2.1 |
| 221 | 3.3.16. Орон нутгийн бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, хоршоодын бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын тогтолцоог кластерын системээр хөгжүүлнэ. | 1. Хоршоодоор дамжуулан хөдөө аж ахуйн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийг хийж, аймгийн хэмжээнд хоршоодыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | 38 | | | 2021 онд “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-III”-ийг 2021-2024 онд орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулсан. Хөдөө аж ахуйн бирж, ХХААГ хамтран "Хоршооны хөгжлийг дэмжих жил -2022" ажлын хүрээнд хоршоодыг чадавхжуулах сургалтад 30 хоршоодын төлөөлөл, сумдын, хоршоо хариуцсан мэргэжилтнүүд оролцож “Хоршоо биржийн арилжаанд оролцох боломж, үр ашиг” сэдвээр мэдээлэл, танилцуулга, мэдээлэл хийсэн. Хоршоод биржийн байнгын бус гишүүнээр бүртгүүлж, гэрээ байгуулснаар өөрсдийн бэлтгэсэн түүхий эдээ биржээр дамжуулан арилжиж үндэсний үйлдвэрт чанар, стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг хангах боломжтой болсон. “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газар, Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбооноос хамтран зохион байгуулж буй “Хоршоологчид тогтвортой | 100% / 90%<br><br>2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. Тодорхойлсон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй нийцүүлж хэрэгжилтийг тайлагнах. Үнэлгээг бууруулав. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөгжилд-2023” туршлага солилцох арга хэмжээг Улаанбаатар хот болон Говьсүмбэр аймагт зохион байгуулагдсан. Баруун-Урт сумын “Бумт алтан өргөө” хоршоо, Эрдэнэцагаан сумын Хөх хавцал хоршоо, Мөнххаан сумын “Ашид баян мөнх” хоршооны дарга гишүүдийг ХХАХҮЯ, ЖДҮГ-аас зохион байгуулсан туршлага судлах арга хэмжээнд оролцуулсан. 2024 онд шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд малчдыг хоршоолж ажиллахын ач холбогдол, хоршоодыг үйл ажиллагаагаа өргөжүүлэх хүрээнд улс, бүс, орон нутгийн 5 удаагийн сургалт, зөвлөгөөнд нийт 510 малчид, хоршоологчдыг хамруулж ажилласан. Мөн шинэ хоршоо хөдөлгөөний тайлант хугацаанд сум бүрт бэлтгэгдсэн сургагч багш нар 13 сумын 5319 өрхийн 13822 гишүүнд мэдээлэл хүргэж ажилласан байна. Үүний үр дүнд 2024 оны 04 дүгээр улирлын байдлаар аймгийн хэмжээнд 170 хоршооны 430 гишүүнд эрчимжсэн аж ахуй, хөдөө аж ахуйн түүхий эд, дайвар бүтээгдэхүүн боловсруулах, бэлтгэн нийлүүлэх чиглэлээр нийт 14.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. | |
| 222 | | 2. Загвар хоршоо байгуулах | 2021 - 2024 | | | | 2021 онд 2 хоршоо байгуулагдсан. 2022 онд ЖДҮГ-аас Хоршооны улсын зөвлөгөөнийг Хэнтий аймгийн Баян-Овоо суманд зохион байгуулсан Загвар хоршооны туршлага судлах, хоршоологчдын чадавхжуулах арга хэмжээг. Тус арга хэмжээнд ҮХҮАлбаны дарга, Баруун-Урт сумын Алтанцацал хоршоо, Баянмөнх ундрах хоршоо, Түмэнцогт сумын Эв нэгдэл хамтын хоршоо, Түвшинширээ сумын Бат бэх найрамдал хоршоодын дарга, гишүүд оролцож туршлага судалсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга | 90% / 90%<br><br>2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний дагуу Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/512 тоот тушаалаар дараах салбар, чиглэлд хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн. Үүний хүрээнд Загвар хоршоо, Нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олгох чиглэлээр төсөл хүлээн авах системд Баруун-Урт сумын "Түмэн цагаан ноос" хоршоо мах боловсруулах чиглэлээр 166 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. 024 онд шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд малчдыг хоршоолж ажиллахын ач холбогдол, хоршоодыг үйл ажиллагаагаа өргөжүүлэх хүрээнд улс, бүс, орон нутгийн 5 удаагийн сургалт, зөвлөгөөнд нийт 510 малчид, хоршоологчдыг хамруулж ажилласан. Мөн шинэ хоршоо хөдөлгөөний тайлант хугацаанд сум бүрт бэлтгэгдсэн сургагч багш нар 13 сумын 5319 өрхийн 13822 гишүүнд мэдээлэл хүргэж ажилласан байна. Үүний үр дүнд 2024 оны 04 дүгээр улирлын байдлаар аймгийн хэмжээнд 170 хоршооны 430 гишүүнд эрчимжсэн аж ахуй, хөдөө аж ахуйн түүхий эд, дайвар бүтээгдэхүүн боловсруулах, бэлтгэн нийлүүлэх чиглэлээр хөнгөлөлттэй зээл олгосон байна. | |
| 223 | 3.3.17. Бизнесийн салбарын техник туслалцааны зөвлөх үйлчилгээг | 1. Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг чанаржуулах, бизнес төсөл боловсруулах | 2021 - 2024 | 6 | | 12 | Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг чанаржуулах, бизнес төсөл боловсруулах чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, гадаад дотоодод харилцан туршлага судлах, бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2021-2024 онд нийт 56 удаагийн арга хэмжээнд нийт | 100% / 50%<br><br>Бизнес эрхлэгчдэд хүргэсэн техник туслалцааны талаар |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. | чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах хүрээнд гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, их дээд сургууль, мэргэжлийн байгууллагуудтай хамтран техник туслалцааны ажлыг нэвтрүүлэх | | | | | 1272 бизнес эрхлэгчдийг хамруулсан. | тайлагнаагүй. Арга хэмжээний хүрэх түвшинд хүрээгүй. Журмын 6.2.2.3 |
| 224 | 3.3.18. Бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ. | 1. ТХХЗөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 6 | | | 2021 онд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнд 200 гаруй төлөөлөл оролцсон.2022 онд азийн хөгжлийн банкны зөвлөх үйлчилгээний хүрээнд Сүхбаатар аймагт ноос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮГ боловсруулан "Дөрвөн гэгээн эрдэнэ" ХХК-д хүлээлгэн өгсөн. 2023 онд Төр хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны үр дүнд Баруун-Урт суманд сард 200 тонн ноос боловсруулах, 20 хүний ажлын байр бүхий үйлдвэр ашиглалтанд орсон. Мөн хувийн хэвшлийн 15.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий хоногт 1000 бог, 300-400 бод нядлах хүчин чадал бүхий мах боловсруулах үйлдвэр 2023 онд ашиглалтанд орж, 2024 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байна. | 100% / 70%<br><br>2022-2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. Шалгуур үзүүлэлт зорилтод түвшинд хүрээгүй. Журмын 6.2.2.2 |
| 225 | 3.4.1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, | 1. Аймгийн аялал жуулчлалын | 2021 | | | | Аймгийн аялал жуулчлалын нөөц даацын судалгааг хийх зорилгоор 2021 онд Улаанбаатар хотын Монголиан гайд турс ХХК- | 100% / 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний чанарыг сайжруулна. | нөөц даацын судалгааны ажлыг хийх | | | | | тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулж судалгааг хийлгэсэн. Судалгааны баг тус аймгийн Сүхбаатар сум, Эрдэнэцагаан сум, Бичигт хилийн боомт, Дарьганга сум, Онгон сум, Баяндэлгэр сум, Түвшинширээ сум, Халзан сумын нутгаар нийт 7 хоног явж судалгаа хийн зорин очих газруудыг үзэхээс гадна цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Уулбаян, Мөнххаан, Түмэнцогт, Асгат, Наран сумын холбогдох албан хаагчдаас шаардлагатай мэдээллийг утсаар авч судалгааг хийсэн. Нөөц даацын судалгааг хийснээр аймгийн аялал жуулчлалын зорин очдог голлох газруудыг цаашид хэрхэн сайжруулах, өөр бусад газруудыг зах зээлийн эргэлтэнд оруулах, аялал жуулчлалын өөр шинэ шинэ ямар нөөц боломж байгаа, амралтын газруудын нүхэн жорлонг хэрхэн өөрчлөх, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, хүний нөөцийг хэрхэн чадавхжуулах, шинэ аяллын маршрутыг гаргаж, цаашид шинээр ямар төрлийн аяллуудыг хөгжүүлэх боломжтой талаар зөвлөмж боловсруулсан нь үр дүнтэй бөгөөд судалгааний материалыг энгийн үг өгүүлбэрээр бичиж найруулсан нь ямар ч хүн уншаад ойлгохоор авууштай материал болж чадсан. Аялал жуулчлалын нөөц даацын судалгааг нийт 10 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Тус судалгааны ажил нь Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө нэрээр гарсан. жил бүр хэрэгжиж болохуйц ажлыг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг): 10 сая Хүрсэн түвшин: Аялал жуулчлалын | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | менежментийн төлөвлөгөөтэй болсон. | |
| 226 | | 2. Аймгийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн дунд хугацааны стратегийг боловсруулан, хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | | 90 | 2021 онд Аймгийн аялал жуулчлалын Менежментийн төлөвлөгөөг Монголиан гайд турс ХХК-иар 2 сарын хугацаатай гэрээ байгуулж хийлгэсэн. Судалгааны баг тус аймгийн 6 сумын 21 зорин очих газраар 7 хоног явж судалгаа хийж үзэхээс гадна цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Уулбаян, Мөнххаан, Түмэнцогт, Асгат, Наран сумын холбогдох албан хаагчдаас шаардлагатай мэдээллийг авч судалгааг хийсэн. Менежментийн төлөвлөгөөг хийснээр аймгийн аялал жуулчлалын зорин очдог голлох газруудыг цаашид хэрхэн сайжруулах, өөр бусад газруудыг зах зээлийн эргэлтэд оруулах, аялал жуулчлалын ямар нөөц боломжууд байгаа, амралтын газруудын нүхэн жорлонг хэрхэн өөрчлөх, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, хүний нөөцийг хэрхэн чадавхжуулах, шинэ аяллын маршрутыг гаргаж, цаашид шинээр ямар төрлийн аяллуудыг хөгжүүлэх боломжтой талаар зөвлөмж боловсруулсан нь үр дүнтэй ажил болсон. Уг судалгааг нийт 10 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Менежментийн төлөвлөгөөг жил бүр үйл ажиллагаандаа тусган ажиллахаас гадна 2014, 2021 оны судалгаан дээр үндэслэн аймгийн аялал жуулчлалын хөтөлбөрийг боловсруулахаар аймгийн засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. | 100% / 100% |
| 227 | | 3. Аялал жуулчлалын чиглэлээр үйл | 2022 - 2023 | 77 | | | 2020 онд БОАЖЯамны захиалгаар Травел хаб монголиа ХХК Сүхбаатар аймагт “Удирдлага менежер, зөөгч, бариста, бартендер, тогооч, | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллагаа явуулдаг ААНБ-д зөвлөх үйлчилгээний сургалт зохион байгуулж, стандартын түвшнийг нэмэгдүүлэх | | | | | хөтөч, жолооч, өрөөний үйлчлэгч, зочин хүлээн авагч” мэргэжлээр 4 хоногийн сургалтыг зохион байгуулж сургалтанд нийт 180 гаран хүн хамрагдсан. 2022 онд ААНБ-д зөвлөх үйлчилгээний сургалтыг Нью жуулчин турс ХХК-ны дэргэдэх Аялал жуулчлалын ур чадварын сургууль зочид буудал, жуулчны баазад ажлын байран дээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Мөн Баруун-Урт сумын Дарьганга зочид буудал, Наадаан ресорт амралтын газрууд Horeca institute зөвлөх үйлчилгээ авч үйл ажиллагаандаа ахиц гарган ажилласан. 2024 онд Стандарт хэмжилзүйн хэлтэс, Өсөх сэтгэлгээ Өнгөлөг ирээдүй ТББ-тай хамтран Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагууд болон салбарын шууд бус оролцогчдод зочлох үйлчилгээний чиглэлээр сургалт зохион байгуулж, сургалтад 13 сумын 450 орчим иргэн хамрагдсан. 2020-2024 оны хугацаанд зочлох үйлчилгээний чиглэлээр давхардсан тоогоор нийт 696 ажилтан сургалтад хамрагдсан байна. | |
| 228 | | 4. Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу стандартад нийцсэн түр буудаллах цэг байгуулах | 2023 - 2024 | 0 | | | "Зам, Тээвэр Хөгжлийн Яам, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Аялал Жуулчлалын холбоо 2020 оны 10 дүгээр сарын 05-ны өдөр Аялал жуулчлалын гол чиглэл дагуу үйлчилгээний цогцолбор байгуулах чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Мөн Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайд, Зам, Тээвэр Хөгжлийн Сайдын хамтарсан 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/267, А/143 дугаар тушаалын дагуу, Аялал жуулчлалын гол чиглэл дагуу үйлчилгээний цогцолбор байгуулах байршлын жагсаалтыг баталж, тогтсон байршил дээр Олон улс, улсын чанартай авто зам дагуу | 30% / 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлчилгээний цогцолбор байгуулах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг албажуулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тус ажлыг эхлүүлсэн. Улсын хэмжээнд 16 аймагт 31 байршил сонгосноос Сүхбаатар аймгийн Мөнххаан, Эрдэнэцагаан суманд аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу стандартад нийцсэн түр буудаллах цэг байгуулхаар улсын төлөвлөгөөнд тусгагдсан. Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу стандартад нийцсэн түр буудаллах цэг байгуулах С болон В ангилалын ТЭЗҮ боловсруулагдсан." | |
| 229 | | 5. Аялал жуулчлалын бүс бүрд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж, нүүдлийн соёл иргэншлийг харуулсан морь, тэмээн аялал, шувуу ажиглах, язгуур урлаг, өв соёлын арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | | | 1 | 2023 онд Наран, Дарьганга, Онгон сумдын Эко клубүүдэд "Шувуу ажиглах аялал" төслийг хэрэгжүүлэхэд 1 сая төгрөг зарцуулсан байна.Төслийн хүрээнд: "Шувуу ажиглах төсөл"-ийн хүрээнд Дарьганга, Онгон, Наран сумдын Эко клубын сурагчдын дунд “Шувуу ажиглах” аяллыг зохион байгуулсан. Нэг өдрийн аялалд 43 хүүхэд хамрагдсан. 2024 онд Ганга нууранд шувууны нуувч хийх ажлын талаар Дарьганга сумын иргэнтэй 3.9 сая төгрөгийн гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн. Шувууны нуувч хийгдснээр шувуу судлаачид, шувууны гэрэл зурагчдыг татах, шувуугаар дамжуулан тусгай сонирхлын аялал жуулчлал хөгжүүлэх нэг гарц бий болно. Цаашид Ганга нуурын тохижилтын хүрээнд нууранд шувуу ажиглах цамхаг баригдахаар төлөвлөгдөөд байгаа. | 100% / 100% |
| 230 | | 6. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх гадаад | 2022 - 2024 | | | | 2020-2022 оны хооронд цар тахалтай холбоотойгоор гадаадын жуулчид Сүхбаатар аймагт аялаагүй. 2023 онд ар монгол трэвел компаний шугамаар 5 машин, 12 жуулчин, Агтана хүрээт арга хэмжээний үеэр 40 өвөр | 50% / 50%<br><br>2023-2024 онд хүрэх түвшин тодорхойлоогүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх | | | | | монгол жуулчин хүрэлцэн ирсэн байна. Хил орчмын аялал жуулчлалын хүрээнд Засгийн газрын 2024 оны 142 дугаар тогтоолоор Хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах журам батлагдаж гарсан. Мөн зорин очих газруудыг гадаадын жуулчдад сурталчлах үүднээс аймгийн Засаг даргын 2024 оны А/202 дугаар захирамж гарч 2,250,0 мянган төгрөгөөр Монгол, Хятад хэл дээр аяллын маршрут, хөтөлбөр бүхий товхимолыг 500 ширхэгийг хэвлүүлсэн. Ингэснээр аялал жуулчлалын компани болон жуулчид аяллын талаар нэгдсэн мэдээллийг авах боломжтой болсон. 2024 оны 5, 8 дугаар сард хил орчмын аяллын маршруттай танилцахаар 12 жуулчин ирж, судалгаа хийсэн. | |
| 231 | | 7. Эрдэнэцагаан суман дахь 80 ортой зочид буудлын барилгын өмчлөлийн асуудлыг холбогдох талтай харилцан шийдвэрлэх | 2022 - 2024 | 0 | | 100 | 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошууны Засаг дарга Жөү Юүлүнь тэргүүтэй ажлын хэсэг, 2024 оын 08 дугаар сарын 05-ны өдөр тус хошууны Засаг даргын орлогч Шьюй Инжяниар ахлуулсан ажлын хэсэг Сүхбаатар аймагт тус тус айлчилж, аймгийн удирдлагуудтай албан уулзалтуудыг зохион байгуулав. Уулзалтын хүрээнд тус бүр 5-6 асуудлыг хэлэлцсэн бөгөөд Эрдэнэцагаан суманд байрлах 2016 онд баригдсан 80 ортой зочид буудлын асуудлыг хэлэлцэж, Сүхбаатар аймгийн Засаг даргын зүгээс өвс гаргах боломжийг судлан дээд шатны байгууллагад уламжлах талаар мэдэгдэв. Дээд шатны байгууллагаас хилээр өвс гаргах шийдвэр гарвал гэрээнд заасан өвсийг тоо хэмжээ ёсоор өгч, буудлыг шилжүүлж авах саналыг тавьсан. | 30% / 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зүүн үзэмчин хошууны удирдлагуудын зүгээс уг тавьсан саналыг намын хорооны хурал дээр удирдлагууддаа танилцуулахаар хоёр тал тохиролцов. | |
| 232 | 3.4.2. Аялал жуулчлалын маркетинг сурталчилгааг өргөжүүлнэ. | 1. Үйлчилгээний байгууллага, иргэдэд аялал жуулчлалын менежментийн талаар боловсрол олгох, тэдний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, үзэсгэлэнд оролцуулах | 2021 - 2024 | 3 | | 3 | Тус аймаг нь УБ хотод болдог Ай Ти Эм ОУ-ын аялал жуулчлалын үзэсгэлэнд 2021, 2022, 2024 онуудад оролцож гар урлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, ААН-ийг дэмжин ажиллаж байна. Тухайлбал: Тал нутгийн өнгө аялал жуулчлалын холбоо, Мөнххаан сумын Аринги брэнд, эсгий урлаач Цэээсүрэн, Дарьганга сумын зураач Б.Энхмаа, Баруун-Урт сумын Баяншарга ХХК, Дөш брэнд, Мөнх сайн үүд ХХК, Чамбай брэнд, УБ хотоос Агтана хүрээт төсөл жил бүр хамтран оролцдог. 2022, 2024 оны үзэсгэлэнд 1080 ш брошюр, 400 ш газрын зураг, 410 ш товхимол, 32 төрлийн нийт 230 гаруй ш бүтээгдэхүүнээр оролцсон. Тус үзэсгэлэнт 3 удаа оролцоход нийт 17.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн 2020, 2022, 2023, 2024 онуудад зохион байгуулсан “Намрын ногоон өдрүүд-Сүхбаатарт үйлдвэрлэв” арга хэмжээний хүрээнд “Эрүүл хүнс”, “Алтан намар”, “Хөнгөн үйлдвэрлэл”, Тэрбум мод-тарьц суулгацын үзэсгэлэн худалдаа тус тус зохион байгуулагдсан. Нүүдэлчин Монгол-2023, 2024 наадамд гар урлал, байгаль хамгаалах, соёлын өв, бүтээлч үйлдвэрлэл, тоглоом наадгай гэсэн төрлүүдэд Баруун Урт, Онгон, Уулбаян, Дарьганга, Мөнххаан, Эрдэнэцагаан сумдууд тус тус оролцсон. Түүнчлэн INVEST KHENTII- 2023 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИНГИС хотноо болж чуулганы үеэр бүс нутгийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн болж Сүхбаатар аймгаас Уулбаян, | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Мөнххаан, Баруун-Урт сумын өрхийн болон ЖДҮ эрхлэгчдийн төлөөллүүд оролцож, бүтээгдэхүүнээ танилцуулсан. Тухайлбал: хурганы элдсэн арьс, эсгий эдлэл, Дарьганга хийцтэй цай, адууны арьсан гутал, тааны сорс гэх мэт. | |
| 23 3 | | 2. Аймгийн аялал жуулчлалыг сурталчилсан ном товхимол хэвлүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах | 2022 | 0 | | | 2020 онд Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын газрын зургийг 4.5 сая төгрөгөөр газрын зургийг Эм Пи Эм ХХК-иар 1000 ширхэг газрын зураг хийлгэсэн. 2023 онд Алтан овооны их тахилга наамдыг тохиолдуулан Монгол, Англи хэл дээр 2000 ширхэгийг шинэчлэн гаргасан. Газрын зурагт аймгийн аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын мэдээлэл, зорин очих газрууд, аяллын маршрут, аймгийн төв Баруун-Урт хотын план зураг, түүх соёлын болон байгалийн үзэсгэлэнт газар, өвөрмөц тогтоцтой газар нутаг, УТХГН-ын мэдээлэл орсон. 2024 онд Монгол, Хятад дээр Хил орчмын аялал жуулчлалын танилцуулгыг 2.5 сая төгрөгөөр 1000 ш хэвлүүлж гаргасан. | 100% / 90%<br><br>Шалгуур үзүүлэлт тодорхойлсон хугацаанд хүрэх түвшинд хүрээгүй тул үнэлгээг бууруулав. |
| 23 4 | | 3. Аялал жуулчлалын холбооны үйл ажиллагааг эрчимжүүлэх | 2022 - 2024 | | | | Холбоо 2022 онд Тал нутгийн өнгө нэртэй, 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Тус холбоо нь Байгаль орчны газартай хамтран жил бүр болдог Ай Ти Эм олон улсын үзэсгэлэнд орон нутгийн бизнес эрхлэгчдийг зохион байгуулан оролцдог. 2023 онд Сүхбаатар аймгийн Засаг даргын ивээл дор УСАН СЭЛЭЛТ-ийн Олон Улсын нөхөрсөг тэмцээнийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. | 50% / 50%<br><br>2023-2024 онд хүрэх түвшин тодорхойлоогүй. |
| 23 | | 4. Орон нутгийн | 2021 - | 2 | | | 5 жилд нэг удаа болдог Алтан дарь овооны их | 100% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | | өв соёлыг сурталчлан таниулах эвент арга хэмжээг зохион байгуулж, тогтмолжуулах | 2024 | | | | тахилга наадам, 2020 оноос Хунгийн баяр, 2018 оноос Агтана хүрээт, 2010 оноос Талын нар шинэ оны анхны нар харах аялал зэрэг эвент арга хэмжээнүүд тус тус зохион байгуулагдаж ирсэн. Тодоруулбал: Дарьганга өв соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Хунгийн баяр” арга хэмжээг 3 жил зохион байгуулж тус баярт Дарьгангын хошууны бүх сум оролцож, зан үйлийн үзүүлбэр болон ардын авьяастнуудын тоглолтыг бүтэн өдрийн турш үзүүлсэн. Мөн Агтана хүрээт хүлэгч эрс ТББ-ын санаачилгаар “Агтана Хүрээт хүлэгч эрсийн наадам, олон улсын гэрэл зургийн уралдаан” 8 дахь жилдээ Дарьганга сумын Шилийн богд уулын ар  бэлд болсон. Тус арга хэмжээ нь Монгол адууг алдаршуулах, адууны өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэх, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгын дор зохион байгуулагддаг онцлогтой. АДУУЧИН тэмцээнд 16 аймгийн 105 адуучин залуу ид хав, идрийн жавхааг гайхуулан өрсөлдсөн. Тогтмол болдог дээрх арга хэмжээнүүдэд нийт 6000 мянга орчим дотоодын жуулчин ирсэн бол Алтан овооны их тахилга наадамд дотоодын 40 мянга орчим жуулчин ирсэн байна. үүнээс БНХАУ-ын 52 жуулчин аялсан. | 2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. Хэмжих нэгж тодорхойгүй. Тайлагналын зарим хэсэг өмнөх арга хэмжээнүүдийн хэрэгжилттэй адил байна. Төлөвлөлтийг анхаарч, оновчтой гаргах. Жуулчдын тооны өсөлт тайлагнах. Журмын 6.2.2.2 |
| 236 | 3.4.3. Аялал жуулчлалын бүс нутаг дахь орчны бохирдлыг бууруулна. | 1. Аялал жуулчлалын бүс нутагт эко ариун цэврийн байгууламж /00/ байгуулах | 2022 - 2024 | | | | Алтан овооны 110 жилийн ойн хүрээнд Аялал жуулчлалын бүс нутаг болох Алтан овоо, Зэгст нуурт хөрсөнд нэвчдэггүй стандартын шаардлагад нийцсэн Эко нойл 7 ширхгийг хийж байрлуулсан. Дээрх ажлыг ОНХС-ын хөрөнгөөр 45 сая төгрөгийн санхүүжилт гаргаж гүйцэтгэгчээр Ховдтул ХХК ажилласан. Мөн ойн арга хэмжээний үеэр зөөврийн 00-ийн үйлчилгээг мэргэжлийн байгууллага болох | 100% / 100%<br><br>2023-2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. Анхаарах |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Мөнхийн хүндлэл ХХК- иар 50 ш энгийн 00 ийг 39,996,000 төг, 10 ш люкс 00-ийг 11,341,000 төг гүйцэтгүүлсэн. Мөн ойн арга хэмжээний үеэр зөөврийн 00-ийн үйлчилгээг мэргэжлийн байгууллага болох Мөнхийн хүндлэл ХХК- иар 50 ш энгийн ОО ийг 39,996,000 төг, 10 ш люкс 00-ийг 11,341,000 төг гүйцэтгүүлсэн. | |
| 23 7 | | 2. Хог хаягдлыг бууруулах чиглэлээр мэдээллийн самбар байршуулж, нөлөөллийн ажил хийх | 2022 - 2023 | 4 0 | | 3 3 | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.4.3.2 дах заалтыг хэрэгжүүлэх үүднээс Мөнхийн үсэг ХХК-аар эхний ээлжинд 1000 ш брошур хийлгэж аймгийн баруун постон дээр тараасан. Уг брошуранд хөдөө хээр хог хаяхгүй байх, ой хээрийн түймрээс сэргийлэх, уул овоонд зөв хүндэтгэл үзүүлэх, аяллын маршрут, үйлчилгээний газруудын утасны дугаар багтсан болно. АЖ-ын бүс нутагт дахь Хог хаягдлыг бууруулах чиглэлээр аймгийн хэмжээнд нийт 4 сумын 12 байршилд 12ш мэдээллийн самбарыг хийж байршуулсан. Үүнд: Асгат сумын Их ууланд 1 ш, Наран сум 6 ш, Баяндэлгэр 2 ш, Түвшинширээ сум 3 ш самбар тус тус хийлгэсэн. 2022 онд Цагаан сарын баяраар буюу шинийн 8-15 ны өдрүүдэд дотоодын жуулчдын урсгал нэмэгддэгтэй холбогдуулан sukhbaatartourism.page хуудсаар уул овоон дээр хадаг уяхаа зогсооё, түүх соёлын хөшөө дурсгал дээр сүү, архи өргөхөө зогсооё уриалгыг явуулсан. 2022 оны цагаан сарын өдрүүдээр 15000-20000 мянга орчим жуулчин ирсэн. 2023 онд Алтан овооны их тахилгыг тохиолдуулан Хандлагаа өөрчилж, хариуцлагатай аялцгаая уриалга гаргаж 136 шэйр, 220 лайк хандалт авсан байна | 100% / 100% |
| 23 | 3.5.1. Баруун- | 1. Баруун-Урт- | 2023 - | | | 30 | Тус ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэл | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Урт - Бичигт чиглэлийн 272 км хатуу хучилттай хүнд даацын авто зам барина. | Бичигт чиглэлийн 272 км хатуу хучилттай авто зам барих ажилд орон нутгаас дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | 2024 | | | | концессоор гүйцэтгүүлэхээр холбогдох яамнаас тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй байна. Орон нутгаас Бичигтийн боомт талаасаа тус ажлыг уул уурхайн тусгай зориулалтын авто замын ажилтай уялдуулах саналыг ЗТХЯ, УУХҮЯ-дад уламжилан санал солилцон ажилласан. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Баруун-Урт-Эрдэнэцагаан-Бичигт чиглэлд 180 км хатуу хучилттай авто барих ажил хэрэгжихээр төлөвлөгдсөн. Авто замын ажил 2025 онд эхэлнэ. | |
| 239 | 3.5.2. Дорноговь аймгийн Сайншанд - Баруун-Урт - Хөөт чиглэлийн 433 км төмөр замын төслийг эхлүүлнэ. | 1. Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 433 км төмөр замын төслийг эхлүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлж, санал санаачилга гарган хамтран ажиллах | 2023 - 2024 | | | 30 | ""Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний шатны үйл ажиллагааны хөтөлбөр Боомтын сэргэлтийн хүрээнд Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ хийгдэж, БНХАУ-ын хил холболт, бусад салбарын зураг төсөлтэй уялдуулан боловсруулах ажил эхэлсэнтэй холбогдуулан орон нутагт ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн байршил, нөөц, хүчин чадал, бусад ерөнхий мэдээллийг "Монголын Төмөр Зам" ТӨХК-д хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолоор Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426 км төмөр замын ажлыг эхлүүлэх шийдвэр гарсан. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Бичигт-Хөөт чиглэлийн төмөр зам барих ажил хэрэгжихээр төлөвлөгдсөн. " | 70% / 70% |
| 240 | 3.5.3. Олон улсын тээвэр логистикийн төв | 1. Бичигт боомт хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан | 2023 - 2024 | | | 30 | Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Бичигт боомтыг хөгжүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын тендерт Ланд Овнер ХХК гүйцэтгэгчээр шалгарч гэрээний | 50% / 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулна. | тээвэр логистикийн төв байгуулах ажлыг эхлүүлэх | | | | | хугацаанд дахин төлөвлөлтийн ажлыг хийж гүйцэтгэн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан байна. 2022-2024 онд Сангийн яамны захиалгаар Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар Бичигт боомтын дэд бүтэц, шалган нэвтрүүлэх авто замын өргөтгөл шинэчлэлийн ажил эхэлсэн. Гүйцэтгэгчээр "Хурдны зам", "Нэг шугам" ХХК-иуд ажиллаж байна. Орон нутгийн төсвөөр 2023 онд Бичигт боомтын дахин төлөвлөлтийн ажлын зураг, төсвийг "Ланд овнер" ХХК гүйцэтгэж, ачаа тээврийн үйлчилгээ болон нурмаг ачаа тээвэр буулгах төв мөн хүнд даацын тээврийн хэрэгслүүдийн байршил талбайн түр болон байнгын зогсоол тайлбайг том жижиг хэлбэрээр төлөвлөн тусгасан байна. Газрын асуудлыг шийдвэрлэсэн. | |
| 241 | | 2. Уул уурхайн бүтээгдэхүүнийг ачих буулгах талбай бүхий шинэ суурьшлын бүсийг байгуулах | 2023 - 2024 | 0 | - | 90 хувь | Орон нутгийн төсвөөр 2023 онд Бичигт боомтын дахин төлөвлөлтийн ажлын зураг, төсвийг "Ланд овнер" ХХК гүйцэтгэж, ачаа тээврийн үйлчилгээ болон нурмаг ачаа тээвэр буулгах төв мөн хүнд даацын тээврийн хэрэгслүүдийн байршил талбайн түр болон байнгын зогсоол тайлбайг том жижиг хэлбэрээр төлөвлөн тусгасан байна. Газрын асуудлыг шийдвэрлэсэн. | 70% / 70% |
| 242 | 3.6.1. Аймгийн төвийн болон сумдын үерийн далан суваг, борооны болон | 1. Баруун-Урт хотын үерийн ус зайлуулах далан сувгийг барих | 2021 - 2024 | 2.5 | | 11.3 | Сүхбаатар аймгийн үерийн усны сувгийн байгууламжийн зураг төслийг боловсруулах ажлыг гүйцэтгэгч компаниас үнийн санал авч зураг төслийн ажлыг 2025 оны улсын төсөвт оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Улсын онцгой комиссын 2024.05.30-ны өдрийн 46 дугаартай албан тоотын дагуу Сүхбаатар аймгийн үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг | 30% / 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | | | | | | Аймгийн Засаг даргын А/108 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг боловсруулан холбогдох газар хүргүүлэн ажилласан. Аймгийн хэмжээнд үерийн эрсдэлийн үнэлгээгээр аюул, эмзэг байдал, өртөх байдал, чадавхын дундаж утгаар эрсдэлийн түвшин Дунд /эрсдэлийн индекс- 4,29/ эрсдэлтэй үнэлэгдсэн байна. Энэ онд Баруун-Урт сум уртын голын дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ... метр шороон далангын ажлыг хийж гүйцэтгэж ажилласан.Шинээр баригдсан 3 дугаар сургуулийн хойд талаар 200 метр урт үерийн далан байгуулах 004/ЗД-2022 тоот зургийн даалгавар бололвсруулж холбогдох байгууллагуудаар хянаж баталгаажуулж зураг төслийн "Зэд прожект" ХХКомпани гүйцэтгэж магадлалаар баталгаажуулах ажил хийгдэж байна. | |
| 243 | | 2. Эрдэнэцагаан, Наран суманд үерийн ус зайлуулах далан сувгийг барих (АИТХ-ын 2023 оны 7-р тогтоолоор хассан) | 2021 | 1 | | | (АИТХ-ын 2023 оны 7-р тогтоолоор хассан)<br>Ерөнхий дунджаар үнэлэв | 89% / 89% |
| 244 | 3.6.2. Гэр хорооллыг дахин төлөвлөх замаар орон сууцны | 1. Баруун-Урт хотын 3-р тойргоос дотогш дахин төлөвлөлт хийж, шинэ | 2021 - 2024 | 234 | | 454 | Баруун-Урт сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах амгалан гэр хорооллыг дахин төлөвлөх ажлын тендерт Ланд овнер ХХКомпани шалгарч гэрээний дагуу тус ажлыг хийж гүйцэтгэсэн. Дахин төлөвлөлтийн ажлыг хийж гүйцэтгэхдээ 1-р баг амгалан хорооллын | 100% / 70%<br><br>Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин уялдаагүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хангамжийг нэмэгдүүлнэ. | суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, барилгажуулах | | | | | 183 айл өрхтэй биечлэн судалдаа авч ажилласан. Мөн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлтийн явцад нэмэлтээр цэцэрлэг, үйчилгээний барилга, 450 айлын орон сууц, 200 айлын амины орон сууц ногоон байгууламжтай болгох зэрэг төлөвлөлтийн шийдэл гарган төлөвлөлтөд тусган  аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан байна. | Хүрэх түвшин ойлгомжгүй. Журмын 6.2.2.2 |
| 24 5 | | 2. Сумдад гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж, орон сууц барих | 2022 - 2024 | | | 150 | Баруун-Урт сумын 2 дугаар баг, Тээврийн товчооны 9 айлын өмчлөл, эзэмшилийн газрыг газар чөлөөлөлтөнд оруулж 960 айлын орон сууцны хороолол барихаар хэсэгчилсэн төлөвлөгөө хийгдсэн. Баруун-Урт сумын Амгалан гэр хорооллын дахин төлөвлөлт барилгажуулах хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд Ланд овнер ХХК гүйцэтгэж орон сууц, амины хаус хороолол үүсгэх 12.6 га газарт хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулан ажиллалаа.  Баруун-Урт сум 1 дүгээр багт орших Амгалан гэр хороолол нь 15,5 га нутаг дэвсгэрт орон нутгийн хөрөнгө оруулалтаар "Ланд овнер" ХХК ерөнхий төлөвлөгөөг боловсруулан захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн. 2024 оны хагас жилийн байдлаар Амгалан хорооллын инженерийн дэд бүтэц шугам сүлжээний ЗД-20/2024 дугаартай зураг төсөл боловсруулах даалгаврыг боловсруулан ажилласан. Сумдын 2024 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Баруун-урт суманд 1 нэгж талбарын 0,07га, Сүхбаатар суманд 16 нэгж талбарын 1.44га талбайд амины орон сууц барих зориулалтаар Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 136 дугаар | 100% / 70%<br><br>Хүрэх түвшин ойлгомжгүй, шалгуур үзүүлэлттэй уялдаагүй. Төлөвлөлт оновчгүй. Журмын 6.2.2.2 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тогтоолоор батлагдсан | |
| 246 | | 3. Төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон сууцны барилга, хотхон, хороолол барих ажлыг сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн үе шаттай хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | | | Сүхбаатар аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 960 айлын орон сууцны хорооллын инженер дэд бүтэц шугам сүлжээний ажлын зураг төслийг “Сивил инженеринг консалтинг” ХХК СИК-06/2022 шифтэй гүйцэтгэн баталлуулан. “Төсөвт төсөл”ХХК түлхүүр гардуулах нөхцөлтэй шугаман, сүлжээ барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна.Дулаан дамжуулах төв болон цахилгаан түгээх төвийн барилгын ажил гүйцэтгэгдэж дуусч цэвэр усны шугам угсралтын ажил гүйцэтгэгдэж байна. Баруун-Урт сумын 3-р багын нутаг дэвсгэрт баригдаж буй “Шинэ тэмүүлэл” хотхон түрээсийн орон сууцны хөлбөрийн инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Онолт од” ХХК ОД-25/2021 шифртэй гүйцэтгэж шугам сүлжээ угсралтын ажлыг “Гом илч” ХХК цэвэр ус ариутгах татуургын шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэсэн билээ. Орон сууцны хотхоны ажлын зураг төслийг “Редизайн” ХХК боловсруулж барилга угсралтын ажлыг “Голден би ти эс” ХХК гүйцэтгэж А блокийн 56 айлыг орон сууцыг Аймгийн Засаг даргын 2024 оны 05 сарын 08 өдрийн А/271 тоот захирамжаар томилдсон Улсын комиссын бүрэлдэхүүн хуралдан үзлэг шалгалт хийж байнгын ашиглалтад хүлээн авсан. 2024 оны хагас жилийн эцсийн байдлаар Б блокын барилгын 6дугаар давхрын төмөр бетон карказ угсралтын ажил үргэлжилж байна. | 90% / 50%<br><br>Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойлоогүй. Журмын 6.2.3.3. "эрчимжүүлэх шаардлагатай"- зорилт нь .... удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай. |
| 24 | | 4. Түрээсийн | 2021 - | | | | “Ногоон хотхон”-оос 70м2 2 өрөө 1 байрыг орон | 30% / 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | | орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2024 | | | | нутгийн түрээсийн орон сууцны санд авахаар орон нутгийн өмчид бүртгэсэн. Геоканон төв ХХК-ний гүйцэтгэсэн орон сууцны барилгын талбайгаас аймгийн 2020 оны А/531 дугаар захирамжийн дагуу орон нутгийн түрээсийн орон сууцны санд 120м.кв талбайг аваад байна. Баруун-Урт сумын 3-р багын нутаг дэвсгэрт барилгдаж буй “Шинэ тэмүүлэл” түрээсийн орон сууцны хотхон зураг төсөл бэлэн болж нэгдүгээр ээлжийн орон сууцны барилга угсралт ажил гүйцэтгэж байна. Зураг төслийг гүйцэтгэгч “Голден би ти эс” ХХК барилга угсралтын ажлыг “Алтан орд конструшин” ХХК гүйцэтгэж байна. Мөн шугам түрээсийн орон сууц хөлбөрийн инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг “Онолт од” ХХК ОД-25/2021 шифртэй гүйцэтгэж шугам сүлжээ угсралтын ажлыг “Гом илч” ХХК барилга ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авч гүйцэтгэж байна | |
| 248 | | 5. Боловсрол хорооллын доторх тохижилтын ажлыг төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлж дуусгах | 2021 - 2022 | | | | Түмэд групп ХХКомпаний гүйцэтгэсэн тохижилтын ажлын зургийн дагуу тоглоомын талбайн тохижилтыг "Эм Эл Ти Кай" ХХКомпани гүйцэтгэсэн. Боловсрол хорооллын авто замын ажлын зураг төсөл хийгдэж ХОХБТХэлтэст хүлээлгэн өгсөн. | 30% / 30% |
| 249 | 3.6.3. Гэр хорооллыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд | 1. Баруун-Урт хотын Хайлааст гэр хорооллыг цэвэр ус, дулаан, холбоо хангамж, | 2021 | | - | 1 | (АИТХ-ын 2023 оны 7-р тогтоолоор хассан) | 89% / 89% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | холбоно. | ариутгах татуургын шугамд холбох (АИТХ-ын 2023 оны 7-р тогтоолоор хассан) | | | | | | |
| 250 | | 2. Баруун-Урт хотын гэр хорооллын айл өрхийг хэсэгчлэн дулаан хангамжид холбох | 2021 - 2024 | | - | | Баруун-Урт суманд 4 дүгээр багт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Сээмий” ХХК-ны зураг төслөөр "Профэйшнл констракшн" ХХК нэгдүгээр ээлжийн 347м шугам сүлжээ угсралтын ажлыг граффик төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байна. Энэхүү шугам сүлжээ ашиглалтад орсноор тухай багийн 40 гаруй өрх төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох нөхцөл бүрдэж байна. | 70% / 50%<br><br>2023-2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. Журмын 6.2.3.3. "эрчимжүүлэх шаардлагатай"- зорилт нь шалгуур үзүүлэлт, ........ удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай. |
| 251 | | 3. Сумдад хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй | 2022 - 2024 | | - | | Сүхбаатар аймгийн мөнххаан сумын инженерийн байгууламж түүний шугам сүлжээний ажлын зураг, төсөв боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх зургийн | 90% / 70%<br><br>2024 оны Хүрэх түвшин |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | уялдсан инженерийн шугам сүлжээний өргөтгөл хийх | | | | | даалгаврыг 2022.04.14 -ний өдрийн ЗД-037/2022 дугаартай боловсруулан ажилласан. Зураг төсөл зохиох тендерт “ Гидро дизайн инавац” ХХК шалгарч зураг төслийг боловсруулахааар суурь судалгааг хийн орон нутагт, холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулан ажилаж байна. Мөн төр хувийн хэвшилийн түншлэлээр Уулбаян, Түвшинширээ сумын "Сумын хөгжил инженерийн дэд бүтцийн хангамж"-ийн суурь судалгаа зургийн даалгавар боловсруулах ажлын хүрээнд Аймгийн ЗДТГазрын ХБТХОХэлтэс, ГХБХБГазар, сумдын ЗДТГазар, гүйцэтгэгч байгууллага хамтран газар дээр ажиллаж байршлыг сонгон ажиллаж, зургийн даалгавар боловсруулагдан батлагдан /ЗД-013/2023, ЗД-014/2023/. Ажлын зураг, төсвийг боловсруулсан  гүйцэтгэж байна. | тодорхойлоогүй. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. Хэмжих нэгж тодорхойгүй. Хэрэгжилт хангалтгүй. Жүрмын 6.2.2.2 |
| 252 | 3.6.4. Орон нутгийн барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 1. Барилгын материалын лабораторийн барилгыг ашиглалтад оруулах | 2022 | | - | | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын материалын сорил шинжилгээний лабораторийн барилгын ажлын зураг төслийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ММ архитектур ХХК гүйцэтгүүлэн магадлалаар баталгаажуулан хүлээн авсан. Тус ажлын улсын төсвийн тухай хуулийн төсөлд 2020-2023 онуудад хүргүүлсэн боловч хөрөнгө оруулалт батлагдаагүй. Ажлын төсөвт өртөгийг 2023 онд гүйцэтгэгч байгууллагаар шинэчлүүлэн дахин магадлалаар оруулан баталгаажуулж хүлээн авсан. 2025 оны Улсын төсвийн тухай хуулийн төсөлд жагсаалтад дахин оруулж цахим системд шивэлт хийсэн. | 0% / 0% |
| 253 | | 2. Барилгын салбарт эрчим | 2021 - 2024 | 0.4 | - | 0.8 | 2023 оны 05 дугаар сарын 11 өдөр “Их модун” ХХК-ний гүйцэтгэж буй “Спорт цогцолбор”-ын | 90% / 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүчний хэмнэлттэй, ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын үйлдвэрлэлийг дэмжих | | | | | барилга угсралтын талбай дээр “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа-2023” онол, практикийн үзүүлэх сургалтыг амжилттай зохион байгуулав. Уг сургалтанд МБМҮХ-ны МУЗИнженер М.Улаанхүүхэн “Бетоны арчилгаа, материал үйлдвэрлэл, цаашид анхаарах зүйлс, шинэ тоног төхөөрөмж, норм дүрмийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, компаний удирдлага, 70 гаруй инженер техникийн ажилтануудад чухал оновчтой мэдээллийг хүргүүлсэн. "Мөнх өсөх үйлст" ХХК явган зам талбайн үйлдвэрлэл эрхэлж явган замын хавтан 20*20 30*30 хэмжээтэй авто замын брьюдерийг зэргийг үйлдвэрлэн орон нутгийн хэрэгцээг ханган үйлдвэрлэл явуулахад орон нутгаас дэмжин хамтран ажиллаж байна. | 2024 оны хэрэгжилт тодорхойгүй. Тодорхойлсон хүрэх түвшинд хүрээгүй. Үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай. Журмын 6.2.2.3 |
| 254 | | 2. Барилгын хатуу хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин ажиллах | 2024 | | - | 1 | Барилгын хатуу хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах, дахин боловсруулах үйлдвэрлэлийн төсөл, санаачлага ирээгүй байна. | 70% / 0%<br><br>Дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин ажилласан хэрэгжилт байхгүй. Журмын 6.2.3.4. "үр дүнгүй"-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хүрээгүй, ......... удирдлага зохион байгуулалт хангалтгүй. |
| 255 | | 4. Хайрганы карьер, ханын дүүргэгч хөнгөн блок, барилгын бетон хийцийн үйлдвэр барих санал санаачилгыг дэмжих | 2023 | | - | | Хайрганы карьер үйлдвэрлэл, эрхэлж байгаа ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Сэвүүн уудам тал” ХХК (хайрганы карьер) “Бага-Өлгий” ХХК (хайрганы карьер) үйл ажиллагаатай танилцаж гарал үүсэл тодорхой барилгын материал хэрэглэх, түүхий эдийг шинжилгээнд тогтмол хамруулах хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг чанд мөрдөх, шаардлага хангахгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй чанарын стандартын шаардлага хангасан материалыг иргэдэд нийлүүлэх зэрэг мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Үүний дагуу Бага-Өлгий” ХХК-д 1/171, “Сэвүүн уудам тал” ХХК-д 1/175 тоот албан бичгээр барилгын материал үйлдвэрлэгч нарыг стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх, тогтмол лабораторийн шинжилгээнд хамруулах, үйлдвэрлэлийн тасралтгүй хэвийн үргэлжлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллах чиглэлийг хүргүүллээ. Мөн элсний карьер үйл ажиллагаа эхлүүлэх | 90% / 70%<br><br>Шалгуур үзүүлэлт оновчгүй тодорхойлсон. Төлөвлөлт буруу. Журмын 6.2.2.2 |
| 256 | 3.6.5. Аймгийн хэмжээнд хаягжилтын нэгдсэн системийг бүрдүүлнэ. | 1. Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгө, гудамж зам талбайг хаягжуулах | 2021 - 2024 | 0 | - | 20 | Аймаг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 оноос хойш Баруун-Урт сумын 9-н багийн гэр хорооллол, зам талбай, барилга байгууламж үл хөдлөх хөрөнгө, хотхон хорооллуудыг 81.2 хувьтай хаягжуулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэсэн.  Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг бүрэн хаягжуулах, улсын хэмжээний хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг бий | 90% / 70%<br><br>Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах. Хүрэх түвшиндээ хүрээгүй. Хэмжих нэгж тодорхойгүй. Журмын 6.2.2.2 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болгож, хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан дараахь арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд Баруун-Урт сум 100 сая/ төгрөг, Сүхбаатар сум 11 сая төгрөг, Түмэнцогт сум 15 сая төгрөгийг 2024 оны орон нутгийн төсөвт тусгуулсан. Сүхбаатар сум хаягжуултыг шинэ стандартаар орц, гарц суурин судалгааг хийж ГЗБГЗЗЕГазрын серверт уншуулж тэмдэгжүүлэлт хийхэд бэлэн болсон. Сүхбаатар сум 11 сая/төгрөгөөр “Ганга чуулган” ХХКомпаниар хийсэн. Баруун-Урт сумын хаягжуулалтын мэдээллийн санг шинэчлэх, ИТХ-ын тогтоолыг шинэчлэх ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар байгуулахаар хүргүүлээд байна. Ажлын даалгавар боловсруулах төслийг Баруун-Урт сумын Засаг даргад хүргүүлсэн. Түмэнцогт сум хаягийн ажлыг “Эко landmenejment” ХХКомпани 15 сая төгрөгөөр хийж хашаа хайлс, барилга, байгууламж, гудамжинд хаягийн тэмдэглэгээг хийсэн | |
| 257 | | 2. Аймаг, сумын төвийн хаягжуулалтын ажлыг стандартын дагуу хэрэгжүүлж, төлөвлөлтийн дагуу эгнээ гудамжны эмх цэгцийг сайжруулах ажлыг | 2021 - 2024 | | - | 1 | Орон нутгийн төсвийн 74,8 сая төгрөгийн хөрөнгөөр 10181 нэгж талбарт 10869 хаягийн тэмдэг тэмдэглэгээ хийсэн байна. “Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх жагсаалт гаргах” ажлын удирдамжийн дагуу 2020 оны 04 дугаар сарын 24-ний өдөр Сүхбаатар аймгийн Засаг даргын 290 дугаар захирамж /Хавсралт 1/-аар Ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд Хаягийн | 90% / 50%<br><br>Шалгуур үзүүлэлт зорилтод түвшиндээ хүрээгүй. Хаягжуулалтын ажлыг стандартын дагуу хийсэн сумдын хэрэгжилтийн талаар тайлагнаагүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үргэлжлүүлэн зохион байгуулах | | | | | мэдээллийн системийг ашиглан зам, гудамж, талбай, нэгж талбар, үл хөдлөх хөрөнгөнд хаяг, нэр, дугаар олгох, засварлах, өөрчлөлт хийх ажлыг зохион байгуулж дуусгах чиглэлийн дагуу аймгийн газрын даргын Ажил эрчимжүүлэх тухай 2021.02.09-ний өдрийн А/06 дугаар тушаалын дагуу хэрэгжүүлэн ажилсан. Аймгийн хэмжээнд хаягийн мэдээллийн системийн хаягжуулалтын ажлын явц хянасан нэгж талбар 81.2%-тай, хянасан барилга 71.9%-тай байна. Баруун-Урт сумын 3-4 дүгээр тойргийг холбосон авто замын явган зам тавихтай холбогдуулан 2023 онд 5 айл, 2024 онд 6 айлыг газар чөлөөлөлтөнд оруулж явган зам гаргаж замын ажлын явуулан эгнээ гудамж цэгцлэсэн. | Журмын 6.2.2.3 |
| 258 | 3.6.6. Газар өмчлөлийг эрчимжүүлнэ. | 1. Дэд бүтцийн хангамжид тулгуурлан иргэнд газар өмчлүүлэх боломжтой газрын нөөцийг тогтоож газрыг өмчлүүлэх | 2021 - 2024 | 16.5 | - | | 2022 онд сумдад тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Сүхбаатар аймгийн хэмжээнд 1239 нэгж талбар 103.57га газрыг өмчлүүлэхээр тусгагдан батлагдсан. 2022 оны 11 дүгээр сарын 23-ний байдлаар 224 нэгж талбарын 19.74 га газрыг өмчлүүлээд байна. Сүхбаатар аймгийн хэмжээнд Монгол Улсын иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтын саналыг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 07 дугаар тогтоолоор 1353 иргэнд 105.07га газрыг өмчлүүлэх саналыг баталсан. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т "Аймаг, нийслэлийн саналыг үндэслэн тухайн жилд улсын хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох" гэж заасны дагуу Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 137 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд нийт 154 иргэнд 12.9га газрыг | 50% / 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өмчлүүлэхээр тусгасан. 2024 онд Баруун-Урт суманд 686 иргэнд газар өмчлүүлэх нөөц газрын төлөвлөгөө боловсруулан сум болон аймгийн ИТХ-ын тогтоол гаргуулан ЗГ-т хүргүүлсэн боловч батлагдаагүй. | |
| 309 | 4.3.1. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг өргөжүүлнэ. | 1. Аймаг, сумын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, камержуулах ажлыг үе шаттай зохион байгуулж, камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх | 2021 - 2024 | 30 | - | 80 | Баруун-Урт сумыг камерын нэгдсэн хяналтад үе шаттай авч, хүний биеийн давтагдашгүй өгөгдөл, царайгаар таних камерын системийн нэгдсэн хяналтын төвийг тус цагдаагийн газарт байгуулан гэмт хэрэг, зөрчилгүй "Ногоон бүс" буюу "Аюулгүй Баруун-Урт" камерын хяналтын нэгдсэн бүстэй болох ажлыг эхлүүлэх зэрэг 426.522.000 төгрөгийн өртөг бүхий ажил, арга хэмжээг санаачлан орон нутгийн төсөвт тусгуулахаар санал хүсэлт, материалыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, тус цагдаагийн газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/21 дугаартай тушаалаар Баруун-Урт сумын төвийг бүрэн камержуулж, телекамерын хяналтын төвийг тус цагдаагийн газарт байгуулан, гэмт хэрэг, зөрчилгүй "НОГООН БҮС" болгох ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах 13 алба хаагчийн нэрсийг хавсралтаар батлуулж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. "Ногоон бүс" төслийн хүрээнд иргэн, ААН байгууллагын дэмжлэгтэйгээр нийтийн эзэмшлийн зам, гудамж талбайг камержуулах ажлыг зохион байгуулж, 2024 оны 10 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд 368 ширхэг хяналтын камерыг суурилуулж, аймгийн төв, сумдад ашиглагдаж байгаа 1070 ширхэг камерыг бүртгэлийн нэгдсэн системд бүртгэсэн. | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Цагдаагийн газарт байсан “Камерын хяналтын дэд төв”-ийг энэ оны 10 дугаар сард Баруун-Урт сумын ЗДТГ-т тус төвийн үйл ажиллагаа, арчлалт, хамгаалалтыг шилжүүлж, 7 дугаар багт байх орон нутгийн өмчит “Дөрвөлж” ХХК-ийн байрны 1 давхарт “Камерын хяналтын дэд төв”-ийн техник, тоног төхөөрөм, засвар үйлчилгээ, холболт хийх ажлын зардалд 20.000.000 төгрөгийг Баруун-Урт сумын ЗДТГ-аар шийдвэрлүүлсэн. “Камерын хяналтын дэд төв”-ийн байранд засвар үйлчилгээ хийж, шал, техник хэрэгслийг суурилуулж дуусгасан. “Камерын хяналтын дэд төв”-ийг шилэн кабелаар газраар холбох, сувагчлал хийх, холбоожуулалтын ажлыг аймгийн “Мэдээлэл, холбоо сүлжээ” ХХК-иар гүйцэтгүүлэв. | |
| 310 | | 2. Аймгаас гарах, орох төв замуудад дугаар илрүүлэгч бүхий хяналтын камер суурилуулах | 2023 - 2024 | 0 | - | 1 | Аймаг орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 оны 3 дугаар улирлаас Баруун-Урт сумын 9 дүгээр багт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 60.0 сая төгрөгийн өртөг бүхий теле хяналтын камерыг суурилуулахаар зураг төсөвийг гарган ажиллаж байна. Одоогоор ашиглаж байгаа нийт 115 ширхэг теле хяналтын камерыг нэгдсэн системд холбон хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд Баруун-Урт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тогтоол гаргуулан теле хяналтын камерыг хариуцах байгууллагыг тогтоож урсгал засварын хөрөнгийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Теле хяналтын камераар энэ онд 230 зөрчил илрүүлж хариуцлага тооцон ажилласан. Энэ онд аймгийн төвд нийт 9.2 км газарт хатуу хучилттай зам тавьсан бөгөөд замын дагуу орчин үеийн гэрэлтүүлэг сайтай гэрлийг тавьж байршуулсан. Мөн Баруун-Урт | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сумын 5 дугаар багийн нутагт шинээээр гэрэлтүүлэг тавьж ажилласан. Мөн аймгийн 80 жилийн ойг тохиолдуулан байгууллага, аж ахуй нэгжийн гадна гэрэлтүүлгийг сайжруулж аймгийн өнгө үзэмж, соёлыг дээшлүүлж ард иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан. Төсөв батлагдсаны дагуу энэ онд Баруун-Урт сумын төвийг камержуулах ажилд 600.0 сая төгрөгөөр Баруун-Урт сумын төвөөс гарах, орох 9 гарцад дугаар танигчтай 18, чиглэлийн 9 ширхэг, нийт 27 ширхэг камер суурилуулах, 9 гарц руу шилэн кабел татах дэд бүтцийн ажил хийлгэхээр зураг төслийг гаргуулж, Барилга хөгжлийн төвөөр хянан магадлуулж, нээлттэй тендерийг 10 дугаар сард зарлуулсан. Тендэрт “Сервис зоне” ХХК шалгарсан боловч бусад өрсөлдөгч компаниудаас гомдол гаргасан учир гомдлыг хянан хэлэлцэх шатанд явж байна. Уг гомдлыг хянан хэлэлцсэний дараагаар ажлын гэрээ байгуулах, эсвэл дахин тендер зарлагдах эсэхийг шийдвэрлэх юм. | |
| 311 | | 3. Баруун-Урт хотын төвд 2019 онд суурилуулсан телекамерын түрээс, цахилгааны төлбөр, засвар үйлчилгээний урсгал зардлыг аймаг, сумын төсөвт суулган жил бүр | 2021 - 2024 | - | - | | Тус телекамерийн түрээс, цахилгааны төлбөр, засвар үйлчилгээний урсгал зардлыг аймаг, сумын төсөвөөс жил бүр 3 сая төгрөгөөр санхүүжүүлдэг. | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | санхүүжүүлэх. | | | | | | |
| 312 | | 4. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Баруун-Урт, Чингис хот чиглэлийн замд "дундаж хурд тодорхойлох" технологи, туршлагыг судалж нэвтрүүлэх | 2022 - 2024 | 0 | - | | Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Баруун-Урт, Чингис хот чиглэлийн замд "дундаж хурд тодорхойлох" чиглэлээр хяналтын постны үйл ажиллагааг эрчимжүүлж постоор дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийг шалгаж гарсан цаг минутыг постод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид дамжуулж явсан цаг минутыг тодорхойлж ажиллаж байгаа бөгөөд цаашид орчин үеийн техник технологийн шийдлийг нэвтрүүлж ажиллахаар улсын чанартай A2001 авто замд дундаж хурд хэмжих теле камерийн үнийн санал техникийн нөхцөлийг “Оргил делта” трейд ХХК-с авч 126,522,000₮ төгрөг шийдвэрлүүлэхээр саналыг хүргүүлээд байн | 50% / 30%<br><br>2023-2024 онд хүрэх түвшинг тодорхойлоогүй. 2022 оны үр дүнгээс ахиц гараагүй. Журмын 6.2.2.4 |
| 313 | | 5. Хүний биеийн давтагдашгүй өгөгдөл, царайгаар таних хяналтын төхөөрөмжүүдийг байрлуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх | 2023 - 2024 | - | - | | Баруун-Урт сумыг камерын нэгдсэн хяналтад үе шаттай авч, хүний биеийн давтагдашгүй өгөгдөл, царайгаар таних камерын системийн нэгдсэн хяналтын төвийг тус цагдаагийн газарт байгуулан гэмт хэрэг, зөрчилгүй “Ногоон бүс” буюу “Аюулгүй Баруун-Урт” камерын хяналтын нэгдсэн бүстэй болох ажлыг эхлүүлэх зэрэг 426.522.000 төгрөгийн өртөг бүхий ажил, арга хэмжээг санаачлан орон нутгийн төсөвт тусгуулахаар санал хүсэлт, материалыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, тус цагдаагийн газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/21 дугаартай тушаалаар Баруун-Урт сумын төвийг бүрэн камержуулж, телекамерын хяналтын | 70% / 70%<br><br>Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төвийг тус цагдаагийн газарт байгуулан, гэмт хэрэг, зөрчилгүй “НОГООН БҮС” болгох ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах 13 алба хаагчийн нэрсийг хавсралтаар батлуулж, бэлтгэл ажлыг ханган ажилласан. Энэ оны 3 дугаар сарын 11-ний өдөр аймгийн Засаг дарга М.Идэрбат болон нутгийн удирдлагууд Улаанбаатар хотод очиж, тус төслийн хэрэгжилт, үр дүнгийн талаар мэдээлэл авч, нийтийн эзэмшлийн талбайд суурилуулсан камеруудын дүрсийг нэгтгэж харах зорилго бүхий 25 ширхэг ханан дэлгэц бүхий нэг дор 800 ширхэг камерын дэлгэцийг хянах стандартын шаардлагад нийцсэн зориулалтын шал, хана, хөргүүр зэрэг цогц дэвшилтэд технологитой танилцаж, туршлага судалж ажилласан бөгөөд “НОГООН БҮС” төслийн ажил эхлэнэ. 2024 онд Баруун-Урт сумын 9-р багийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 24 ширхэг камерыг суурилуулсан бөгөөд үүнээс хүний царай таних 2, дугаар таних 2, чиглэлийн 20 ширхэг камер ажиллаж байна. Камерын хяналтын дэд төвийн үйл ажиллагаа ашиглалтад орохоор нэгдсэн системд холбох ажлыг зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд ашиглана. | |
| 314 | | 6. Аж ахуйн нэгж, байгууллага, ялангуяа шатахуун түгээх станц, барьцаалан зээлдүүлэх, | 2021 - 2024 | 55 | | 100 | "Баруун-Урт сумын 2, 7 дугаар баг, орон сууцны хороололд “Талын технологи” компаниар 18 ширхэг 360 градусын PTZ камер, 8 ширхэг чиглэлийн камер суурилуулж хяналтыг Баруун-Урт сумын нэг цэгийн үйлчилгээний төвд, мөн Баруун-Урт сумын замын хяналтын постод 3 ширхэг теле хяналтын камер шинээр суурилуулж, цагдаагийн газрын жижүүрийн | 100% / 70%<br><br>2024 оны хэрэгжилт тодорхойгүй, 2023 оны тайлагналыг хуулбарласан. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | интернет тоглоомын газар болон томоохон худалдаа, үзвэр, үйлчилгээний газрууд, гудамж талбайн хяналтын камерын системийг цагдаагийн газрын нэгдсэн сүлжээнд холбох | | | | | шуурхай албаны хяналтын төвтэй тус тус холбосон. Баруун-Урт сумын авто замын гэрлэн дохиотой 7 уулзварын теле хяналтын камержуулалтын техникийн тодорхойлолтыг гаргуулан, гүйцэтгэлийн ажлыг “Иносолюшн” ХХК нь гэрлэн хөдөлгөөнт 7, чиглэлийн 28 ширхэг камер суурилуулан цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албаны хяналтын төвтэй тус тус холбосон. Ингэснээр гудамж талбай, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг цагдаагийн байгууллагын хяналтад авч ажиллаж байна. Аймгийн засаг даргад телехяналтын камерын шилэн кабелийн түрээсийн төлбөр шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг холбогдох тооцоо судалгааны хамт хүргүүлсний үр дүнд түрээсийн төлбөрт 5 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлүүлсэн." | Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. Журмын 6.2.2.2 |
| 315 | | 7. Гэмт халдлагад өртөж болзошгүй эд зүйл, мал, амьтны байршил тогтоох техникийн шийдэл, дэвшилтэт технологи, программ хангамжийг нэвтрүүлэх. | 2021 - 2024 | 0 | - | | Аймгийн цагдаагийн газарт Evo-2 маркийн 2020 онд үйлдвэрлэсэн бүрэн цэнэгээрээ 30 минут ажиллах, дээд өндөр 800М, Level 7 буюу 10м/с-12,5м/с салхинд нисэх чадалтай, далайн түвшинээс 5000М өндөрт нисэх сэнстэй, 58 Gb хүртэл SD card дэмждэг, дээд хурд 68км/цаг хурдлах хүчин чадал бүхий дроныг шийдвэрлэж өгсөнөөр аймгийн төвийн гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гудамж талбай багуудын нутаг дэвсгэрт эргүүл, хяналтын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байна. Мөн энэ хугацаанд хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулагдсан олон нийтийг хамарсан Улсын баяр наадам, Сар шинэ, жагсаал цуглаан, хурдан морины уралдааны хамгаалалтын үед нийтийн хэв журам зөрчиж болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зарим цэг, байршлыг хяналтад авах, өрнөсөн үйл явдалыг | 100% / 50%<br><br>Хүрэх түвшин тодорхойлоогүй. 2021-2022 онд хэрэгжилтгүй. 2024 оны хэрэгжилт тодорхойгүй, 2023 оны хэрэгжилтийг хуулбарлан тайлагнасан. Журмын 6.2.2.3 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | баримтжуулах, аливаа үйл явдлыг сэргээн дүрслэх нотлох баримт бүрдүүлэх зорилгоор ашигласан нь үр дүнтэй, сэжиг бүхий этгээдүүдийн сэтгэл зүйд шууд нөлөөлж, гаргах байсан үйлдэл, зорилгыг нь хязгаарласан урьдчилан сэргийлэх чухал арга хэмжээ болсон | |
| 316 | | 8. Хүн, мал тээврийн хэрэгслийн мэдээллийг шалгах цахим төхөөрөмжөөс хайлт хийх, илрүүлэх зэрэг цахим мэдээллийн санд суурилсан бүртгэл хяналтын системийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрэн сурвалжлах, зарлан мэдээлэх, ажилд өргөнөөр нэвтрүүлж, ашиглах хүртээмжийг нэмэгдүүлэх. | 2021 - 2024 | 0 | | 100 | Цагдаагийн байгууллагын хэмжээнд ашиглагдаж буй Од, ISC, “research.police.gov” зэрэг цахим сангуудыг цагдаагийн газрын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлт бүхий мэдээллийг нэгтгэн боловсруулж, цахим санг бүрдүүлэн, тогтмол нэмэлт баяжилтуудыг хийж ажилласнаар алба хаагчдын программыг ашиглах үйл ажиллагаа улам нэмэгдэж, алба хаагчдын ажлын ачаалал, судалгаа, шинжилгээ хийх ажлыг хөнгөвчлөх ач холбогдол болсон Энэ оны эхний хагас жилийн байдлаар сураггүй алга болсон хүн 15 зарлаж 15 олж тогтоон үлдэгдэл 0, Оргодол 10 зарлаж 9 олж тогтоон үлдэгдэл 1, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 85 зарлаж 72 олж тогтоон үлдэгдэл 13, цогцос 3 зарлаж 3 хэн болохыг тогтоож үлдэгдэл 0, Мал амьтан 4 зарлаж 2 олж тогтоон үлдэгдэл 2, Эд зүйл 26 зарлаж 9 олж тогтоон үлдэгдэл 17, Шүүхээс даалгасан хүн 18 зарлаж 12 олж тогтоон үлдэгдэл 6, Зөрчил үйлдсэн этгээд 14 зарлаж 11 олж тогтоон үлдэгдэл 3, нийт 175 хүн, мал, эд зүйл эрэн сурвалжлалт зарлаж, 133-г олж тогтоон ажилласан нь илрүүлэлт 76.0 хувьтай байна. 2024 онд цагдаагийн байгууллагын нэгдсэн системд алба хаагч бүр өөрийн эрхээр нэвтэрч орох боломжтой бөгөөд өргөдөл, гомдол, гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл хөтлөх, баяжилт хийх, хүн, мал, тээврийн хэрэгсэл гэх мэт бүх төрлийн | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрэн сурвалжлалтыг зарлах, зогсоох, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийн мэдээллийг шалгах, хайлт хийх, хүний нөөц, судалгаа хяналт тогтоох зэрэг өдөр тутмын бүх ажиллагаандаа  ашиглаж байна. Гудамж, замын эргүүл, нийтийн хэв журам сахиулах хөдөлгөөнт эргүүл, улсын онц чухал объектод үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагч бүр дээрх бүх мэдээллийг ашиглах боломжтой “X cover” багажтай бөгөөд байгууллагын хэмжээнд бүх пост, эргүүлийн чиглэл, сум бүрт хүртээмжтэй бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. | |
| 317 | | 9. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж болох “Дроны эргүүл”-ийг бий болгож, эмзэг цэгүүдийг хянаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх | 2021 - 2024 | 0 | 5 | 1 | Аймгийн цагдаагийн газарт Evo-2 маркийн 2020 онд үйлдвэрлэсэн бүрэн цэнэгээрээ 30 минут ажиллах, дээд өндөр 800М, Level 7 буюу 10м/с-12,5м/с салхинд нисэх чадалтай, далайн түвшинээс 5000М өндөрт нисэх сэнстэй, 58 Gb хүртэл SD card дэмждэг, дээд хурд 68км/цаг хурдлах хүчин чадал бүхий дроныг 5.000.000 төгрөгөөр шийдвэрлэж өгсөнөөр аймгийн төвийн гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гудамж талбай багуудын нутаг дэвсгэрт эргүүл, хяналтын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байна. Мөн энэ хугацаанд хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулагдсан олон нийтийг хамарсан Улсын баяр наадам, Сар шинэ, жагсаал цуглаан, хурдан морины уралдааны хамгаалалтын үед нийтийн хэв журам зөрчиж болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зарим цэг, байршилыг хяналтад авах, өрнөсөн үйл явдлыг баримтжуулах, аливаа үйл явдлыг сэргээн дүрслэх нотлох баримт бүрдүүлэх зорилгоор ашигласан нь үр дүнтэй, сэжиг бүхий | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | этгээдүүдийн сэтгэл зүйд шууд нөлөөлж, гаргах байсан үйлдэл, зорилгыг нь хязгаарласан урьдчилан сэргийлэх чухал арга хэмжээ болсон. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж болох “Дроны эргүүл”-ийг бий болгож, эмзэг цэгүүдийг хянаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тус цагдаагийн газраас 2024 оны 6, 7, 8 дугаар саруудад буюу амралт, аялал, зугаалгын дулааны улиралд иргэд ихээр цуглардаг, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй цэгүүд, Дөрвөлж толгой, Уртын гол орчим зэрэг газруудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Дроны эргүүл”-ийг 7 хоног бүрийн амралтын өдрүүдэд зохион байгуулж ажилласан. Эргүүлийн хугацаанд 21 зөрчлийг илрүүлж, үйлдлийг таслан зогсоох, хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, холбогдох хуулиар хариуцлага тооцож ажилласан. | |
| 318 | 4.3.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог хангана. | 1. Аймгийн хэмжээнд гаралт ихтэй зарим төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн дэргэд Хулгайлах гэмт | 2021 - 2024 | 0 | | 5 | "  Иргэдэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээлэл өгөх зорилгоор Баруун-Урт сумын Иргэдийн нийтийн хурал, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн эзэд, сумдын төрийн байгууллагын алба хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад 45 удаагийн сургалтыг зохион байгуулж 2300 хүн хамрагдсан. Аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, илрүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор “Бод”, “Малын хулгай” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан. Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт өөрийн хариуцсан сум, багийн харьяа байдаг согтууруулах ундаа тогтмол хэрэглэдэг, архины хамаарал бүхий иргэдийн судалгааг шинэчлэн гаргаж цагдаагийн байгууллагын “Судалгаа, | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэргээс урьдчилан сэргийлэх, Архидан согтуурахтай тэмцэх, Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх дэд зөвлөлүүдийг байгуулж ажиллуулах | | | | | хяналтын сан"-д баяжилт хийж нийт 28 иргэнийг бүртгэл судалгаанд авч Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулдаг "Мандах нар" "Зөв боломж" зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран архины хамааралтай иргэдэд согтууруулах ундаанаас татгалзах, түүний хор уршгийн талаар сургалт зохион байгуулж архины хамаарал бүхий иргэдийг албадан хамруулах ажлыг /Өглөө эрт архи уухаас нь өмнө гэрээс нь цуглуулах ажлыг 7 хоног бүрийн лхагва, ням гаригт 8 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 180 иргэнийг сургалтад хамруулах ажлыг хамтран зохион байгуулж ажилласан одоогоор эдгээр иргэдээс 5 иргэн архинаас татгалзсан үр дүн гарсан. .Бага насны хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Засаг даргын захирамжаар төлөвлөгөө батлуулсан. Мөн 2023.06.13-ны өдрийн 14.00 цагаас сумдын ИТХ-н ажлын алба, сум багийн Засаг дарга, Тамгын газрын дарга, Хууль, эрх зүйн мэргэжилтэн, сумдын хэсгийн төлөөлөгч нараас бүрдсэн 35 орчим төрийн албан хаагчидтай гүүгль миитээр цахим уулзалт зохион байгуулсан. Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дэргэдэх түр хамгаалах байранд 2024 оны 5-р сарын байдлаар үйлчлүүлсэн хохирогч иргэдийн тоо 25 ХЗДХС-ын А/39 дугаар тушаалаар батлагдсан "Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам", Монгол улсын стандарт MNS 6040:2019 "Хохирогчий | |
| 319 | | 3. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг, гэр бүлийн | 2021 - 2024 | 0 | | 100 | Ази номхон далайн бүс нутгийн цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжаар Хууль зүй дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банкны хамтарсан төслийн дагуу 253.6 сая төгрөгийн | 100% / 50%<br><br>2022 он үр дүнгээс хойш |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүчирхийллээс хамгаалах зорилгоор Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдсан “Түр хамгаалах байр”-ны урсгал зардлыг шийдвэрлэх | | | | | санхүүжилтээр нэг удаа 8 хүн хүлээн авах боломжтой 177 мкв талбай бүхий түр хамгаалах байр байгуулагдсан. Барилга байгууламжийг 2022 оны 07 дугаар сарын 02-ны өдөр ашиглалтад оруулж үйл ажиллагааг явуулж байна. 2022 онд аймгийн орон нутгийн төсвөөс Хамгаалах байрны үйл ажиллагааны зардалд 90.000.000 төгрөг батлуулж шийдвэрлэсэн. | ахиц байхгүй. Журмын 6.2.2.3 |
| 320 | | 4. Өсвөр үеийнхэн, ерөнхий боловсролын сурагчдыг хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, уруу татагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зохих мэдлэг олгох, хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг сурталчлах чиглэлээр “Үзүүлэн кабинет” байгуулах. | 2021 - 2024 | 0 | | 100 | ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газар Боловсролын ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран #АНЗААР арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд төрийн байгууллагын 67 албан хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 350 сурагчдад "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх урьдчилан сэргийлэх, хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаанд анхаарах" сэдвээр сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулсан. 2024 онд Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт байрлах Боловсрол-Өргөө дотуур байр, Ерөнхий боловсролын 1-4 дүгээр сургуулийн нийт 3004 сурагчид “Бэлгийн хүчирхийлэл”, “Хүүхдийн эрх, дээрэлхэл гэж юу вэ” “Электрон тамхины хор хөнөөл”, “Хар тамхи мансууруулах бодис гэж юу вэ” сэдэвт 15 удаагийн сургалт мэдээллийг тавьж ажилласан. Сүхбаатар аймгийн хэмжээнд сургуулийн насны болон бага насны хүүхэд хар тамхи хэрэглэх, мансууруулах төрлийн бодис, газ цавуу үнэрлэх гэх мэт тохиолдлууд бүртгэгдээгүй, мансуурдаг | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүүхэд бүртгэгдээгүй болно. | |
| 321 | | 5. Баруун-Урт хот, Мөнххаан, Түмэнцогт сумдад баригдсан замын хяналтын постын аюулгүй байдлыг хангах зорилгоор стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулах | 2021 | 10 | | | Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум, Мөнххаан, Түмэнцогт сумдад баригдсан замын хяналтын постын аюулгүй байдлыг хангах зорилгоор стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулсан | 100% / 70%<br><br>Мөнххаан суманд хийгдсэн ажил тодорхойгүй. Шалгуур үзүүлэлт зорилтод түвшиндээ хүрээгүй. |
| 322 | | 6. Баруун-Урт хотын төв болон хот хоорондын төв магистрал замуудын тэмдэг, тэмдэглэгээнд үзлэг, шалгалт хийж, стандартад нийцүүлэн засаж өөрчлөх, шинээр нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 345 | 27 | 95 | Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2022 онд 27 сая төгрөг шийдвэрлүүлж Баруун-Урт сумын төвд шинээр 96 ширхэг замын тэмдэг суулгуулах ажилд “Наран булаг Сүхбаатар принтринг” ХХК шалгарч ажлыг хэрэгжүүлсэн. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохицуулах салбар зөвлөлөөс “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд улсын чанартай А2001 авто зам дагуу “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” гэсэн агуулга бүхий зурагт самбар 18 ширхэгийг байршуулан гарч болзошгүй зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэн ажилласан, Сүхбаатар аймгийн “Талын зам” ТӨХК-д цагдаагийн газрын замын цагдаагийн тасгаас энэ онд 4 удаа албан мэдэгдэл хүргүүлж Улсын чанартай А2001 авто замд тэмдэг, замын эвдэрсэн хэсэг үзлэг тооллого хамтран зохион байгуулж илэрсэн зөрчилд засвар үйлчилгээг | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийлгэн ажилласан. Мөн зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор улсын чанартай А2001 авто замын 10 километр тутамд нийт 17 ширхэг хэвтээ хурд сааруулагчийг байршуулсан. Мөн аймгийн төвийн сургууль, цэцэрлэгийн ойролцоох замуудад 7 ширхэг хурд сааруулагчийг шинээр хийж байршуулсан.Мөн Баруун-Урт сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэр болон төвийн баг, 4 замуудын уулзвар, гарцууд зэрэг хяналтын камер ажиллаж байгаа цэгүүдэд иргэдэд мэдээлэх зорилгоор "Хяналтын камер ажиллаж байна" гэсэн 72 ширхэг тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан. | |
| 323 | | 8. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдтэй хамтран тогтмол зохион байгуулах, мэдээлэх. | 2021 - 2024 | 0,916 | | 98 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн 1-р үе шат буюу эрх зүйн хөтчийн тогтолцоо бий болгох хүрээнд сум тус бүрээс 2-с доошгүй төрийн албан хаагч, нийт 47 хүнийг сонгож, эрх зүйн хөтчөөр ажиллах гэрээ байгуулан, АЗДТГ-ийн ХЭЗХ-ээс арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллаж байна. Эрх зүйн хөтчүүдийг чадавхжуулах зорилгоор "Эрх зүйн хөтчийн цахим сургалтын платформ"-оос анхан шатны сургалтад цахимаар хамрагдах ажлыг сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулаа. 2023 онд ХЗҮХ-тэй хамтран Байгаль орчны хууль тогтоомжийн чиглэлээр эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалтыг танхимаар зохион байгуулж, 44 эрх зүйн хөтөч буюу 93.6 хувь нь хамрагдаж, гэрчилгээ авсан. Уг хөтөлбөрийн 2-р үе шатанд бэлтгэгдсэн эрх зүйн хөтчүүд нь иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, нөлөөлийн арга хэмжээ зохион байгуулах, иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөөг үнэ төлбөргүй үзүүлэх | 100% / 90%<br><br>Суурь түвшин ойлгомжгүй. Хөтөлбөрийн хэрэгжилийн биелэлт тодорхойгүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бөгөөд бүх эрх зүйн хөтчүүдийг бүртгэлийн дэвтрээр хангасан, мөн эрх зүйн хөтчөөр сонгогдсон төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллуулах, эрх зүйн хөтчөөр ажиллах талаар арга хэмжээг албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг тооцон, урамшуулж ажиллах талаар сумдын ТГД нарт мэдээлэл хүргүүлж ажилласан. Мөн бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээг жил бүр ХЗҮХ-д хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилладаг ба 230 удаагийн сургалт, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, давхардсан тоогоор 229 аж ахуй нэгж, байгууллагын 4212 албан хаагч, иргэд хамрагджээ. Сургалтыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 110, бусад сэдвээр 120 удаагийн сургалт зохион байгуулсан. | |
| 324 | | 9. Хүүхдийг багаас нь зөв хүн болгон төлөвшүүлэх, хууль дээдлэх, эрх зүйн боловсрол олгох, аливаа асуудлыг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, соёл, | 2021 - 2024 | 0 | | 8 | Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Нэгдсэн эмнэлгийн өсвөр үеийн бэлгийн замын халдвартын их эмч, Хууль зүйн туслалцааны төвийн Сүхбаатар аймаг дахь салбарын улсын өмгөөлөгч нартай хамтран ерөнхий боловсролын 1, 2, 3, 4 дүгээр сургуулийн ахлах ангийн 320 сурагчдад хууль, эрх зүйн болон эрүүл мэнд, хүүхдийн хөгжил, хүмүүжил төлөвшил, өөрийгөө хэрхэн хөгжүүлэх мэдлэг, чадварыг олгох соён гэгээрүүлэх "Өртөөчилсөн сургалт"-ыг үе шаттай зохион байгуулан ажилласан. Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан үүргийн дагуу Баруун-Урт | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | харилцааны ур чадвар олгоход чиглэсэн цогц арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх. | | | | | сумын 1, 2 дугаар багийн ажлын алба, хүүхдийн оролцооны байгууллагын гишүүдтэй хамтран зорилтот бүлгийн 9 гэр бүлийн 21 хүүхдийг оролцуулан хууль, эрх зүйн мэдлэг олгох, өөрийгөө хэрхэн хамгаалах, хэнд хандаж байх чиглэлээр соён гэгээрүүлэх өдөрлөгийг 2022 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгууллаа. Энэ үеэр ая тухтай орчныг бүрдүүлж оролцооны байгууллагын хүүхдүүд хөгжөөнт тоглоом тоглуулж, ая дууны мэндчилгээ дэвшүүлж, идэвхтэй оролцсон 21 хүүхдэд багийн ажлын алба, хүүхдийн оролцооны байгууллагаас 300.000 /гурван зуун мянга/ төгрөгийн гарын бэлэг өгч урамшуулав. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан эрх, үүргийн дагуу гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхдийг илрүүлэх, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдтэй өдөр бүр уулзаж, үйлчилгээ үзүүлдэг гэр хорооллын хүнсний дэлгүүрийн 48 худалдагч, худгийн ус түгээгч, багийн засаг дарга, анги даасан багш, өсвөр үеийн эмч, өмгөөлөгч зэрэг оролцсон 10 төрийн байгууллага, 2 төрийн бус байгууллагатай хамтран иргэдэд сургалт, мэдээллийг зохион байгуулж, мэдээ, мэдээлэл солилцон, зөвлөмж өгч, хүчирхийллийн дуудлага мэдээлэл өгөх утасны дугаар бүхий гарын авлага, санамж сэрэмжлүүлэг 130 ширхэгийг тараасан. | |
| 325 | | 10. Тухайн хүн гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс | 2021 - 2024 | 0 | | 2 | Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн алба хаагч нар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран 2022 оны 05 дугаар сарын | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | урьдчилан сэргийлэх, түүний зан үйл, ёс суртахуунд нөлөөлж, хандлагыг өөрчлөх замаар гэмт үйлдлээс сайн дураараа татгалзах нөлөөллийн арга хэлбэрийг үе шаттай хэрэгжүүлэхэд гэр бүл, ойр дотны хүмүүсийн дэмжлэгийг авч хамтран ажиллах. | | | | | 23-наас 26-ны өдрүүдэд сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааг шалган мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн бөгөөд сум тус бүрийн онцлогт тохируулан иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж, аль болох гэмт хэрэг, зөрчлөөс сайн дураараа татгалзах нөлөөллийг хүргэж ажилласан. MERIT төсөл нь Сүхбаатар аймгийн ЗДТГ-тай хамтран аймгийн төрийн албаны хүний нөөцийн суурь судалгааны үр дүнг танилцуулах семинарыг 2022 оны 6-р сарын 8-ны өдөр Баруун-Урт хотноо Төрийн албаны зөвлөл, аймгийн ЗДТГ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, сумдын ЗДТГ-ын төлөөллөөс бүрдсэн нийт 63 албан хаагчдад зохион байгуулж төрийн албан хаагчдын ерөнхий шинж байдал, тогтвор суурьшил, хүний нөөцийн хангалт, сургалт хөгжил, нийгмийн баталгаа, ёс суртахуун, ажлын байрны сэтгэл ханамж, ур чадварын зөрүүгийн үнэлгээ зэрэг багц сэдвүүдийн хүрээнд сургалт орсон. | |
| 326 | | 11. Гэмт хэрэг үйлдэж болзошгүй нөхцөлд байгаа болон хорих ял эдлээд суллагдсан этгээдэд хяналт тавих, нийгэмд дасан зохицох, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох | 2021 - 2024 | 0 | | 95 | Хоригдлыг нийгэмшүүлэх ажлын зааврын дагуу хоригдолд давтан гэмт хэрэг үйлдэх, оргон зайлахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хууль тогтоомж, танин мэдэхүйн болон зөвлөмжит 15 цагийн сургалтуудыг аудио хэлбэр, цахим ном, зарлан мэдээлэх систем ашиглан зохион байгуулсан. Хоригдол, хоригдогч нарын эрхийг хангах, ахуй нөхцөлийг сайжруулах, нийгэмшүүлэх, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжийг олгох зорилгоор Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж буй “Насан туршийн агболовсролын төв”, “Улаан загалмайн хороо”, “Сүхбаатар аймаг дахь Төв | 90% / 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | боломжийг бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах | | | | | номын сан", "Гэр бүл, хүүхэд залуучуудын Хөгжлийн газар"-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх, үйлдсэн гэмт хэрэг, тэдгээрээс үүсэн гарах үр дагаврыг ойлгуулах, хорих ялын зорилтыг хангах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх болон бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу дангаар, мөн төрийн, төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж байна. | |
| 327 | 4.3.3. Мал хулгайлах гэмт хэргийг иргэдийн оролцоо, дэвшилтэт технологи ашиглан илрүүлэлтийг нэмэгдүүлнэ. | 1. Аймгийн хэмжээнд 2018 оноос батлан хэрэгжүүлж буй "Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх | 2021 - 2024 | 0,85 | | 90 | Аймгийн хэмжээнд 2018 оноос батлан хэрэгжүүлж буй "Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Тус цагдаагийн газраас 2022 он гарсаар мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор "БОД", "ДАЙЧИЛГАА" зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулснаар Баруун-Урт, Мөнххаан, Сүхбаатар, Уулбаян, Эрдэнэцагаан сумдын нутаг дэвсгэрээс 2021 оны 03 дугаар сараас 2022 оны 02 дугаар сарын хугацаанд 17 удаагийн үйлдлээр иргэдийн 77 бод, 92 бог малыг хулгайлж бусдад 160.600.000 /нэг зуун жаран сая зургаан зуун мянган/ төгрөгний хохирол учруулсан 17 холбогдогчтой хэргийг илрүүлж, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж шүүхэд шилжүүлсэн. Мал хулгайлах 55 хэргээс хэрэг бүртгэлтийн 27, мөрдөн байцаалтын 28 байна. Хэрэг бүртгэлтийн 27 хэргээс 17 хэргийг | 70% / 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | илрүүлж эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан нь мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 62.9 хувьтай, одоо эзэн этгээд нь тогтоогдоогүй хэрэг бүртгэлтийн 10 хэргийн үлдэгдэлтэй байна. | |
| 328 | | 2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг татан оролцуулах, тэдний дэмжлэг туслалцааг авах зорилгоор "Малын хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх сан" -г үүсгэн байгуулах (АИТХ-ын 2023 оны 7-р тогтоолоор хассан) | 2021 | 0 | | 97 | (АИТХ-ын 2023 оны 7-р тогтоолоор хассан) | 89% / 89% |
| 329 | | 3. Малчдын бүлгийн ахлагч, гишүүдийг олон нийтийн байцаагчаар томилж, урамшуулал олгох | 2021 - 2024 | 0 | | - | Аймгийн хэмжээнд нийт 16 малчдын бүлэг, холбоо байдаг бөгөөд тэдний үйл ажиллагааг дэмжиж Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээ мэдээлэл солилцох тэдний хараа хяналтыг сайжруулах хариуцлагатай байх зорилгоор цагдаагийн газраас уулзалт, яриа хийж хамтран ажиллаж байна. | 90% / 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 330 | 4.3.4. Орон нутгийн гамшгаас хамгаалах техник тоног төхөөрөмжийг шинэчилж, гамшгийг даван туулах, дасан зохицох чадавхыг бэхжүүлнэ. | 1. Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулан машин, техник тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх хүрээнд шуурхай албаны автомашиныг шийдвэрлэх | 2022 - 2024 | 45 | | | 2021 онд Япон Улсын Токүшима мужийн Анан хот болон Ава хотын захиргаанаас Монгол Улсын Онцгой байдлын байгууллагад буцалтгүй тусламжаар гал түймэр унтраах, зориулалтын Toyota Land Cruiser маркын 1 ширхэг автомашин, Монгол улсын засгын газрын 2023 оны 08 дугаар сарын 16 -ны өдрийн 293 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар шуурхай албаны Land Cruiser-76 автомашин, Монгол Улсын Шадар Сайдын шийдвэр 2023 оны 12сарын 06 өдрийн 436 дугаар тогтоолоор Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газар-т “Япон улсад үйлдвэрлэсэн Land-78” маркийн шуурхай албаны автомашиныг тус тус шийдвэрлүүлсэн. | 100% / 90%<br><br>2023-2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. |
| 331 | | 2. Улсын нөөцийн 016 дугаар цэгийг цахилгаанд холбох | 2021 - 2024 | 0 | | | “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн өлд 2021-2023 онуудад хамтран ажиллах хүсэлтээ хүргүүлэн ажилласны үр дүнд 144 дүгээр салбарын агуулахын дээврийн засварын ажлын санхүүжилтэд 37.000.000 /Гучин долоон сая/ төгрөг, 144 дүгээр салбарын 016 дугаар цэгийн гэрэлтүүлгийн ажлын санхүүжилтэд 70.000.000 /Далан сая/ төгрөгийг тус тус шийдвэрлэсэн. Батлагдсан төсвийн хүрээнд засвар, шинэчлэлтийн ажлуудыг чанартай гүйцэтгэж, тайланг 2023 оны 09 сарын 20-ны өдөр “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төсөлд болон Улсын нөөцийн газарт хүргүүлэн, ажилласан. | 100% / 100%<br><br>2022-2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 332 | | | 3. Гал унтраах зориулалттай автомеханик шаттай 3,8 м өндөр, 11 м урттай автомашиныг байрлуулах гражийн өргөтгөлд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх | 2021 - 2024 | 70 | 314 сая төгрөг | | Тус газар нь Гал унтраах тусгай зориулалтын авто машины бэлэн байдлыг хангахад зориулалтын авто машины гарааш шаардлагатай байгааг аймгийн Засаг даргад танилцуулж, аймгийн Иргэдийн Төлөөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 03 дугаар тогтоолоор 314,056,800 /Гурван зуун арван дөрвөн сая, тавин зургаан мянга, найман зуу/-н төгрөгийн төсөв батлуулсан. Тендер сонгон шалгаруулалтаар"Солар Сити Инженеринг" ХХК шалгарсан. Тус компанитай гэрээ байгуулж тусгай зориулалтын автомашины гараашийн барилга, дулааны гадна шугам сүлжээ, цэвэр усны шугамыг шинэчлэн гүйцэтгүүлэв. Аймгийн Засаг даргын 2023 оны А/635 тоот захирамжаар томилогдсон Улсын Комиссын үүрэг даалгаврын биелэлтээр уг гараашийг 2023 оны 11дүгээр сарын 23-ны өдөр байнгын ашиглалтад оруулав. Тус гараашийг бариулсанаар Онцгой байдлын газрын бэлэн байдлын томилгоот автомашинууд дулаан гараашаар бүрэн хангагдсан. | 100% / 100% |
| 333 | | | 4. Онцгой байдлын газрын гадна талбай, автомашины гражид асфальтан зам, талбай хийж гал унтраах тусгай зориулалтын автомашинуудын даацын стандартыг | 2023 | 60 | | | Гал түймэр унтраах, аврах ангийн машин техникийн хүчин чадлыг нэмэгдүүлж, Онцгой байдлын ерөнхий газраас сүүлийн 5 жилд парк шинэчлэлийг ОХУ, Япон , Хятад, Белирусь, Польш, Солонгос зэрэг орнуудын өндөр хүчин чадалтай тусгай зориулалтын машин техникээр хангасан хэдий ч эдгээр автомашины даацад нийцсэн зам талбайг тохижуулах асуудал тулгараад байна. Иймд Онцгой байдлын газрын гадна талбай, автомашины гражид асфальтан зам, талбай хийж гал унтраах тусгай зориулалтын автомашинуудын даацын | 0% / 0% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хангах | | | | | стандартыг хангах ажлын нөхцөл байдлын дүн шинжилгээг Талын зам ТӨХК-аар хийлгэж. асфальт бетон хучилт хийх барилгын ажлын төсөвт 196.408.992 төгрөгийн зардал гарсаныг 2025 оны төсвийн төсөлд тусгуулах саналыг хүргүүлээд байна. | |
| 334 | | 5. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Сүхбаатар аймагт гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх зардлыг шийдвэрлэх | 2021 - 2024 | 1 | 50,8 | 5 | Сүхбаатар аймгийн ИТХ-аар Баруун-Урт суманд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнд 50.8 сая төгрөг төсөвлөн “Гамшгаас хамгаалах судалгаа шинжилгээний төв” ХХК-аар гүйцэтгүүлж, дүгнэлтийн Онцгой байдлын ерөнхий газар хянан баталгаажуулж 2023 онд хүлээн авсан. | 100% / 100% |
| 335 | | 6. “Аймгийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, | 2021 - 2024 | 400 | | 1200 | 2022 оны аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгийн төсвийн 36.6 сая төгрөгөөр иргэдэд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх боловсрол олгох, өөрийгөө болон бусдын амь насыг авран хамгаалах мэдлэг, | 100% / 90%<br><br>Гамшгаас хамгаалах ангиллын |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | аргазүйн танхим” байгуулах | | | | | дадлагыг олон нийтэд олгох сургалт арга зүйн танхимыг Онцгой байдлын газрыг түшиглэн тохижуулж байгуулсан. Тус сургалтын танхимд ухаалаг дэлгэц, сандал, ширээ шинээр авч байрлуулан ард иргэдэд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулан ажиллаж байна. | сургалтад хамрагдах иргэдийн тоогоор тайлагнах. Үнэлгээг бууруулав. |
| 336 | 4.4.1. Тэргүүлэх салбарт гадаадын хөрөнгө оруулалт татах, төсөл хөтөлбөр, буцалтгүй тусламжийн тоог нэмэгдүүлнэ. | 1. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй хамтран ажиллах боломжтой олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн нарийвчилсан судалгааг гаргаж хамтын ажиллагааны уулзалтуудыг зохион байгуулах | 2021 - 2024 | 15 | | 32 | Тайлант онуудад Монгол дахь АНУ-ын ЭСЯ, Чех Улсын Элчин сайдын яам, Япон Улсын элчин сайдын яам, Унгар Улсын ЭСЯ, БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа ЕК, Туркийн хамтын ажиллагааны нийгэмлэг, Өвсний үндэс хөтөлбөр, Дезерет, Южин Оптикал, Раффл интернэйшнл, Мандах наран, Монголиа Азрич, НҮБ зэрэг Олон Улсын байгууллагууд болон ЭСЯ-тай нийт байгууллагатай хамтын ажиллагааны 20 гаруй уулзалтуудыг тус тус зохион байгуулав. Үүний үр дүнд: Эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуй, байгаль орчны салбарын чиглэлээр орон нутагт нийт 7 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтыг татан авлаа. | 100% / 70%<br><br>2024 оны хэрэгжилт тодорхойгүй, 2023 оны тайлагналтай ижил. Журмын 6.2.2.2-р үнэлэв. |
| 337 | | 2. Олон улсын төсөл хөтөлбөрөөс санхүүжилт татах чадавхыг бэхжүүлэх нэгдсэн сургалт зохион байгуулах | 2021 - 2024 | 10 | | 180 | "Олон улсын байгууллагаас буцалтгүй тусламж, төслийн санхүүжилт татах, чадавхийг бэхжүүлэх, төсвөөс гадуурх хөрөнгө оруулалтыг бий болгох зорилгоор “Олон улсын төслийн санал боловсруулах чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтыг 2021 онд зохион байгуулсан. Орон нутгийн хүрээнд хамрагдах боломжтой олон улсын төсөл хөтөлбөрийн танилцуулга, “Асуудлаа хэрхэн тодорхойлох вэ?”, “Жендерийн тухай ойлголт, жендерийн анализ | 90% / 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрхэн хийх вэ ?", "Тогтвортой байдал, түүнийг хэрхэн хангах вэ?", "Эрсдэлийн үнэлгээ хэрхэн хийх вэ?", "Үр дүнгээ хэрхэн хэмжих вэ?" "Туршлага, арга барилаа хуваалцъя" зэрэг сэдвүүдийн хүрээнд сургалтыг үйл явц өрнөж сумд, агентлаг, төсөвт байгууллагын 42 албан хаагч хамрагдав. 2021 оны Канад сангийн төслийн сонгон шалгаруулалтад төслийг боловсруулахад анхаарах асуудлын хүрээнд Zoom сургалтыг 5 сарын 14-ны өдөр зохион байгуулж агентлаг төсөвт байгууллагын 38 албан хаагч хамрагдав. Хууль зүй дотоод хэргийн яам болон Азийн хөгжлийн банктай хамтран цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийн цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2019-2023 онд хэрэгжүүлж буй "G9198/G9221-МОН" төслийн хүрээнд "Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг дэмжих хөтөлбөр"-ийн эхний шатанд Сүхбаатар аймгийн 27 эмэгтэй хувь хүний хөгжил, санхүү, хууль эрх зүйн мэдлэг олгох, бизнесийн төлөвлөгөө боловсруулах, төсөл бичих, чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдаж, олж авсан мэдлэг, туршлагадаа үндэслэн өрхийн эдийн засгийг дэмжих бичил бизнес эрхлэх төслийг боловсруулсан. Хөтөлбөрийн 2 дахь шатанд сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдээс 26 эмэгтэй өөрсдийн санаачилсан бичил төслийн саналыг боловсруулан ирүүлж, 26 нь төслөө өөрийн биеэр сонгон шалгаруулах ажлын хэсэгт амжилттай танилцуулсан. Сонгон шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авч шалгарсан 10 эмэгтэйд бичил төсөл хэрэгжүүлэх батламжийг гардуулсан. " | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 338 | | 3. KOICA олон улсын байгууллагатай хамтран Солонгос улсаас сайн дурын ажилтан ажиллуулах үйл ажиллагааг зохион байгуулах | 2021 - 2024 | 0 | | 3 | 2021 онд KOICA олон улсын байгууллагын сайн дурын ажилтан ажиллуулах хөтөлбөрийг танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулж сайн дурын мэргэжилтэн ажиллуулах салбарын жагсаалт, хүсэлт гаргах маягтыг хэрхэн бөглөх, хүсэлт гаргах байгууллагаас хариуцах асуудлын дагуу холбогдох төсөвт байгууллага, агентлаг албадад зөвлөмж чиглэл өгч ажилласанаас Баруун-Урт сумын ЗДТГ, 1-р цэцэрлэг, 8-дугаар цэцэрлэг, Нийтийн номын сан, Мэнэнгийн тал, сав газрын захиргаа гэсэн 5 байгууллагын материалыг холбогдох журмын дагуу Сангийн яам, КОЙКА Олон улсын байгууллагад хүргүүлсэн боловч Ковид-19 цар тахлаас шалтгаан сүүлийн 2 жил сайн дурын ажилтан илгээх боломжгүйн улмаас хэрэгжээгүй. | 50% / 50% |
| 339 | | 4. Тэргүүлэх салбаруудад чиглэсэн төслийн санал боловсруулах | 2023 - 2024 | - | - | 4 | Тайлант онуудад Туркийн хамтын ажиллагааны нийгэмлэг, Өвсний үндэс хөтөлбөр, Раффл интернэйшнл, Мандах наран, Монголиа Азрич, Дезерет, Ротари, НҮБ зэрэг Олон Улсын байгууллагад тэргүүлэх чиглэл буюу эрүүл мэнд, хөдөө аж ахуй, боловсролын салбарт төслийн саналуудыг боловсруулсны үр дүнд Ротари Гепатитгүй Монгол, Өвсний Үндэс Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн засварын төсөл, Өвсний үндэс 4 дүгээр цэцэрлэгийн өргөтгөл, НҮБ хүүхдийг ивээх сан 11 дүгээр цэцэрлэгийн дээврийн засварын ажил, Дезерет ОУ-н энэрлийн байгууллага аймгийн төв болон сумдын сургууль цэцэрлэгийг орчин үеийн гал тогооны тоног төхөөрөмжөөр хангах төсөл, АНЭ-ийн мэс заслын тасгийн хагалгааны өрөөний иж бүрэн тохижилт, ТИКА хүн чулуун соёлын өвийг хамгаалах, аймгийн нэгдсэн эмнэлэгт нэн | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх, бэлчээрийн усан хангамжийг сайжруулж цэвэршүүлэх төхөөрөмж нийлүүлэх төслүүд, раффлс интернэйшнл ОУБ 1200 иргэдийн эрүүл мэндийн үзлэг оношилгооны төсөл гэх мэт нийт 20 гаруй төслийн саналыг боловсруулан дэмжигдээд амжилттай хэрэгжээд байна. | |
| 340 | | 5. БНТУ-ын Самсун мужтай харилцааг сэргээж, албан ёсны хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах | 2022 - 2024 | 0 | | 1 | Хэрэгжээгүй | 0% / 0% |
| 341 | 4.4.2. БНХАУ-ын аймаг, хотуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллана. | 1. БНХАУ-ын Шилийн гол аймаг, Хөлөнбуйр аймаг, Тунляо, Улаанхад хотуудтай хамтарсан зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах | 2021 - 2024 | 7 | | 13 | Зүүн 6 аймгийн Зөвлөлдөх уулзалтыг гишүүн 6 аймаг ээлжлэн зохион байгуулдаг уламжлалтай бөгөөд тус уулзалтыг 2019 онд Сүхбаатар аймагт зохион байгуулсан бөгөөд ээлжилт зөвлөлдөх уулзалтыг Хэнтий аймаг энэ онд зохион байгуулахаар төлөвлөсөн. Сүхбаатар аймаг тус уулзалтанд оролцох бэлтгэл ажлыг хангаж байна. Түүнчлэн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хот, Сүхбаатар аймаг хоорондын хамтын ажиллагааны цахим уулзалтыг 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан. Тус уулзалтын үеэр 2 талын удирдлагууд цаашид нийгэм, эдийн засаг, бизнес, худалдааны салбарт хамтын ажиллагааг эрчимжүүлэх, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шийдвэрийг гаргасан. 2023, 2024 онуудад БНХАУ-ын Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошууны Ардын Засгийн газрын | 90% / 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | удирдлагууд 2 удаа Сүхбаатар аймагт албан ёсоор айлчлан хамтын ажиллагааны уулзалт зохион байгуулав. | |
| 342 | | 2. БНХАУ-ын Ляонин мужтай хамтын ажиллагааг сэргээж санамж бичгийг шинэчлэн байгуулах | 2022 - 2024 | 1 | | 1 | БНХАУ-ын Ляонин мужийн Жинжоу хотын удирдлагууд, Жинжоу хот дахь “Зүүн хойд хуурай газар-Далайн шинэ суваг байгуулах төсөл”-ийн удирдагч нартай 2022 онд хамтын ажиллагааны уулзалт, 2023 оны 6 сард Сүхбаатар аймаг болон БНХАУ-ын Ляонин мужийн Жинжоу хот дахь ардын засгийн газар хоорондын хамтын ажиллагааны уулзалт, Сүхбаатар аймгийн Засаг дарга 2023 оны 10 дугаар сард БНСУ-д албан томилолтоор ажиллах үеэрээ БНХАУ-ын Ляонин мужийн захирагчийн орлогч Жин Гуо Вэйтэй албан уулзалт, 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Ляонин мужийн дэд захирагчаар ахлуулсан айлчлалын бүрэлдэхүүн Сүхбатар аймагт айлчилж, амйгийн удирдлагуудтай хамтын ажиллагааны уулзалтыг тайлант хугацаанд тус тус 4 удаа зохион байгуулав. Үүний үр дүнд Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум болон БНХАУ-ын Ляонин мужийн Чаёон хот хооронд олон улсын ах дүү хотын нөхөрсөг харилцааны санамж бичгийг байгуулахаар тохиролцов. Хоёр талын холбогдох мэргэжилтнүүд холбогдож хоёр талаас санамж бичгийн төслийг боловсруулах шатанд явж байна. | 100% / 90%<br><br>Арга хэмжээний хэрэгжилт хүрэх түвшиндээ хүрээгүй. |
| 343 | | 3. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн ажил мэргэжлийн дээд сургуульд | 2024 | - | - | 5 | БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошууны төлөөлөлтэй 2023, 2024 онуудад тус тус албан уулзалт зохион байгуулах үед Сүхбаатар аймгийн удирдлагуудын зүгээс оюутан залуусыг БНХАУ-ынн ӨМӨЗО-д сургах талаар санал тавьсан | 30% / 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | жилд 10 хүртэлх оюутныг хагас болон бүрэн тэтгэлэгтэй суралцуулах ажлыг зохион байгуулах | | | | | бөгөөд Зүүн үзэмчин хошууны төлөөлөл удирдлагууддаа танилцуулан, цаашид хэрэгжүүлэх боломжтой талаар судлахаар болов. | |
| 344 | | 4. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр, Шилийн гол, Тунляо хотуудад уламжлалт анагаах ухааны чиглэлээр жилд 10 хүртэлх эмч, сувилагчдыг богино болон дунд хугацааны сургалтад хамруулах | 2024 | - | - | 5 | БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошууны төлөөлөлтэй 2023, 2024 онуудад тус тус албан уулзалт зохион байгуулах үед Сүхбаатар аймгийн удирдлагуудын зүгээс оюутан залуусыг БНХАУ-ынн ӨМӨЗО-д сургах талаар санал тавьсан бөгөөд Зүүн үзэмчин хошууны төлөөлөл удирдлагууддаа танилцуулан, цаашид хэрэгжүүлэх боломжтой талаар судлахаар болов. | 30% / 30% |
| 345 | | 5. Аймгийн Уламжлалтын эмнэлгийг БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн Монгол эмнэлгийн хороотой онлайн хамтын ажиллагаатай болгох | 2024 | - | - | 5 | 2024 оны 11 дүгээр сард аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Монгол эмнэлгийн хороотой хамтын ажиллагааг сэргээх, хамтын ажиллагааны уулзалтыг зохион байгуулах хүсэлтээ илэрхийлсэн аймгийн Уламжлалтын эмнэлгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 36 тоот албан бичгийг Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошууны гадаад явдалын албан гэрт хүргүүлэв. Одоогоор нөгөө талаас судалж байна гэсэн хариуг ирүүлээд байна. | 50% / 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 346 | | 6. БНХАУ-ын ӨМӨЗО-ны хил орчмын аймаг, хошуутай хамтран бизнес эрхлэгчдийн уулзалт, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах | 2022 - 2024 | 0 | | 30 | БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошууны төлөөлөлтэй 2023, 2024 онуудад тус тус албан уулзалт зохион байгуулах үед Сүхбаатар аймгийн удирдлагуудын зүгээс оюутан залуусыг БНХАУ-ынн ӨМӨЗО-д сургах талаар санал тавьсан бөгөөд Зүүн үзэмчин хошууны төлөөлөл удирдлагууддаа танилцуулан, цаашид хэрэгжүүлэх боломжтой талаар судлахаар болов. | 30% / 30% |
| 347 | 4.4.3. ОХУ-ын хил орчмын муж хотуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 1. Өвөр Байгалийн хязгаартай хамтын ажиллагааг сэргээж, санамж бичиг байгуулах | 2022 - 2024 | 2 | | 5 | 2022.11.09-нд МОНГОЛ-ОХУ-БНХАУ хоорондын бүс нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжих, сурталчлах цахим хурал болж хуралд Монгол улсын Дорнод аймаг, Сүхбаатар аймаг, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс, ОХУ-ын Өвөр байгалийн хязгаар, БНХАУ-ын Хөлөнбуйр хотын төлөөлөгч нар оролцсон. Хурлаар хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, хамтран ажиллах талаар санал солилцож 3 улсын 41 төсөл танилцуулагдсан.Сүхбаатар аймгийн зүгээс “Дулааны аргаар мах боловсруулах”, “Сүүний чиглэлийн үхрийн ферм”, “Борц үйлдвэрлэх”, “Арьс, нэхий боловсруулах бүтээгдэхүүний бага оврын үйлдвэр” гэсэн 4 төсөл танилцуулагдаж хамтран ажиллах санал тавьсан. Мөн 2024 оны 11 дүгээр сард Монгол улс дахь ОХУ-ын Элчин сайдын яамны зөвлөхөөр ахлуулсан нийт 18 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг айлчилж аймгийн удирдлагуудтай хамтын ажиллагааны уулзалт зохион байгуулж, цаашид хэрхэн хамтран ажиллах тухай санал солилцов. Тус айлчлалын үеэр Монгол-Оросын найрамдал, хамтын ажиллагааны 64 жил, Орос хэл Зүүн бүс | 50% / 50% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нутгийн баярын арга хэмжээг зохион байгуулав. | |
| 348 | 4.4.4. Нэгдсэн Үндэсний Байгууллагын "Тогтвортой хөгжлийн зорилт - 2030" хөтөлбөрийн хүрээнд "Орон нутагт тогтвортой хөгжлийн зорилтыг нутагшуулах нь" төслийг хэрэгжүүлнэ. | 1. Монгол дахь Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр түүний салбар төслүүдтэй орон нутгийн түвшинд хамтран ажиллах уулзалтыг зохион байгуулах | 2021 - 2024 | 0 | 3200 | 3 | Сүхбаатар аймаг нь 2021-2023 оны хооронд НҮБ-ын хүүхдийн сан, НҮБ-ын ХХААБ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтын ажиллагааны уулзалтуудыг тогтмол зохион байгуулж байна. Тухайлбал 2023 оны 5 дугаар сард НҮБ-ын Хүүхдийг ивээх сантай хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулан 2023 онд 600 сая төгрөгний төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Мөн НҮБ-ын ХХААБ-тай хамтран Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, НҮБ-ын ХБ-тэй хамтран Адапт төсөл, Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төсөл зэрэг төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж 3,4 тэрбумын хөрөнгө оруулалтыг татаад байна. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 2025 онд ажиллах 880 мянган ам долларын хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурав. | 100% / 100% |
| 349 | | 2. "Тогтвортой хөгжлийн зорилт ба уялдаа холбоо", сэдэвт чадавхыг бэхжүүлэх цуврал сургалтыг сум, агентлагийн хүрээнд зохион байгуулах | 2023 - 2024 | - | - | 20 | 2023 онд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан "Төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих" нь төслийн хүрээнд "Үр дүнд суурилсан төлөвлөлт болон төсөвлөлтийн арга зүй сэдэвт сургалт Хэнтий аймагт зохион байгуулагдсан бөгөөд Сүхбаатар аймгаас хэлтсийн дарга нар болон холбогдох бодлогын мэргэжилтэнгүүд нийлсэн 10 алба хаагч тус сургалтад хамрагдав. | 100% / 70%<br><br>2024 оны хэрэгжилт тодорхойгүй. Шалгуур үзүүлэлт зорилтод түвшиндээ хүрээгүй. Журмын 6.2.2.2 |
| 35 | | 3. “Тогтвортой | 2022 | 0 | | 1 | (АИТХ-ын 2023 оны 7-р тогтоолоор хассан) 89 | 89% / 89% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 0 | | хөгжлийн зорилт”-ыг нутагшуулах төслийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулах (АИТХ-ын 2023 оны 7-р тогтоолоор хассан) | | | | | | |
| 351 | 4.4.5. "Их түмэн санаачилга" бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд зүүн бүсийн хэмжээнд хамтран оролцоно. | 1. БНСУ, Япон Улсын муж, хотуудтай хамтын ажиллагаа тогтоох | 2022 - 2024 | 0 | | 3 | "Тайлант хугацаанд БНСУ-ын Гванжу хоттой шинээр харилцаа тогтоох хүсэлт илгээж 3 удаагийн хамтын ажиллагааны уулзалтыг зохион байгуулав. Үүний үр дүнд талууд нийгмийн салбарт тухайлбал боловсролын салбарт хамтран ажиллахаар тохиролцов. Мөн БНСУ-ын хөдөлмөр халамжийн яамны харьяа БНСУ-ын бие даах чадвар, халамж хөгжлийн хүрээлэнтэй 2024 kоны 4 дүгээр сард хамтран ажиллах 2 жилийн хугацаатай санамж бичиг байгуулав. " | 100% / 100% |
| 352 | | 2. "Их түмэн санаачилга" бүс нутгийн хамтын ажиллагааны хорооны уулзалтад идэвхтэй оролцож, тэргүүлэх салбарт | 2022 - 2024 | 0 | | 3 | Тайлант онуудад "Их Түмэн Санаачлага" Зүүн Хойд Азийн орнуудын орон нутгийн хамтын ажиллагааны хорооны 10 дугаар хурал цахимаар, 11 болон 12 дугаар хурал танхимаар тус тус 3 удаа зохион байгуулагдсан бөгөөд Сүхбаатар аймгийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид хурал тус бүрт аймгийг төлөөлөн мэндчилгээ дэвшүүлж, илтгэл танилцуулгыг хэлэлцүүлэн идэвхтэй оролцсон. Мөн ОНХАХ-ны цаашдын хамтын ажиллагаа, хэтийн төлөв, | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамтарсан төслийн санал боловсруулах | | | | | тэргүүлэх чиглэлийн төсөл хөтөлбөрийн саналын талаар ОНХАХ-ны гишүүн орон нутгуудтай санал солилцов. 2022.11.09-нд МОНГОЛ-ОХУ-БНХАУ хоорондын бүс нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжих, сурталчлах цахим хурал болж хуралд Монгол улсын Дорнод аймаг, Сүхбаатар аймаг, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс, ОХУ-ын Өвөр байгалийн хязгаар, БНХАУ-ын Хөлөнбуйр хотын төлөөлөгч нар оролцсон. Хурлаар хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, хамтран ажиллах талаар санал солилцож 3 улсын 41 төсөл танилцуулагдсан.Сүхбаатар аймгийн зүгээс “Дулааны аргаар мах боловсруулах”, “Сүүний чиглэлийн үхрийн ферм”, “Борц үйлдвэрлэх”, “Арьс, нэхий боловсруулах бүтээгдэхүүний бага оврын үйлдвэр” гэсэн 4 төсөл танилцуулагдаж хамтран ажиллах санал тавьсан. | |
| 353 | | 3. БНХАУ-ын Ляонин мужийн Жинжөү боомтыг түшиглэн Бичигт боомт болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн хатавч боомтоор дамжуулан далайд гарах гарцыг нээх боломж, нөхцөлийг | 2022 - 2024 | 0 | - | 100 | БНХАУ-ын Ляонин мужийн Жинжоу хот дахь “Зүүн хойд хуурай газар-Далайн шинэ суваг байгуулах төсөл”-ийн удирдагч нарын хооронд зөвлөлдөх хурлыг 2022.10.20-ны өдөр зохион байгуулсан. Тус уулзалтын үеэр БНХАУ-ын Ляонин мужийг түшиглэн Бичигт боомт болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн хатавч боомтоор дамжуулан далайд гарах гарцын боломжийн талаар 2 тал хэлэлцсэн. 2022 оны 2-р сард өвлийн олимпын үеэр БНХАУ-ын төрийн зөвлөлийн ерөнхий сайд Ли Көчян болон Монгол улсын ерөнхий сайд Оюун-Эрдэнэ нар уулзаж зүүн хатавч боомт болон бичигтийн боомтыг төмөр замаар холбох тохиролцоонд хүрсний дагуу Жинжоу боомтоос эхлээд БНХАУ-ын Ляонин муж, ӨМӨЗО, Хятад-Монголын хилийн Зүүн хатавч боомт, Бичигт | 90% / 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | судлах | | | | | боомт, Баруун-Урт хот, Монголын зүүн хэсгийн Чойбалсан хот гэсэн чиглэлийн төмөр зам цаашлаад Оросын Сибирийн төмөр замтай холбогдож Европт хүрэх зорилгын талаар санал бодол солилцсон. БНХАУ-ын Зүүн хойд далайд шинэ суваг барих ажлын хүрээнд Монгол улсаас хүрэн нүүрс, малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд, цайр гэх мэт бүтээгдэхүүн, БНХАУ-аас импортолж болох бараа бүтээгдэхүүнийг төмөр зам болон авто замаар хэрхэн тээвэрлэх талаар ярилцаж тус ажлыг яаралтай шийдвэрлэж өгөхийг 2 улсын засгийн газартаа уламжлахаар болсон. 2023 онд БНХАУ-ын Ляонин мужийн Жинжоу хотын Ардын засгийн газрын гадаад харилцааны албаны дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг Сүхбаатар аймагт ажиллах үеэр Монгол Улсын далайд гарах гарц, төмөр замын ажлын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар санал солилцов. | |
| 354 | 4.5.1. Хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч хүмүүжлийг төлөвшүүлнэ. | 1. Аймгийн хэмжээний ЕБ-ын 10 сургуульд цэрэг дайчдын "Алдарын танхим" байгуулах | 2021 - 2024 | 0 | | 3 | 2021-2024 онд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас 5 сая, сумын ЗДҮАХ-аас 2 сая төгрөгийг зарцуулж аймгийн хэмжээний ЕБС-ын 7 сургуульд цэрэг дайчдын алдрын танхим байгуулаад байна. | 70% / 70% |
| 355 | 4.5.2. Дайчилгааны төлөвлөгөөг шинэчилж, томилгоот бүрэлдэхүүнийг | 1. Дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэх сургалтыг зохион байгуулах | 2021 - 2024 | 0 | | 1 | Зэвсэгт хүчний анги салбарыг хүн техникээр нөхөн хангах төлөвлөгөөг 2021 оны 5 дугаар сард шинэчилэн боловсруулж, сумдын дайчилгааны төлөвлөгөө болон орон нутгийн цэргийн төлөвлөгөөг боловсруулах сургалтыг 13 сумын Тамгийн дарга нарт явуулж Сумдын дайчилгааны төлөвлөгөөг 2023 оны 08 дугаар | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | чадавхжуулна. | | | | | | сард аймгийн Засаг даргаар батлуулсан. Улсын дайчилгааны төлөвлөгөө 2024 онд шинэчилэгдэн батлагдсан. | |
| 356 | | 2. Цэргийн штаб, анги салбарын сургалтын нэгдсэн төвийг байгуулах | 2021 - 2024 | 0 | | 100 | Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн сургалтын төвийн /полигон/ тусгай хэрэгцээний эзэмшлийн газрыг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэн сургалтын төвийн гүйцэтгэлийн ажилд зарцуулах 80.000.000 төгрөгийг аймгийг ИТХ-аар батлуулан аймгийн төсөвт дагуу санхүүжилтийг олгож гүйцэтгэл 2023 онд 75 хувийн гүйцэтгэлтэй байсан бөгөөд нэмэлтээр шаардагдах 20 сая төгрөгийг 2024 оны төсөвт суулган шийдүүлж сургалтын төв ашиглалтад ороод байна. | 100% / 100% |
| 357 | 4.5.3. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу нөөц бүрдүүлнэ. | 1. Орон нутгийн томилгоот нэгж, түүний удирдлага, бие бүрэлдэхүүний сургалтыг үе шаттай зохион байгуулах. | 2021 - 2024 | - | - | 300 | Батлан хамгаалах зарим чиг үүргийг орон нутагт 2023 онд хэрэгжүүлэх гэрээний 4.1, 4.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтын 4.5.3.1, Монгол Улсын Батлан Хамгаалахын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн А/111 тоот тушаал, 2020 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/133 тоот тушаал,Зэвсэгт Хүчний Жанжин Штабын даргын А/186 тоот тушаал, 02/540 албан бичиг, Цэргийн штабын 2023 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөг тус тус мөрдлөг болгон Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдлага, томилгоот нэгжийн бүрэлдэхүүн онц болон дайны байдлын үед орон нутгийн хамгаалалтын үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, гүйцэтгэх үүрэгт нь чиглэсэн онолын мэдлэг, дадлага, ур чадвар олгох, томилгоот нэгжийн гар нийлэмжтэй ажиллагаа, жигдрэлтийг хангах, | 100% / 90%<br><br>Шалгуур үзүүлэлт хүрэх түвшиндээ хүрсэн эсэх нь тодорхойгүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үүрэг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “Орон нутгийн хамгаалалтанд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагаа” сэдвээр орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн “Хээрийн дадлага” сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 21-28-ны өдрүүдэд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд Хилийн цэргийн 0146 дугаар ангийн сургалтын төвийг түшиглэн зохион явуулсан. Тус сургалтыг 2021-2024 онд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас 43 сая төгрөгөөр зохион байгуулсан. | |
| 358 | | 2. Орон нутгийн хамгаалалтын техник хэрэгсэл, бараа материалын нөөцийг бүрдүүлэх | 2021 - 2024 | | 22,7 | - | Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу орон нутгийн хамгаалалтын нөөц бүрдүүлхэд зориулж 22.369.500 төгрөгийн бараа материалыг татан авч нөөц бүрдүүлсэн. | 100% / 70%<br><br>2022-2024 оны хүрэх түвшинг тодорхойлоогүй. 2024 оны хэрэгжилт тодорхойгүй. |
| 5. ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ | | | | | | | | |
| 359 | 5.1.1. Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийн талаарх боловсролыг дээшлүүлнэ. | 1. Иргэдэд байгаль хамгаалах, ногоон хөгжлийн боловсрол олгох сургалт, арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | 9433 | | 2400 | Аймгийн хэмжээнд 28 арга хэмжээг зохион байгуулж 275 ААНБ, 23468 иргэн хамрагдсан байна. Дээрх арга хэмжээг зохион байгуулахад нийт 3.3 сая төгрөг зарцуулаад байна. Нээлттэй хаалганы өдөрлөгөөр Тарьц, суулгац-2023 үзэсгэлэн худалдаа-3, хэлэлцүүлэг-4, сургалт-31, эко аялал-1, эвент арга хэмжээ чуулга уулзалт-5, нэг уут хог-1000 төг арга хэмжээ-2, ТВ нэвтрүүлэг, шторк-12, гарын авлага зөвлөмж-7694 иргэнд өгч ажилласан. Дээрх арга хэмжээг БНМТСГ-ын захиргаа, Сүхбаатар | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ТҮОНӨААТҮГ, Сүхбаатар ойжуулалт сум дундын ойн анги, Шаргын модот ХХК, Ойжуулалт хайлааст ХХК, Мяндарт, Талын жимс зэрэг холбогдох газруудтай хамтран зохион байгууллаа. Мөн, нийтийн эзэмшлийн зам талбай болон аялал жуулчлалын бүс нутагт 20 ш мэдээллийн самбарыг шинээр хийж байршуулсан | |
| 360 | | 2. ЕБС-ийн Эко клубүүдийг чадавхжуулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэх | 2022 - 2024 | 1 | | 1 | 2024 онд Биологийн олон янз байдлыг хамгаалах өдрөөр аймгийн ЗДТГ, БОАЖГ, ИТХ, Хуурай хээрийн төсөлтэй хамтран "ХАЙРЛАЯ ХАМГААЛЪЯ ХАМТАРЪЯ" ток шоуг зохион байгуулж нийт 5 сумын 8 эко кулбийн төлөөлөл болон ЕБС -ын 500 орчим сурагчдад цагаан зээрийн ач холбогдол, хамгааллын сургалт хийсэн. Уг арга хэмжээнд мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдын төлөөлөл, малчин, сэтгүүлч, эко клубийн сурагчдийг урьж Цагаан зээрийг хамгаалахад тулгарч буй асуудлын талаар мэдээлэл солилцлоо. 2023 онд Наран, Дарьганга, Онгон сумдын Эко клубуудад "Шувуу ажиглах аялал" төслийг хэрэгжүүлэхэд 1 сая төг, "Янзаган хүрээг хайрлаарай-2023" зүүн бүсийн Эко клубууудийн чуулга уулзалт төслийг хэрэгжүүлэхэд 9 сая төг нийт 10 сая төг зарцуулсан. Төслийн хүрээнд: 1. "Шувуу ажиглах төсөл"-өөр Дарьганга, Онгон, Наран сумдын Эко клубын сурагчдын дунд "Шувуу ажиглах" аялалыг зохион байгуулсан ба 43 хүүхэд Дарьгангачуудын өв соёл, зан заншил, нүүдэлчин амьдралын хэв маягтай танилцаж, Дарьганга брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн, ардын авьяастнуудын тоглолт, Шувуу ажиглах аялал зэрэгт оролцож туршлагаа солилцлоо. 2. Янзаган хүрээг | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хайрлаарай-2023" зүүн бүсийн Эко клубийн чуулга уулзалтыг Дэлхийн байгаль хамгаалах сан, 3 аймгийн ИТХ, БСУГ, БОАЖГ-уудтай хамтран зохион байгуулж нийт 16 сургуулийн Эко клубийн 200 гаруй сурагчид оролцлоо. Мөн зүүн бүсийн Эко клубийн сурагчдийн дунд Тик ток, бүтээл, шилдэг чиглүүлэгч багшийн уралдаан зарласан ба 200 гаруй бүтээл ирсэн. 2022 онд аймгийн хэмжээний 16 ЕБС-ийн эко клубийн дунд “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД – ЭКО КЛУБИЙН ОРОЛЦОО” сэдэвт нийт 13 сая төгрөгийн санхүүжилттэй төслийн уралдааныг зарлаж уралдаанд нийт 9 төсөл ирүүлснээс: 1-р байр Уулбаян сумын ЕБС-ийн “Орчноо ногооруулъя” төсөл 6000000 төгрөг, 2- р байр Баруун –Урт сумын 4 дүгээр ЕБС-ийн “Холивол хог-Ангилбал баялаг” төсөл 3000000 төгрөг, 3- р байр Баруун –Урт сумын 3 дугаар сургуулийн “Холивол хог-Ангилбал мөнгө” төсөл 2000000 төгрөг, 4- р байр Дарьганга сумын ЕБС-ийн “Өнөөдрийн хог маргаашийн баялаг” төсөл 200 | |
| 361 | | 3. Жил бүр 3-аас доошгүй сумын Улсын тусгай хамгаалалтад авах газруудын судалгааг гаргаж, аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан, Засгийн газарт | 2021 - 2024 | 12.3 | | 0.7 | Баяндэлгэр сумын ИТХ-ы 2023 оны 04 дүгээр сарын 03 өдрийн А/54 дүгээр тогтоолоор Өөшийн говь нэрээр 43416,35 га Дөхөмийн говь нэрээр 37162,74 га аймгийн ИТХ-ын 2023 оны 4 сарын 14 өдрийн 11 дүгээр тогтоолоор Баянцогт нэртэй 2773,18 га 16 дугаар тогтоолоор Уулбаян, Халзан, Түвшинширээ сумын нутаг дах Өөшийн говийг 35051,37 га, 17 дугаар тогтоолоор Эрдэнэцагаан сумын дундын ам, Чулуутын булаг нэрээр 26617 га, 18 дугаар тогтоолоор Эрдэнэцагаан сумын Адуун чулууны булаг 57,14 га, 19 дүгээр тогтоолоор Халзан сумын Сайн шанд нэртэй 5858,12 га, 20 дугаар тогтоолоор Бадрах овоо, Хуран овоо, Адгын | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | уламжлах | | | | | баян хошуу, Ар булгийн цагаа овоо нэрээр 83267,89 га тус тус орон нутгийн тусгай хамгаалалтанд аваад байна. | |
| 362 | | 4. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 2021 - 2023 | 0 | | | Аймгийн Засаг даргын 2022 оны 02 сарын 01 –ний өдрийн А/67 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан Улсын тусгай хамгаалалттай Баянцагааны талын менежментийн төлөвлөгөө, хамгаалалтын горим боловсруулахаар цахимаар 4 удаагийн уулзалт хэлэлцүүлгийг олон талын оролцоог хангаж зохион байгуулж, 2 удаа орон нутагт ирж анхан шатны судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулаад байна. Дээрхи сургалт хэлэлцүүлэгт 60 хүн хамрагдсан байна. Тусгай хамгаалалттай газан нутгийн тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотой ажлын хэсэг дахин менежментийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. 2023 онд Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт биологийн олон янз байдлын хамгаалал төсөлтэй хамтран Хар ямаат, Баянцагаан талын БНГ-ын өнөөгийн болон ирээдүйн үр өгөөжийг үнэлэх үр ашгийн тайланг мэргэжлийн багаар хийлгүүлэн олон талын оролцоог хангаж хэлэлцүүлэг хийсэн. Онгон таван булгын УТХ-тай газарт Зүүн булаг, Зотолхаан уулын УТХ-тай газарт Наран булгын эхийг хашиж хамгаалах ажлыг БХНСАХЗардал болон Адапт төсөлтэй хамтран хийж гүйцэтгээд байна. | 100% / 70%<br><br>Хүрэх түвшин ойлгомжгүй. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар тайлагнаагүй. |
| 363 | 5.1.2. Ойн сан бүхий газрын ойгоор бүрхэгдсэн талбайн | 1. Цөлжилтийн нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар | 2022 - 2024 | 0 | | | Аймгийн хэмжээний Цөлжилтийн нарийвчилсан судалгааг урьдчилсан бэлтгэл ажил хангагдсан ба 50 сая төгрөгөөр судалгаа хийлгэх саналыг тус төлөвлөгөөнд тусгасан боловч дэмжигдээгүй. Судалгааг хийлгэх | 0% / 0% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээ болон төв суурин газрын ногоон байгууламжийн ургалтын хувийг нэмэгдүүлнэ. | хийлгэж, цөлжилтийн атластай болох | | | | | санхүүжилтийн дэмжлэг авахаар "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдлийн менежментийг боловсронгуй болгох нь" төсөлд санал хүргүүлсэн боловч дэмжигдээгүй. | |
| 364 | | 2. Ойгоор бүрхэгдсэн талбай хэмжээг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 2218 | | 10 | "-АДАПТ төсөл 70%, ОНТ 30%-ийн санхүүжилтээр Дарьганга сумын Ганга нуурын татамд 30 га талбайд 24.000 мод тарьж татмын ойжуулалт, 5151 м хашаа хамгаалалт, 10 га талбайд ойн цэвэрлэгээ арчилгааны ажлыг Гранд форест ХХК 315.0 сая төгрөгөөр, - Түмэнцогт сумын Хэрлэн голын татмын дагуу 20 га талбайд 16.000 мод тарьж татмын ойжуулалт, 5679 м хашаа хамгаалалт, 15 га талбайд ойн цэвэрлэгээ арчилгааны ажлыг Алтан солин ХХК 322.0 сая төгрөгөөр, Түмэнцогт суманд Хэрлэн голын татмын дагуу 92 га талбайд 73.600 мод, 1234 м хашаа хамгаалалтын ажлыг Гранд форест ХХК 1.0 тэрбум төгрөгөөр, Наран /Баянгол/, Дарьганга /Өлзийт булаг/ сумдад 13 га талбайд 10400 мод, хашаа хамгаалалтын хамт тарьж ургуулсан. Тус ажлуудыг хүлээн авах комиссыг аймгийн Засаг даргын 2024 оны 06 сарын 11-ны ""Ажлын хэсэг байгуулах тухай"" А/357 дугаар захирамжаар байгуулж, ажлын хэсэг газар дээр нь очиж ажлыг хүлээж авсан. Нийт 2 сумын 4 байршилд 142 га буюу 113.600 мод тарьж, хашаажуулсан ба модны ургалт 75%-тай байна. " | 100% / 70%<br><br>Хэмжих нэгж тодорхойгүй. Суурь түвшин, хүрэх түвшин уялдаагүй. |
| 365 | | 3. Эвдэрч, эзэнгүй орхигдсон газарт нөхөн | 2021 - 2024 | 10 | | 10 | "2023 онд Орон нутгийн төсвийн 60 сая төгрөгөөр эвдэрч эзэнгүй орхигдсон 4 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн боловч Төрийн хэмнэлтийн тухай | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сэргээлт хийх | | | | | хуулиар зураг төсөвгүй ажлуудыг тендер зарлахгүй талаар мэдэгдсэн тул уг ажлыг хэрхэн хийх талаар 145 тоот албан бичгээр зөвлөж чиглэлийг БОАЖЯ-наас хүсээд байна. 2024 онд Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийх ТЭЗҮ- г зардлыг  Ланд овнер ХХК-тай гэрээг байгуулан БХНСАХЗ-аас 20,0 сая төгрөгийн санхүүжилтээр хийлгэсэн. Гэрээний дагуу Халзан сумын Хар худаг, Түвшинширээ сумын Бумбат, Мөнххаан сумын Хөх өндөр зэрэг газруудад нөхөн сэргээлтийн зардлыг тооцуулахад нийт 1.6 тэрбум санхүүжилт шаардлагатай гэсэн ТЭЗҮ, зураг төсөв гарсан. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө дүгнүүлэх хүсэлт болон тайланг 11 ААНБ ирүүлсэн байна.Үүнээс 8 ААН-ийн тайланг хүлээн авч хангалттай дүгнэсэн. 3 ААН-ийн тайланг буцаасан. БОМТ-ний хэрэгжилтийг жил бүр дүгнэснээр байгаль хамгаалах нөхөн сэргээлтийг нэмэгдүүлж эзэнгүй орхигдсон 10 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийлгэсэн. 2021-2024 оны хугацаанд Аж ахуй нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд тусгагдсан эвдэрч эзэнгүй орхигдсон талбайд техникийн  болон биологийн нөхөн сэргээлтийг нийт аймгийн хэмжээнд 20 орчим га талбайд хийлгээд байна. " | |
| 366 | | 4. Аймаг, сум, багийн төвд бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэн байгуулах газрыг газар | 2021 | 0 | | | Аймгийн хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 75.9 га газрыг тусгасан. Үүнээс нийтийн эзэмшлийн газар- 35 га, Мод үржүүлгийн газар 6,4га, ойжуулалт, ойн зурвас байгуулах ажил-35 га-г тус тус тусгасан | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж нөөцөд авах | | | | | байна. | |
| 367 | | 5. Мод үржүүлгийн газарт орон нутгийн онцлогт тохирсон модлог ургамлыг үр, мөчрөөр тарималжуулан нөөцийг бүрдүүлэх | 2022 - 2023 | 0,5 | | 1 | Ойн газраас Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж буй мод үржүүлгийн газруудад нэгдсэн тооллого, бүртгэлийн ажил хийлээ. Тус аймагт “Сүхбаатар ойжуулалт” СДОАнги, “Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт” ОНӨААТҮГазар, “Ойжуулах хайлааст” ХХК, “Мяндарт” ХХК нар мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. ”Сүхбаатар ойжуулалт” СДОАнги нь 2013 оноос мод үржүүлгийн зориулалтаар нийт 4 га талбайг ашиглан үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд үүнээс үйлдвэрлэлийн хэсэг 2 га болон бойжуулгын хэсэг 1,8 га талбайтай. Тухайн сум дундын ойн анги нь 215,0 мян ш 2-3 настай тарьцын нөөцтэй бөгөөд 2023 оны хавар үр болон мөчрийн тайрдсаар 223,6 мян тарьц, суулгацыг ургуулж байна. ”Баруун-Урт” цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГазар нь нийт 1 га талбайг мод үржүүлгийн зориулалтаар ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд улиас, хайлаас, бургасны 33,0 мян ш тарьц ургуулж байна. 2023 оны хаврын тарилтаар нийт 35,0 мян ш мөчрийн тайрдас тарьсан бөгөөд мөн хайлаасны үрийн тарилтыг хийжээ. ”Ойжуулах хайлааст” ХХК нь нийт 2,5 га талбайг мод үржүүлгийн зориулалтаар ашиглаж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн хэсэгт 1 га талбай, суулгац бойжуулах хэсэгт 0,4 га талбайг ашиглаж байна. Мод үржүүлгийн газартаа 15,3 мян ш тарьцын нөөцтэй бөгөөд нэмж үр болон | 100% / 90%<br><br>2024 оны хэрэгжилт тодорхойгүй. Үнэлгээг бууруулав. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мөчрийн тайрдсаар 29,0 мян ш тарьц, суулгац ургуулсан. Түмэнцогт сумын “Мяндарт” ХХК: Шинэс, Нарс, Гацуур, Интоор, Өрөл, Жигд, Алим гэх мэт 55 төрөл зүйлийн мод, бут сөөг болон чимэглэлийн цэцгийг сонирхлынхоо дагуу тарьж ургуужээ. Тэрээр үржүүлгийн талбайдаа 14,2 мян ш тарьц, 500 ш суулгацыг бойжуулж байна.Улсын Мод үржүүлгийн газрын бүртгэл, тооллогонд 4 мод үржүүлгийн 7.8 га талбайд үр, мөчрөөр нийт 565.100 ш, 1 настай тарьц суулгацны нөөцтэй болсон. Эдгээр тарьц, суулгац нь 3 жилийн дараа зах зээлд нийлүүлэгдэнэ. | |
| 368 | | 6. Баруун-Урт хот, Эрдэнэцагаан, Түмэнцогт, Дарьганга сумдын бичил болон цэцэрлэгт хүрээлэнд гоёл чимэглэлийн мод сөөг ургуулах ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | 1800 | | 1 | Баруун-Урт, Дарьганга, Эрдэнэцагаан сумдад бичил болон цэцэрлэгт хүрээлэнд 3 төрлийн чимэглэлийн 5700 ш мод сөөгийг тарьж арчилан ургуулж байна. Үүнд: 1.Баруун-Урт суманд байгуулагдаж байгаа Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнд Их модун компианаас 3 төрлийн 1000 ш чимэглэлийн мод сөөг, Ойжуулалт-Хайлааст ХХК Улсын төсвийн хөрөнгөөр 18000 ш мод тарьж, арчилан ургуулж байна. 2.Дарьганга сум ОНХС-аас 48.0 сая төгрөөр 1 га газарт бичил цэцэрлэг байгуулах хашаа хамгаалалт хийж 2 төрлийн 1100 ш хайлаасыг хашлага хэлбэрээр тарьж, усалгаа арчилгааг хийж байна. 3.Эрдэнэцагаан сум Худалдааны гудамжинд Цуваа бичил цэцэрлэг байгуулж 3000 ш хайлаас амьд хашлага хэлбэрээр тарьсан. 4. Түмэнцогт сум нийтийн эзэмшилийн газарт 600 ш хайлаас, гүйлс тарьсан. | 100% / 100%<br><br>2023-2024 оны хүрэх түвшин ойлгомжгүй. Анхаарах. |
| 369 | | 7. Аймгийн төвийн нийтийн эзэмшлийн | 2021 - 2024 | 29708 | | 6000 | Аймгийн төвийн ногоон байгууламжийн усалгаа, арчилгааны ажилд Баруун-Урт сумын ЗДТГ-аас 19.0 сая төгрөгийн тендер зарлаж, | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, усалж арчлах | | | | | гүйцэтгэгчээр Шаргын модод цэцэрлэг ХХК шалгарч гэрээ байгуулан 12266 ш модны усалгаа арчилгааг хийж гүйцэтгэж байна. --Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ААТОНӨГазар сум дундын ойн ангиас хүлээн авсан тойргийн мод, төвийн ногоон байгууламж, наадмын талбай зэрэг 8000 гаруй модны усалгаа арчилгааг хийж гүйцэтгэж байна. --Баруун-Урт сумаас Улаанбаатар хот гарах зам дагуу 2022 онд 5 га-д Ойн зурвас байгуулсан. 2024онд 5 га Ойн зурвасны арчилгааны зардлыг Ойжуулалт-Хайлааст ХХК нь өөрсдийн хөрөнгөөр усалгаа арчилгааг хийж байна. 2023 оны ажлын хэсгийн намрын тооллогоор 88.5% тай ургасан. ---Баруун-Урт сумаас Дорнод аймаг гарах авто зам дагуу Улсын төсвийн хөрөнгөөр 10 га-д Ойн зурвас байгуулах ажлыг Сүхбаатар-Ойжуулалт СДОАнги гүйцэтгэж 6000 ш улиас модонд нөхөн тарилт хийж усалгаа арчилгааг хийж байна. 2024 оны улсын төсвийн хөрөнгөөр Соёл амралтын хүрээлэнд таригдах 18000ш модны тендер зарлагдаж гүйцэтгэгчээр Ойжуулалт-Хайлааст ХХК шалгарч 18000 ш модыг бүрэн тариад байна. | |
| 370 | | 8. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг үе шаттай хэрэгжүүлнэ | 2021 - 2024 | 0 | | 90 | "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ний бэлтгэл ажлыг хангах, хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд: - “Мод тарьж ургуулах арга, дэвшилтэт технологи”-ийн талаар ХААИС-д туршлага судалж тус сургуулийн захирал, аймгийн Засаг дарга нар хамтран хүний нөөц бэлтгэх талаар Санамж бичигт гарын үсэг зурсан /2022.03/. Энэ ажлын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2 хүнийг 2022 оноос эхлэн ХААИС-д “Ойн аж ахуйн инженер” мэргэжлээр бакалавр зэргээр | 100% / 90%<br><br>Шалгуур үзүүлэлт зорилтод түвшиндээ хүрээгүй. Зөв төлөвлөх. Үнэлгээг бууруулав. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургаж, амжилттай төгссөн.  - МСҮТөв 2022-2023 оны хичээлийн жилд 1 жилийн сургалттай Ойжуулалтын анги нээгдэж, 18 ойжуулагч бэлтгэн төгсгөсөн. - Жил бүр “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” аяны Нээлт болон “Тарьц суулгац”-ын үзэсгэлэн худалдааг Баруун-Урт суманд зохион байгуулан ажиллаж байна. "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн" хэрэгжсэнээс хойш буюу 2021-2024 онд аймгийн хэмжээнд 594 байгууллага, 20690 ажилтан, иргэн, 6080 өрх оролцож 830.115 ш мод сөөгийг тарьж, усалгаа, арчилгаа, хашаа хамгаалалтад 2.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. - Баруун Урт суманд УБ гарах зам дагуу 5 га-д 56,2 сая төгрөгөөр ойн зурвас байгуулах ажлыг Ойжуулалт Хайлааст ХХК гүйцэтгэж 4000 мод 80%-ийн ургалттай байна. - Баруун-Уртын голын татмын ойг хамгаалах 645 м хамгаалалтын хашааг Хүрэл соёмбо ХХК 45.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн  - Баруун-Урт сумын Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-т модны нүх ухагч тракторыг 100.0 сая төгрөгөөр нийлүүлсэн.  - Баруун-Урт суманд Наадан явах замд улсын төсвийн 112.5 төгрөгийн хөрөнгөөр 10 га газар ойн зурвас байгуулах ажлыг хашаа хамгаалалтын хамт 2023 оны 10 сард хийгээд байна. - 2024 онд АДАПТ төсөл 70%, ОНТ 30%-ийн санхүүжилтээр Дарьганга, Түмэнцогт, Наран сумдын нийт 5 байршилд 1.7 тэрбум төгрөгөөр 142 га буюу 112.600 мод тарьж, хашаажуулсан ба модны ургалт 75%-тай байна. | |
| 371 | | 9. Сум дундын болон сумын ойн ангийн | 2022 - 2024 | 0 | | | "2022 онд Сүхбаатар-Ойжуулалт"" Сум дундын ойн ангид БОАЖЯ-наас 8.0 сая төгрөгний төсөвт өртөг бүхий Хүлэмж болон | 100% / 100%<br><br>2023-2024 оны |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, мэргэжлийн боловсон хүчнийг чадавхжуулах | | | | | бороожуулагчийн дэмжлэг үзүүлсэн.  2023 онд Сум дундын ойн ангийн 4 ажилтан  2 удаагийн сургалтанд хамрагдсан. Үнд: 1. БОАЖЯ-наас зохион байгуулсан ""Мод тарих 1000 сургагч багш "" бэлтгэх сургалтанд  3 ажилтан хамрагдаж  сертафикат олгогдсон. 2.Цэцэрлэгч-сургагч багш"" бэлтгэх сургалтанд 4 хүн хамрагдаж сертафикат олгогдсон. 2024 онд Ойн газраас зохион байгуулсан Ой салбарын уулзалт сургалтанд Ойн анги болон мэргэжлийн байгууллагаас 8 хүн оролцсон. Мөн Ойн үрийн байнгын талбай тусгаарлах, арчлах аргачлалын сургалтанд Ойн ангийн 3 хүн хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн." | хүрэх түвшинг тодорхойлоогүй. |
| 372 | | 10. Баруун-Урт хотын 5-р тойргийн зам дагуух модыг хашиж хамгаалах ажлыг дуусгах | 2022 - 2024 | 6000 | | | БОАЖГ-ын санхүүжилтээр 45 сая төгрөгөөр “Баруун-Урт сумын 5-р тойрогт 6 км газарт ногоон байгууламжийн хамгаалалтын хашаа хийх ажил”-д "Хүрэл соёмбо" ХХК шалгарч 45 сая төгрөгөөр тус ажлыг хийж гүйцэтгэсэн. Хашаа хамгаалалтыг  БОАЖГ-ын даргын А/ 23 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Баруун-Урт сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн. Цаашид “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022-2030 онд тухайн суманд таригдах 735,7 мян.ш мод сөөг бүрэн хамгаалагдах боломжтой. | 100% / 100% |
| 373 | 5.1.3. Ховордсон биологийн төрөл зүйлийн нөөцийг хамгаалж, сэргээн | 1. Ургамлын нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж нөөцийг тогтоох | 2021 | 0 | БХНСАХЗ 22,0 сая төгрөг | | 2021 онд аймгийн хэмжээнд Ургамлын нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж нөөцийг тогтоолгох ажлын хүрээнд "Гарааны ногоон дэлийн чанар" ХХК тай 22,0 сая төгрөгийн гэрээ байгуулан хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлсэн. Судалгааны үр дүнд аймгийн хэмжээнд нийт 550 зүйл ургамал бүртгэснээс нэн ховор 7, | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нутагшуулна. | | | | | | ховор 27, эндемик 15, үлдэц 4, завсрын 33 зүйл ургамал бүртгэв. Эмийн ашигт ургамлын нөөц тогтоогдоогүй болно. Мөн ургамлыг цаашид хэрхэн хамгаалах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулагдан гарсан. Үүнтэй холбогдуулан жил бүр тодорхой ажлуудыг төлөвлөн ажиллаж байна. | |
| 374 | | 2. Нэн ховор, ховор, ашиглалтад өртөмтгий ургамлыг тарималжуулах, хамгаалах | 2022 - 2023 | 1 | | | Сүхбаатар аймгийн хэмжээнд ургамалжилтын судалгааг 2020 онд мэргэжлийн байгууллагаар хийлгэж зарим нэг зүйлийн эмийн Нэн ховор, ховор, ашиглалтад өртөмтгий ургамлыг тарималжуулах, хамгаалах зорилгоор судалгаанд үндэслэн Нарийн цахилдаг /Iris tenuifolia Pall/ ургамалыг сонгон авч 2023 онд хамгаалалтын хашааг татах ажлыг хийгээд байна. Дээрх ажлыг Асгат, Халзан сумын зааг нутагт 0,5 га газрыг сонгоод 300 м хамгаалалтын хашааг нь бүрэн хийж байрлуулахад бэлэн болгосон. Цаашид ургамлын үрээ түүх, үрээ боловсруулах,тарих ажлуудыг шат дараатай хийхээр төлөвлөөд байна. | 90% / 90% |
| 375 | | 3. Аймгийн хэмжээнд ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх | 2021 | 1 | БХНСАХЗ 14,1 сая | | Тендерт шалгарсан “Авралын эрэлд” ХХК-тай 14,1 сая төгрөгийн гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн. Судалгааны үр дүнд аймгийн хэмжээний нэн ховор болон ховор, элбэг амьтдын тархац нөөцийн судалгаатай болж цаашид хэрхэн хамгаалах, өсгөн үржүүлэх талаар менежментийн төлөвлөгөөний дагуу аймгийн хэмжээнд ахуйн зориулалтаар жилд 600 орчим Цагаан зээр агнах боломжит нөөцтэй гэж гарсан ба бусад амьтадын хувьд агнуурын нөөц тогтоогдоогүй байна. | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 376 | | 4. Халиун бугын Илий, Монгол тарвага сэргээн нутагшуулах /1 суманд 10 толгой халиун бугын илий, 5 суманд 100 толгой тарвага/ | 2022 - 2023 | 110 | | | 2021-2023 онд аймгийн хэмжээнд нийт 420 толгой Монгол тарвагыг Сүхбаатар, Түмэнцогт, эрдэнэцагаан, Дарьганга, Уулбаян, Халзан, Мөнххаан зэрэг сумдад Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал, орон нутгийн төсөв, Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт биологийн төрөл зүйлийг хамгаалах төслийн санхүүжилтээр сэргээн нутагшуулаад байна. 2024 онд  сэргээн нутагшуулсан болон нутгийн унаган Монгол тарваганы тархац, нөөцийг тогтоох нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас 15,0 сая төгрөгийг гаргаж “Авралын эрэл” ХХК-аар хамтран ажиллах гэрээг байгуулж судалгааг 9 дүгээр сард 100 хувь хийж гүйцэтгэсэн.<br>Судалгааны үр дүнд:<br>-  Аймгийн хэмжээнд судалгаагаар нийт  2733 орчим тарвагатай,  нийт нутаг дэвсгэрийн тарваганы тархацтай 10 сумын нийт 6899.2 га талбайд 2733 толгой тарваганы нөөцтэй нь тогтоогдсон. | 100% / 90%<br><br>1 суманд 10 толгой халиун бугын илий нутагшуулсан эсэх нь тодорхойгүй. |
| 377 | | 5. Зэрлэг амьтдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулж, биотехникийн арга хэмжээ авах | 2021 - 2024 | 3 | | 1 | "2021 онд Баяндэлгэр, Түвшинширээ, Сүхбаатар, Мөнххаан зэрэг сумдын нутагт байршиж байгаа Аргаль хонинд нийт 1.8 тн ногоон тэжээл, 1.5 тн хужир шүү мөн Эрдэнэцагаан сумын Лхачинвандад ууланд нутагшдаг Халиун буганд 3.5 тн хужир шүү тавьж өгсөн нийт 3.5 сая төг-ийг зарцуулсан байна.  2022 онд Дарьгангын Дунд нартын Аргаль хонинд 2 тн өвс, Эрдэнэцагаан сумын Лхачинвандадын байгалийн нөөц газарт нутагладаг Халиун бугад 10 тн хужир шүү тавьж өгөхөд 4.5 сая төг зарцуулсан. 2023 онд | 100% / 100%<br><br>Хэрэгжилтийн зарим хэсэг нь 5.1.3.4-тэй ижил тайлагнасан. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Баяндэлгэр сумын Дөхмийн Баян-Овоо, Улаан хад, Дарьганга сумын Баруун Нартын уул, Түвшинширээ сумын Малгарын уул зэрэг газарт байршидаг Аргаль хонинд өвөлжилт хүндэрч идэш тэжээлийн хомсдолд орсон тул дээрх байршлуудад нийт 500 боодол ногоон тэжээлийг байгаль хамгаалагчдынхаа тусламжтайгаар тавьж өглөө. Мөн Эрдэнэцагаан сумын Лхачинвандадын байгалийн нөөц газарт байршдаг Халиун буганд нутгийн иргэдтэй хамтран 5 тн хужир шүү тавьж өгч ажиллаа. Ингэснээр зэрлэг амьтны үхэл хорогдол тухайн газруудад гараагүй болно." | |
| 378 | | 6. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр нөхөрлөл байгуулах | 2022 - 2024 | 3 | | 1 | "Хуурай хээрийн тогтвортой ландшафт биологийн олон янз байдлыг хамгаалах олон улсын төсөл хэрэжиж байгаа Мөнххаан, Сүхбаатар сумын хил залгаа нутаг болох Баянцагааны талд тухайн экосистем, биологийн төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр шинээр нөхөрлөл байгуулан ажиллаж байна. | 100% / 70%<br><br>2024 оны хэрэгжилт тодорхойгүй, 2023 оны хэрэгжилтийг хуулбарлан тайлагнасан. Шалгуур үзүүлэлт зорилтод түвшиндээ хүрээгүй. |
| 379 | | 7. Байгаль хамгаалах үйл ажиллагаанд нөхөрлөлийн оролцоог нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 3 | | 4 | Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд Байгаль орчны чигэлэлээр үйл ажиллагаа явуулдаг "Түмэн барбарис" ахмадын нөхөрлөл, Дарьганга сумын Нарт нөхөрлөлд үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дэмжлэг үзүүлсэн. Ой хээрийн түймрээс урьдчидан сэргийлэх, нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламж нэмэгдүүлэх, байгаль орчны | 90% / 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чиглэлээр гарсан хууль тогтоомжийн талаар сургалт сурталчилгаа хийх, хууль бус ан агнуурын хяналт шалгалтыг зохион байгуулах, ховор ан амьтанд биотехникийн арга хэмжээ авах ажлуудыг зохион байгуулдаг. | |
| 380 | 5.1.4. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаална. | 1. Төвлөрсөн ундны усны хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх | 2021 - 2024 | 0 | | 20 | "Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 04 сарын 29-ны өдрийн 04 тоот тогтоолоор төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт ба хязгаарлалтын бүсийг нийт газар нутгийн 5,10 хувьд тогтоосон. Төвлөрсөн болон төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэр дээр нийт 10 сумын 40 удны усны эх үүсвэр дээр 96 ширхэг самбарыг байршуулаад байна. Үүнд БХНСАХЗ-аас 60 сая төг зарцуулсан " | 100% / 100% |
| 381 | | 2. Гидрогеологийн дунд масштабын зураглал хийлгэх | 2022 - 2024 | 0 | Улсын төсөв 550,0 сая төгрөг | | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу БОАЖЯамны хэрэгжүүлж буй "Усны нөөц, нуур, гол мөрний менежмент" төслийн хүрээнд "Дунар-од" ХХК Дорноговь аймгийн Дэлгэрэх сум, Сүхбаатар аймгийн Уулбаян, Баяндэлгэр, Асгат L-49-XVII XVIII XXII XXIII /бүтэн/, Халзан, Түвшинширээ, Онгон, Баруун-Урт сум L-49-XXVIII L-49-XXIX /хагас/ талбайг хамарсан Гидрогеологийн 1:200000 хураангуйлалтай зураглалын ажлыг хагас болон бүтэн нийт 6 хавтгайд явуулсан ба өрөмдлөг, шавхалт туршилт, гадаргуугийн геофизик, гедрогеологийн стуруктурын цооног, суурин боловсруулалтын ажлууд тус тус бүрэн хийгдсэн байна. | 100% / 100% |
| 382 | | 3. Усны сан бүхий газарт | 2022 - 2024 | 0 | | | Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж | 30% / 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөв цөөрөм, усны сан байгуулах | | | | | болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь төслөөс хийгдсэн судалгаагаар аймгийн хэмжээнд 23 цэг судлагдсанаар хөв цөөрөм байгуулахад тохиромжтой 9 байршил байна. Үүнд Эрдэнэцагаан суманд 5 байршил, Сүхбаатар суманд 1 байршил, Наран суманд 2 байршил, Түвшинширээ суманд 1 байршил байна. Хөв цөөрөм байгуулахад дунд зэргийн тохиромжтой Эрдэнэцагаан, Дарьганга, Сүхбаатар, Баяндэлгэр сумдад тус тус нэг байршил байна. 2024 онд АДАПТ төсөлтэй хамтран Хөв цөөрөм байгуулах зардлын оролцооны 30 хувийн санхүүжилтийг БХНСАХЗ - 32.0 сая төг-ийг тусгаж ИТХ-ын 2023 оны 07 дугаар тогтоолоор батлуулсан боловч АДАПТ төслөөс хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсөв хийгдээгүй учир уг ажлыг 2024 онд санхүүжүүлэх боломжгүй болсон тул аймгийн ИТХ-ын 2024 оны 04 сарын 29-ны өдрийн 01 тоот тогтоолоор төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолд хөв цөөрөм байгуулах зардлыг хассан. Иймээс 2025 онд БХНСАХЗардлаар Баяндэлгэр суманд 1 хөв цөөрөм байгуулахаар төлөвлөсөн. | |
| 383 | | 4. Гүн өрмийн худгуудад зөвшөөрөл олгож паспортжуулах ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | 40 | | 50 | Аймгийн хэмжээнд энгийн уурхай болон гүн өрмийн нийт 3318 худаг байдаг. 2023 онд худгийн зөвшөөрөл 15 олгогдож паспорт олгогдож баталгаажуулсан. 2024 онд уул уурхайн ундны усны зориулалтаар 2 худгийн зөвшөөрөл олгогдож, паспортжуулаад байна. Бэлчээр усжуулалтаар иргэдээс худгийн зөвшөөрөл ирээгүй байна. АДАПТ төсөл болон ХХААХҮЯ-аас бэлчээр усжуулах зориулалтаар 9 суманд 16 худаг гаргахаар тендерт "Эхний | 100% / 70%<br><br>Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах. Шалгуур үзүүлэлт зорилтод түвшиндээ хүрсэн эсэх нь тодорхойгүй. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эхэн", "Сатабу" ХХК-иуд шалгарсан байна. | Журмын 6.2.2.2 |
| 38 4 | | 5. Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | 50 | 95,9 сая төгрөг | 4 | "2021 онд нийт 9 суманд 9 булгийн эхийг хашиж хамгаалсан.Үүнд: -БХНСАХэмжээний зардлаас 20 сая төгрөгийн сахүүжилтээр Халзан - Баянбулаг, Онгон - Шарбүрд, Дарьганга - Салаа, Наран - Сөдөт, Мөнххаан - Цагаан булгуудын эхийг хашиж хамгаалж орон нутагт нь актаар хүлээлгэн өгсөн. -Хандив тусламжаар Түвшинширээ - Алтанбулаг /УИХ-ын гишүүн Ганибалын санаачилгаар/, Сүхбаатар - Гүнбулаг /Цайртминерал ХХК санхүүжилтээр 8,2 сая.төг/, Баяндэлгэр-Улаан хад /ОНХСангаас 2.8 сая.төг/ Түмэнцогт-Нүдэн / Газрын чимэг ХХК -3.0 сая.төг/ 14.0 сая.төг нийт 34.0 сая.төг-өөр булгийн эхийг хашиж хамгаалсан. 2023 онд Тогоон төмөр ХХК дараах булгийн эхийг хашиж хамгаалсан. Үүнд: Уулбаян сум – Хөөвөр Эрдэнэцагаан сум – Наран Халзан сум – Ар булаг Наран сум – Зүүн булаг /Тосонгийн гол баг/ Баяндэлгэр – Зүүн булаг Түвшинширээ сум – Сэвхүүл булгийн эхийг АДАПТ төслөөс 70 хувь, БХНСАХЗардалаас 30 хувийн санхүүжилтээр Мөнххаан сум -Батбулаг -5.0 сая.төг /ОНХС/ Түмэнцогт сум - Сэмүүний булаг - 2.8 сая.төг /ОНХС/ Түмэнцогт сум - Баян-Овоо булаг - 2.8 сая.төг /ОНХС/ Эрдэнэцагаан сум - Аман - Ус / Эрээнтолгой ХХК/ Эрдэнэцагаан сум - Бага бүлэг /Эрээн толгой ХХК/-ийн санхүүжилтээр тус тус хашиж хамгаалсан. 2024 онд Дарьгангын Байгалийн цогцолборт газрын Онцгой бүсэд харьяалагдах Наран сумын Өлзийт булгийн эхийг 1,4 км хашааг 267.0 сая.төг /ОНХС/-ийн санхүүжилтээр, Эрдэнэцагаан сум Бавхайт булаг – 5.0 сая.төг | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | /ОНХС/, Мөнххаан сум Хавцалын булаг – 7.5 сая.төг /ОНХС/, Мөнххаан сум Гурван худгийн булаг – 7.5 сая.төг /ОНХС/ тус тус хашиж хамгаалсан. Мөн АДАПТ төсөлтэй хамтран Асгат сумын 1-р багийн /Өлзийт баг/ Хадат булгийн эх, Онгон сумын 2-р багийн /Шар бүрд баг/ Шар бүрдний булгийн эх, Эрдэнэцагаан сумын 3-р багийн /Бадрах баг/ Хүйтэн булгийн эх, Уулбаян сумын 3 багийн /Тэгш баг/ Богд – Уулын булгийн эх, Халзан сумын 4 багийн /Хатавч/ Самын булгийн эхийг хашиж хамгаалах ажлын тендерт Гранд Авгуш ХХК шалгарч тус компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. " | |
| 385 | | 6. Дарьгангын байгалийн цогцолборт газарт байрлах нууруудын ууршилтын судалгаа хийх | 2022 | 0 | 12 | | Нууруудын ууршилт хэмжих багажийг Дайки Монголиа Индастри ХХК-тай гэрээ байгуулан ОХУ-аас ГГИ-3000 маркийн багажийг аваад байна. БХНСАХЗардалаас 12.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн. ГГИ-3000 ууршуур, бороо хэмжигч, яндуур /бюретка/, хэмжигч гуурснуудаас бүрдэх ба усан гадаргын ууршлыг хэмжихэд зориулагдсан. Ууршилтын багажтай болсноор Ганга нуурын ууршилтын дата мэдээллийг цуглуулан мэдээлэл судалгаанд ашиглах боломжтой болсон 2023 оны 5 сараас ашиглалтанд оруулж Ганга нуур, Дуут нуурын усны ууршилтыг хэмжиж эхэлсэн. | 100% / 100% |
| 386 | 5.1.5. Агаар орчны бохирдлын түвшнийг бууруулна. | 1. Агаарын чанарыг хэмждэг багаж тоног төхөөрөмжийн чадавхыг нэмэгдүүлж агаарт | 2023 | 0 | | | Агаарын чанарыг хэмждэг багаж тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж агаарын бохирдлын элементийн үзүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ЦУОШГазар БНСолонгос улстай хамтран аймгийн төвүүдийн агаарын чанарын харуулуудыг чадавхжуулж автомат суурин станц байгуулах судалгааны ажил хийгдэж байна. 2022 онд агаарын | 100% / 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | агуулагдаж буй 4-5 төрлийн элементийг хэмждэг болох | | | | | чанарын бохирдлын үзүүлэлтийг нэмэгдүүлэх, хүчин чадлыг сайжруулах ажлын хүрээнд тоосонцрын багажийг шинэчилж PM2.5, PM10 тоосонцрыг 24 цагийн дунджаар хэмжилт хийх багаж нэвтрүүлэн ажилласан. Баруун-Урт хотын агаарын чанарын бохирдлын элемент азотын давхар исэл (NO2), хүхрийн давхар исэл (SO2), тоосонцор (PM2.5, PM10) зэрэг 4 үзүүлэлтээр хэмжих боломжтой болсон байгаа. Энэ онд тоосонцрын багаж нөөцөнд шинээр ирээд байна. | |
| 387 | | 2. Аймгийн нийт айл өрхийн эко шийдлээр хийгдсэн нүхэн жорлонгийн тоог нэмэгдүүлэх | 2022 - 2023 | 0 | улсын төсвийн - 43.6 сая төгрөг Айл өрх, ААНБ-ын -116.4 сая төгрөг Нийт - 160,0 сая төгрөг | | " Аймгийн хэмжээнд нүхэн жорлонтой айл өрхийн тоог сумдаар нь гаргаж нийт 9000 орчим өрх, 120 ААНБ нүхэн жорлонтой, Усан сан бүхий газрын эргээс 200м, Ус хангамжийн эх үүсвэрийн 100м дотор нүхэн жорлонтой айл өрх 350, ААНБ-10 гэсэн судалгааг гаргаад байна. ""Хаягдал усыг дахин ашиглах шинэ дэвшилтэт техник технологи, нүхэн жорлонг хэрхэн энгийн хялбар аргаар цэвэрхэн, хямд өртгөөр эко болон био ариун цэврийн байгууламжтай болох, ногоон зээлд хэрхэн хамрагдах талаар МХГ, Баруун-Урт сумын ЗДТГ, Дөрвөлж ОНӨК, мах боловсруулах үйлдвэрүүд, цэвэр усны үйлдвэр, ШТС, авто угаалга, амралтын газрын 28 ААН-ын төлөөллүүдэд сургалт зохион байгуулсан. Сургалтад ШУТИС-ийн доктор Д.Басандорж, докторантур Г.Ариунаа, “Эколос Алтай” ХХК уриалгаар оролцлоо. Сургалтаар ААНБ-ууд хаягдал усыг цэвэрлэх болон ашиглах арга замууд, эко био жорлонгийн талаар мэдээлэл, БОГ –аас эко жорлон үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл танилцуулгыг БОГ даргын 101 тоот албан бичиг гарын авлага бэлтгэн 13 сумдад | 90% / 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
